

3. Одоогийн хатуу хог хаягдлын менежмент

3 Одоогийн хатуу хог хаягдлын менежмент

3.1 Одоогийн хог хаягдлын урсгал

Дараах судалгаануудын дүнг үндэслэн Улаанбаатар хотын 2006 оны хог хаягдлын урсгалын тухай энэхүү бүлэгт тайлбарлан оруулав (энэхүү тайлангийн 2 дугаар бүлгийг үзнэ үү):

- Хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгаа, 2005
- Эмнэлгийн хог хаягдлын менежментийн судалгаа, 2005
- Үйлдвэрийн хог хаягдлын менежментийн судалгаа, 2005
- Барилгын хог хаягдлын судалгаа, 2005 (хог хаягдлын гарах хэмжээг 2004 оны байдлаар хийв)
- Дарж булах хог хаягдлын хэмжээний тухай судалгаа, 2005 ба 2006

3.1.1 Өрхийн хог хаягдлын гарах хэмжээ

2005 оны Хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгааны дагуу 4.1 дүгээр бүлэгт дурьдсан тооцооны дагуу нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ болон эх үүсвэрийн (хүн ам) тоог тооцов. 2006 оны нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээг (GR) доорх хүснэгтэд тооцсон бөгөөд тооцоог дараах байдлаар хийв. Үүнд:

Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах дундаж хэмжээ, 2006 = ((Орон сууцны хорооллын GR, 2006 х Орон сууцны хүн ам, 2006) +

(Гэр хорооллын GR, 2006 х Гэр хорооллын хүн ам, 2006))/УБ хотын хүн ам, 2006

Дараах хүснэгтээр Улаанбаатар хотын өрхийн хог хаягдлын хэмжээг 2006 оны байдлаар үзүүлэв.

Хүснэгт 3-1: Өрхийн хог хаягдлын гарах хэмжээ (2006)

Гарах эх үүсвэр	Эх үүсвэрүүдийн тоо	Нэгж	Өвлийн улирал		Зуны улирал		
			Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ (гр/өдөр)	Өдөр тутам гарах нийт хэмжээ (тонн/өдөр)	Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ (гр/өдөр)	Өдөр тутам гарах нийт хэмжээ (тонн/өдөр)	
Өрхийн хог хаягдал	Орон сууцны	481,037	гр/хүн/өдөр	264	127.0	235	113.0
	Гэр хорооллын	409,772	гр/хүн/өдөр	956	391.8	208	85.2
	Дундаж	890,809	гр/хүн/өдөр	582	518.8	222	198.2

3.1.2 ААН-ийн хог хаягдлын гарах хэмжээ

ААН-ийн хог хаягдал ахуйн үйлчилгээ ба албан байгууллага, зах, сургууль, зочид буудал болон зам тайлбайн цэвэрлэгээний хог хаягдлаас бүрдэнэ. 2005 оны Хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгааны дагуу 4.1 дүгээр бүлэгт дурьдсан тооцооны дагуу нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ болон эх үүсвэрийн (ахуйн үйлчилгээ, албан байгууллага зэрэг) тоог тооцов. Өрхийн хог хаягдлаас бусад төрлийн хог хаягдал гаргадаг эх үүсвэрүүдийн нийт хог хаягдлын хэмжээг тодорхойлоход тухайн хог хаягдал гаргадаг төрөлд нэг хүнд ногдох хог хаягдлын гаргах хэмжээг тухайн төрлийн нийт эх үүсвэрүүдийн тоонд үржүүлж төрөл төрлөөр тооцож гаргасан дүнг хооронд нь нэмж нийт гарах хог хаягдлын хэмжээг тооцох ба дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3-2: ААН-ийн хог хаягдлын гарах хэмжээ (2006)

Хог хаягдал гаргах эх үүсвэр	Эх үүсвэрийн тоо	Нэгж	Өвлийн улирал		Зуны улирал	
			Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ (гр/өдөр)	Өдөрт гарах хог хаягдлын хэмжээ (тонн/өдөр)	Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ (гр/өдөр)	Өдөрт гарах хог хаягдлын хэмжээ (тонн/өдөр)
ААН-ийн хог хаягдал (ресторан)	44,112	гр/суудал/өдөр	258	11.4	278	12.3
ААН-ийн хог хаягдал (бусад дэлгүүр)	3,174	гр/дэлгүүр/өдөр	1,236	3.9	1,689	5.4
Байгууллагын хаягдал	111,172	гр/ажилтан/өдөр	134	14.9	185	20.6
Захын хаягдал	4,593	гр/лангуу/өдөр	876	4.0	1,772	8.1
Сургуулийн хаягдал	278,977	гр/оюутан/өдөр	3.1	0.9	1.5	0.4
Зочид буудлын хог хаягдал	12,139	гр/өрөө/өдөр	134	1.6	113	1.4
Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний хаягдал	3,430,451	гр/м ² /өдөр	3	10.3	5.1	17.5

3.1.3 Эмнэлгийн байгууллагуудаас гарах эмнэлгийн болон ерөнхий ахуйн хог хаягдал

Эмнэлгийн хог хаягдлын менежментийн тухай судалгааны хүрээнд цуглуулсан 2005 онд судалгааны бүсийн эмнэлгийн байгууллагуудаас гарах эмнэлгийн болон ерөнхий ахуйн хог хаягдлын хэмжээг даарх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3-3: Ерөнхий болон эмнэлгийн хог хаягдлын гарах хэмжээ, 2005

Хог хаягдлын ангилал	Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ (кг/ор/өдөр)	Орны тоо	Хог хаягдлын гарах хэмжээ (тонн/өдөр)
Эмнэлгийн хог хаягдал (аюултай/хортой)	0.207	7,721	1.6
Ерөнхий хог хаягдал	1.917	7,721	14.8

Дээрх дүнг үндэслэн судалгааны баг судалгааны бүсэд 2006 онд эмнэлгийн байгууллагуудаас гарах эмнэлгийн болон ерөнхий хог хаягдлын хэмжээг урьдчилан тооцов. Урьдчилан тооцоог хийхэд судалгааны баг дараах нөхцөл төлөвлөсөн. Үүнд:

- Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ өөрчлөгдөхгүй.
- Хүн амын өсөлтийг дагаж хог хаягдлын эх үүсвэрийн (орны тоо) тоо нэмэгдэх болно.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан 2006 оны эмнэлгийн болон ерөнхий хог хаягдлын хэмжээг дараах хүснэгтийн дагуу үзүүлэв.

Хүснэгт 3-4: Ерөнхий болон эмнэлгийн хог хаягдлын гарах хэмжээ, 2006

Хог хаягдлын ангилал	Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ (кг/ор/өдөр)	Орны тоо	Хог хаягдлын гарах хэмжээ (тонн/өдөр)
Эмнэлгийн хог хаягдал (аюултай/хортой)	0.207	7,937	1.6
Ерөнхий хог хаягдал	1.917	7,937	15.2

3.1.4 Үйлдвэрийн хог хаягдлын гарах хэмжээ

Үйлдвэрийн хог хаягдлын менежментийн талаар хийсэн судалгааны дагуу цуглуулсан 2005 оны үйлдвэрийн аюулгүй болон аюултай хог хаягдлын гарах хэмжээг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3-5: Үйлдвэрийн хог хаягдлын гарах хэмжээ (2005)

Үйлдвэрийн төрөл	Код	Үйлдвэрийн тоо*1 (тоо)	Ажилчдын тоо (хүн)	Аюулгүй үйлдвэрийн хог		Аюултай үйлдвэрийн хог	
				Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ*1 (кг/ажилчин/өдөр)	Нийт гарах хэмжээ (тонн/өдөр)	Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ (кг/ажилчин/өдөр)	Нийт гарах хэмжээ (тонн/өдөр)
Хүнс, сүүн бүтээгдэхүүн	G01	2,878	39,200	0.40	15.7	-	-
Савхи	G02	130	1,150	2.29	2.6	-	-
Даавуу	G03	122	8,650	0.36	3.1	-	-
Хими	G04	74	1,650	1.88	3.1	0.03	0.1
Цемент, тоосго	G05	77	4,700	0.86	4.0	-	-
Мах боловсруулах	G06	16	200	0.65	0.1	-	-
Тавилга	G07	157	2,350	0.86	2.0	-	-
Цаас боловсруулах	G08	153	1,700	0.86	1.5	-	-
Уул уурхай, металлурги	G09	251	16,100	0.86	13.8	-	-
Бусад	G10	663	21,400	0.86	18.4	-	-
Нийт		4,521	97,100	---	64.3	---	0.1

Дээрх дүнг үндэслэн судалгааны баг судалгааны бүсэд 2006 онд үйлдвэрийн газраас гарах үйлдвэрийн хог хаягдлын хэмжээг урьдчилан тооцов. Урьдчилан тооцоог хийхэд судалгааны баг дараах нөхцөл төлөвлөсөн. Үүнд:

- Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ өөрчлөгдөхгүй.
- Эдийн засгийн өсөлтийг дагаж хог хаягдлын эх үүсвэрийн (ажилтан) тоо нэмэгдэх болно.

Улмаар 2006 оны үйлдвэрийн хог хаягдлын гарах хэмжээг дараах байдлаар тооцов:

- Аюулгүй үйлдвэрийн хог хаягдал: 67.9 тонн/өдөр
- Аюултай үйлдвэрийн хог хаягдал: 0.1 тонн/өдөр (2.6 дугаар бүлэгт хийсэн дүгнэлтийн дагуу энэхүү хэмжээ нь нэлээд эргэлзээтэй тоо болно)

3.1.5 Барилгын хог хаягдлын гарах хэмжээ

Барилгын хог хаягдлын талаар хийсэн судалгааны дагуу цуглуулсан 2004 оны барилгын хог хаягдлын гарах хэмжээг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3-6: Барилгын хог хаягдлын гарах хэмжээ, 2004

	Орон сууц	Ахуйн үйлчилгээ	Эмнэлэг, сургууль, соёлын	Албан байгууллага, агуулах байгууламж	Эрчим хүм	Холбоо	Замын ажил	Далан, суваг	Бусад	Засварын ажил	Нийт
Төслийн хүрээ (сая төг)	36,333	7,152	4,510	3,743	6,896	412	1,853	3,387	3,456	3,635	71,377
Хаягдал гарах нэгж (тонн/1,000 төг)	1.4859 x 10 ⁻⁴	1.4859 x 10 ⁻⁴	1.4859 x 10 ⁻⁴	1.4859 x 10 ⁻⁴	14.0664 x 10 ⁻⁴	14.0664 x 10 ⁻⁴	4.13997 x 10 ⁻⁵	14.0664 x 10 ⁻⁴	13.3849 x 10 ⁻⁴	13.0805 x 10 ⁻⁴	---
Хог хаягдал гарах (тонн/жил)	5,398.7	1,062.7	670.1	556.2	9,700.2	579.5	76.7	4,764.3	4,625.9	2,667.3	30,101.6
Хог хаягдал гарах (тонн/өдөр)	14.8	2.9	1.8	1.5	26.6	1.6	0.2	13.1	12.7	7.3	82.5

УЧХЦ дээр суурьлуулсан автопүү болон бусад хогийн төвлөрсөн цэгүүдийн үйл ажиллагааны ажиглалтаас барилгын хог хаягдлын гарах хэмжээ зун ба өвөл гэсэн улирлын чанартай бөгөөд тэдгээр нь хоорондоо нэлээд зөрүүтэй байна. Дээрх хүснэгт

дээр үндэслэн судалгааны баг барилгын хог хаягдлын гэрэх хэмжээний улирлын өөрчлөлтийгн тооцоог хийхийн тулд дараах дараах урьдчилсан нөхцөл байдлыг харгалзав:

- Өвлийн улирал жилийн 10 дугаар сард эхэлж 3 дугаар сард дуусах бөгөөд зуны улирал 4 дүгээр сар эхэлж 9 дүгээр сард дуусна.
- Өвлийн улирлын барилгын ажлын хүнд нөхцөл байдлыг харгалзан зуны улирлын хог хаягдлын хэмжээ өвлийн улирлын хэмжээнээс хоёр дахин их гэж үзнэ. Захаас гарах хог хаягдлын онцлогтой нэлээд ижилхэн тул дээрх харьцааг ашигласан болно.

Улмаар 2004 оны хог хаягдлын гарах өдөр тутмын хэмжээг дараах байдлаар тодорхойлов:

- Жилийн турш өдөрт дунджаар гарах хог хаягдлын хэмжээ: 82.5 тонн/өдөр
- Өвлийн улиралд өдөрт гарах хэмжээ: $(82.5 \times 12 \times 0.33/6) = 54.5$ тонн/өдөр
- Зуны улиралд өдөрт гарах хэмжээ: $(82.5 \times 12 \times 0.67/6) = 110.6$ тонн/өдөр

Эдийн засгийн өсөлтийг дагаж жилийн хог хаягдлын гарах хэмжээ өснө гэж үзвэл 2006 оны хог хаягдлын гарах нэг өдрийн хэмжээг дараах байдлаар тооцов :

- Жилийн турш өдөрт дунджаар гарах хог хаягдлын хэмжээ: 91.8 тонн/өдөр
- Өвлийн улиралд өдөрт гарах хэмжээ: $(91.8 \times 12 \times 0.33/6) = 60.6$ тонн/өдөр
- Зуны улиралд өдөрт гарах хэмжээ: $(91.8 \times 12 \times 0.67/6) = 123.0$ тонн/өдөр

3.1.6 Хогийн төвлөрсөн цэг дээр дарж булах хог хаягдлын хэмжээ

Судалгааны бүсэд хотын 4 хогийн төвлөрсөн цэг байна. Судалгааны баг хогийн төвлөрсөн цэг дээр дарж булах хог хаягдлын хэмжээг тооцохын тулд юуны түрүүнд дараах судалгааг тэрхүү 4 цэг дээр хийв. Үүнд:

Хүснэгт 3-7: Хотын 4 ландфил дээр хийсэн хогийн төвлөрсөн цэг хог хаягдлыг дарж булах хэмжээний тухай судалгаа

Ландфил	Хийсэн судалгаа	Мэдээлэл цуглуулсан огноо
УЧХЦ	1. Хогийн цэг дээр ирэх хогны машины төрөл, тоо 2. Хувийн үйлдвэрийн автопүүн дээр хогны машины даацын хэмжээ, машины төрлөөр	1. Өвөл: 2003 оны 12-р сараас 2004 оны 1-р сар, Зун: 2004 оны 7-р сараас 2004 оны 8-р сар 2. 2005 оны 1-р сар
МДХЦ	3. Хогийн цэг дээр ирэх хогны машины тоо	3. 2004 оны 7 ба 8-р сар
НХЦ	4. Хогийн цэг дээр ирэх хогны машины тоо	4. 2003 оны 12 сар ба 2004 оны 7-р сар
Хороо 21	-	-

Дээр дурьдсан судалгаануудыг үндэслэн дараах хүснэгтэд холбогдох хогийн төвлөрсөн цэг дээр дарж булах хог хаягдлын хэмжээг тооцоов.

Хүснэгт 3-8: Холбогдох хогийн төвлөрсөн цэгүүд дээр дарж булах хог хаягдлын хэмжээ, 2004

Ландфил	Булах хэмжээ (тонн/өдөр)	Хогийн цэг бүрийн харьцаа (%)	Хогийн цэг бүрийн шинэчилсэн харьцаа (%)	Хогийн цэг бүр дээр ашиглах харьцаа (%)
УЧХЦ	260.1	91.8	91.1	91
МДХЦ	16.0	5.6	5.6	5
НХЦ	7.3	2.6	2.6	3
Хороо 21	NA	---	0.7 ^{*1}	1
Нийт	283.4	100.0	100.0	100

(Тайлбар) *1: Харьцааг хорооны хүн ам дээр үндэслэн тооцов.

УЧХЦ дээр автопүү суурилуулж 2005 оны 12 дугаар сарын 26-аас үйл ажиллагаа эхэлсэн. Автопүү ашиглаж УЧХЦ дээр булах хог хаягдлын хэмжээг нарийвчлан тогтоож өгч байгаа тул дээрх хүснэгтийг дараах хүснэгтийн дагуу булах хог хаягдлын хэмжээг шинэчлэв. Шинэчилсэн мэдээллийг автопүүний 2005 оны 12 дугаар сарын 26-аас 2006 оны 6 дугаар сарын 19-ний мэдээлэл үндэслэсэн болно.

Хүснэгт 3-9: Хогийн төвлөрсөн цэгүүд дээр булах хог хаягдлын хэмжээ, 2006 онд

Ландфилын нэр	Булах хэмжээ (тонн/өдөр)	Булах хэмжээ (тонн/өдөр)
	Өвөл	Зун
УЧХЦ	338.4	483.0
МДХЦ	18.5	26.1
НХЦ	11.3	16.1
Хороо 21	3.8	5.5
Нийт	372.0	530.7

3.1.7 Одоогийн хог хаягдлын урсгалыг тодорхойлох аргачлал ба нөхцлүүд

Дээр дурьдсан судалгаануудыг үндэслэн судалгааны бүсийн 2006 оны хог хаягдлын урсгалыг тодорхойлов. Одоогийн хог хаягдлын урсгалыг тодорхойлох аргачлал болон нөхцлүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв. Тэрхүү аргачлал болон нөхцлүүдийг илүү ойлгомжтой болгох зорилгоор судалгааны баг хог хаягдлын загвар урсгалыг боловсруулж дараах зургаар үзүүлэв.



Зураг 3-1: Одоогийн хог хаягдлын урсгалыг тодорхойлох загвар жишээ

Хүснэгт 3-10: Тохиргооны нөхцлүүд

Зүйл		Холбогдох судалгааны нэр	Тооцооны аргачлал, тохиргоо	Хэмжээ, 2006	
				Өвөл	Зун
(1-1)	Гарах хэмжээ	Хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгаа (Өвлийн улирал: 2004/12, Зуны улирал: 2005/07)	Хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгаа	Гарах: 565.8 тонн/өдөр	Гарах : 263.9 тонн/өдөр
(1-2)	Өрхийн хог (орон сууцны хороолол)		ны хүрээнд цуглуулсан (Нэг хүнд ногдох хог хаягдлын гарах хэмжээ) х (хүн ам, ААН-ийн тоо, цэвэрлэх хэмжээ)	Нийт гарах хэмжээ (нэг хүнд ногдох хэмжээ): 127.0 тонн/өдөр (264 гр/хүн/өдөр)	Нийт гарах хэмжээ (нэг хүнд ногдох хэмжээ): 113.0 тонн/өдөр (235 гр/хүн/өдөр)
(1-3)	Өрхийн хог (гэр хороолол)			Нийт гарах хэмжээ (нэг хүнд ногдох хэмжээ): 391.8 тонн/өдөр (ерөнхий хог 168 гр/хүн/өдөр, үнс 788 гр/хүн/өдөр)	Нийт гарах хэмжээ (нэг хүнд ногдох хэмжээ): 85.2 тонн/өдөр (ерөнхий хог 208 гр/хүн/өдөр)
(1-4)	ААН-ийн ү/а-наас гарах хог			Гарах : 36.7 тонн/өдөр	Гарах: 48.2 тонн/өдөр
(1-5)	Нийтийн эзэмшил газрын цэвэрлэгчээр гарах хог			Гарах: 10.3 тонн/өдөр	Гарах: 17.5 тонн/өдөр
(2-1)	Өөрөө устгах/ Хууль бусаар хаях	Олон нийтийн санал асуулга судалгаа (2005/02) болон Хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгааны талаарх санал асуулга (өвлийн улирал: 2004/12, зуны улирал: 2005/07)	Хог хаягдлыг өөрөө устгах/хууль бусаар хаях үйл явдал гэр хороололд болдог гэж үзвэл түүний хэмжээг дараах байдлаар тооцно $(2-1) = (1-1) - ((2-2) + (3-1))$	306.5 тонн/өдөр	20.2 тонн/өдөр
(2-2)	Хаях 1	---	$(2-2) = (2-3) + (3-2)$	257.2 тонн/өдөр	241.4 тонн/өдөр
(2-3)	Хаях 2	---	$(2-3) = (8) - ((4-1) - (4-2) + (5) + (6) + (7))$	252.3 тонн/өдөр	235.9 тонн/өдөр
(3-1)	Рисайкл буюу хог хаягдлыг дахин ашиглах 1	Олон нийтийн санал асуулга судалгаа (2005/02) ба Хоёрдогч түүхий эдийн зах зээлийн судалгаа (2005/02, 2005/08)	Рисайкл үйл ажиллагаа бүрийн гаргах хэмжээг олон нийтийн санал асуулга судалгаа ба хоёрдогч түүхий эдийн зах зээлийн судалгаан дээр үндэслэн цуглуулав.	Хэмжээ: 2.1 тонн/өдөр	Хэмжээ: 2.3 тонн/өдөр
(3-2)	Рисайкл үйл ажиллагаа			Хэмжээ : 4.9 тонн/өдөр	Хэмжээ: 5.5 тонн/өдөр
(3-3)	Рсайкл үйл ажиллагаа (ландфиллын цэг дээр)			Хэмжээ: 11.1 тонн/өдөр	Хэмжээ: 11.5 тонн/өдөр
(3-4)	Рисайкл 2	---	$(3-4) = (3-1) + (3-2) + (3-3)$	Total 18.1 тонн/өдөр	Нийт 19.3 тонн/өдөр
(4-1)	Барилгын хог	Барилгын хог хаягдлын тухай судалгаа (2005/08)	Барилгын хог хаягдлын судалгааны дагуу өдөрт гарах барилгын хог хаягдлын хэмжээг 2004 оны байдлаар 30,110 тонн/жил буюу өдөрт 82.5 тонн/өдөр байна гэж тооцов. ДНБ-ийн өсөлттэй зэрэгцэж 206 он гэхэд тэрхүү хэмжээ 91.8 тонн/өдөр хүрнэ гэж тооцно. Зуны улирлын хэмжээ хүйтэн өвлийн улирлын ажлын хүнд нөхцөлд байдлаас шалтгаалан хоёр дахин их байна гэж үзнэ. (Хог хаягдлын гарах хэмжээний харьцааг захын хог хаягдлын хэмжээ, хандлагатай ижилхэн захын хог хаягдлын тухай судалгаанаас авсан.)	60.6 тонн/өдөр (91.8 x 12 x 0.33 / 6)	123.0 тонн/өдөр (91.8 x 12 x 0.67 / 6)

(4-2)	Барилгын хог хаягдлыг хууль бусаар хаях		Барилгын хог хаягдлын судалгааны дагуу хууль бус хог хаягдлын хэмжээг 2004 оны байдлаар 36%-тай байна гэж тогтоов. Энэхүү харьцаа 2010 он гэхэд 0% хүртэл буурна.	14.5 тонн/өдөр	29.5 тонн/өдөр
(5)	Үйлдвэрийн хаягдал (ҮХ)	Үйлдвэрийн хог хаягдлын менежментийн судалгаа (2005/02 ба 2005/09)	Нэг ажилчинд ногдох хог хаягдлын гарах хэмжээ х ажилчдын тоо	Үйлдвэрийн аюулгүй хог хаягдал: 67.8 тонн/өдөр Үйлдвэрийн аюултай хог хаягдал: 0.1 тонн/өдөр (хог хаягдлын урсгалаас хасав)	
(6)	Эмнэлгийн хаягдал	Эмнэлгийн хог хаягдлын менежментийн судалгаа (2005/01)	Нэг оронд ногдох хог хаягдлын гарах хэмжээ х орны тоо	Ерөнхий хог хаягдал: 15.2 тонн/өдөр Эмнэлгийн хог хаягдал: 1.6 тонн/өдөр	
(7)	Хууль бус хог хаягдал цуглуулах	---	Өвлийн улиралд ачаагүй хог хаягдлыг зуны улиралд цуглуулдаг. Тэрхүү хэмжээг дараах томъёо ашиглан тооцов. $(7) = (8) - ((2-3) + (4-1) - (4-2) + (5) + (6))$	---	128.1 тонн/өдөр
(8)	Хогийн цэг дээр ирэх хэмжээ	Хогийн төвлөрсөн цэг дээр дарж булах хог хаягдлын хэмжээний тухай судалгаа буюу түүнд УЧХЦ-ийн автопүүний мэдээлэл, бусад хогийн цэг дээр ирэх машины тоо, зэрэг	Хогийн төвлөрсөн цэг дээр дарж булах хог хаягдлын хэмжээний тухай судалгаа дээр үндэслэв	383.1 тонн/өдөр	542.2 тонн/өдөр
(9)	Булах хэмжээ	---	$(9) = (8) - (3-3)$	372.0 тонн/өдөр	530.7 тонн/өдөр

3.1.8 Одоогийн хог хаягдлын урсгал

Дараах зургаар судалгааны бүсийн хог хаягдлын урсгалыг үзүүлэв.

а. Судалгааны нийт бүс



Зураг 3-2: Судалгааны бүсийн өвлийн улирлын хог хаягдлын урсгал (2006)



Зураг 3-3: Судалгааны бүсийн зуны улирлын хог хаягдлын урсгал (2006)

б. Төлөвлөгөөтэй бүс



Зураг 3-4: Төлөвлөгөөтэй бүсийн өвлийн улирлын хог хаягдлын урсгал (2006)



Зураг 3-5: Төлөвлөгөөтэй бүсийн зуны улирлын хог хаягдлын урсгал (2006)

с. Төлөвлөгдөөгүй бүсийн өвлийн улирал (2006)



Зураг 3-6: Төлөвлөгдөөгүй бүсийн өвлийн улирлын хог хаягдлын урсгал (2006)



Зураг 3-7: Төлөвлөгдөөгүй бүсийн зуны улирлын хог хаягдлын урсгал (2006)

3.1.9 Хог хаягдал замбараагүй тархах, хууль бусаар хог хаях явдал

а. Хог хаягдал замбараагүй тархах, хууль бусаар хог хаях явдлын өнөөгийн байдал

а.1 Төлөвлөгөөтэй бүс

Хог хаягдал ачиж цуглуулах үйлчилгээ болон нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээг одоогоор хангалттай түвшинд явуулж байгаа тул төлөвлөгөөтэй бүсийн хувьд харьцангуй цэвэр байдалтай байдаг боловч дараах газруудад хүндрэл бэрхшээл гарах нь ажиглагдана. Үүнд:

- a) Ахуй үйлчилгээний газруудын замын дагуу өглөө эрт хог хаягдал замбараагүй тархах явдал үзэгдэх бөгөөд тухайн өдрийн өглөө гудамж талбай цэвэрлэгч хог хаягдлыг шүүрдэж зайлуулдаг.
- b) Төлөвлөгөөтэй бүсийн, ялангуяа Чингэлтэй дүүргийн орон сууцны дунд байрлалтай нийтийн эзэмшлийн хогны контейнер савны дэргэд хог хаягдла ихэвчлэн задгай байдалтай тархсан байдаг. Тэрхүү байдлыг ихэвчлэн хог түүгч нар хаягдал түүхий эд цуглуулах зорилгоор замбараагүй тараах явдал гаргадаг байна.
- c) Нарны зам гэх мэт гол замын дагуу хаяа хогны овоолонгууд үзэгдэх бөгөөд тэрхүү байдал нь хууль бусаар хог хаяснаас үүдэлтэй юм.

a.2 Төлөвлөгдөөгүй бүс

Хог хаягдал замбараагүй тархах явдал тухайн газар байдлын онцлогоос хамаарах боловч ихэвчлэн хамгийн хүндрэлтэй газруудыг хоёр ангилж болон. Үүнд, гэр хорооллын гудамжны зам дагуух газар бөгөөд айлуудын ойролцоох гуу жалга, голын хөндий зэрэг болно.

Гэр хорооллын зам гудамжны дагуу хог хаягдлыг овоолж хаясан байдал ихээр ажиглагдах боловч хог замбараагүй тархах нь бага буюу, өөрөөр хэлбэл, тэдгээр хог хаягдал нь хууль бус, үнс ихтэй хог хаягдал байдаг бөгөөд ихэвчлэн ойр хавийн хашаа, айлууд гаргаж хаясан байж болзошгүй.

Гуу жалга, голын хөндийн зэрэг газруудыг ойролцоох хашаа, айлууд нийтийн хог хаях цэг болгож ашигладаг байна.

a.3 Бусад бүс

Аж үйлдвэрийн бүсийн задгай талбай, голын хөндий болон оршуулгын газар хог хаягдал ихээр хаясан байдал ажиглагдах бөгөөд зарим газар нь машинууд бараг байнга, өдөр болгон ирж хаяж байна.

b. Хууль бус хог хаягдлыг зайлуулах

Дүүргийн захиргааны зүгээс ТҮК-д хууль бус хог хаягдлыг зайлуулах арга хэмжээ авахыг хаяа шаарддаг бөгөөд ихэнх тохиолдолд тэдгээр ТҮК-д нь аливаа үнэ төлбөргүйгээр тухайн дүүргийн нутаг дэвсгэр дэх хууль бус хог хаягдлыг зайлуулдаг байна.

ТҮК-д 4 ба 9 дүгээр сард өөрсдөө санаачлан хууль бусаар хаясан хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж дүүргээс тодорхой хэмжээний төлбөр хийх асуудлыг тавих боловч ихэнх тохиолдолд дүүргээс тэдгээр ажилд төлбөр хийдэггүй байна.

Иргэд, оршин суугчид өөрсдийн санаачилгаар ойр орчныхоо нийтийн эзэмшил газрын хууль бус хог хаягдлыг цэвэрлэх ажил зохион байгуулдаг байна. Нийтийн цэвэрлэгээний ажлуудыг ихэвчлэн хавар цас хайлсаны дараа болон намар цас орохоос өмнө хийдэг байна.

ТББ-д иргэд оршин суугчидад урамшуулал олгож хууль бусаар хаясан хог хаягдлыг цэвэрлэх ажил зохион байгуулдаг бөгөөд судалгааны бүсийн нутаг зарим хорооны дэвсгэр дээр Дэлхийн зөн ТББ дээрх цэвэрлэгээний хөтөлбөр, арга хэмжээ авдаг байна.

3.2 Техникийн тогтолцоо

Дараах системийг 2005 оны 5 дугаар сарын байдлаар ажиглалт хийв.

3.2.1 Хог хаягдлыг хаях ба хадгалах

а. Хог хаягдлыг хаях ба хадгалах тухай журам заавар

2003 оны хог хаягдлын менежментийн тухай хуулийн дагуу тухайн байгууллага бүрийн үүрэг хариуцлагыг зааж өгсөн боловч хог хаях этгээдийн үүрэг хариуцлагыг зааж өгөөгүй байна. Хог хаягдлыг хэрхэн хаях болон хадгалах тухай хуулийн журам заавар байхгүй байна.

б. Хог хаягдлыг хаях ба хадгалах

б.1 Төлөвлөгөөтэй бүс

Төлөвлөгөөтэй бүсэд хог хаягдлыг хаях ба хадгалах дараах систем ашигладаг байна.

- а) Хогны бункер
- б) Нэг удаагийн сав (гялгар уут болон цаасан хайрцаг сав)
- с) Хадгалах өрөө
- д) Хадгалах орон зай
- е) Хадгалах байр
- ф) Хогийн задгай цэг
- г) Нийтийн контейнер

Дээрх системүүдийг дараах байдлаар тайлбарлав.

б.1.1. Нэг удаагийн сав (Гялгар уут эсвэл цаасан хайрцаг)-ийн систем

Ихэнх хог хаях этгээд нь хогоо гялгар уутанд хийж хогны бункер, хадгалах хонгил, байр, контейнер зэрэг газарт хаядаг буюу иргэд хогны тусгай уут дэлгүүрээс худалдан авч улмаар ашиглаж хогоо хийж хаядаггүй.

б.1.2. Хогны бункерийн систем

Улаанбаатар хотын олон барилга, орон сууцанд, ялангуяа харьцангуй хуучин байшингууд хогоо хаях хогны бункерийн системтэй. Энэхүү системийн хүрээнд орцны нэгээс хамгийн дээд давхар хүртэл босоо хоолой суурилуусан байдаг бөгөөд тэрхүү хоолой нь давхар болгондоо тусгай хаалттай нүхтэй. Оршин суугчид хаалтыг нээж хогоо хаяна. Хог нь нэг давхарт байрлах хонгилд унаж хогны машин ирж ачих хүртэл тэндээ хадгалагдана.

Энэхүү систем нь хог хаягдал гаргарч болон цуглуулагч хоюуланд нь тохиромжтой систем боловч хог дээр ялаа шавах зэрэг ариун цэврийн байдал маш муу байдгийн сацуу гал гарч утаа үүсэх нь хүндрэл учруулдаг байна.

б.1.3. Хадгалах өрөө

Хогны өрөө гэдэг нь орцны нэг давхрын шатны доор байрлах орцны хэсэг бөгөөд тэндээс нь ачигч нар хогны машинд хог татаж ачдаг байна. Энэхүү системийг хуучин байшингуудад ихэвчлэн ашигладаг боловч цэвэрлэж угаах нь хүндрэлтэй учир ариун цэврийн хувьд хүнд нөхцөл байдалтай. Түүнчлэн тэдгээр



өрөөнүүдийн хаалга нь жижиг байдаг тул ачихад нэлээд хүндрэлтэй байхын сацуу иргэдийн хамтын ажиллагаа огт байдаггүй байна.

b.1.4. Хог хадгалах байр

Оршин суугчид орон сууцныхаа гадаа байрлах хогны тусгай байранд хогоо гаргаж хаядаг байна. Хог ачигч нар тэрхүү байр, байгууламжаас нь хог ачдаг байна.



Энэхүү систем нь тухайн байр, орон сууцнаас зайдуу байрладаг тул орон сууцны ариун цэврийг сахихад чухал боловч тэрхүү байгууламжуудын хог ачих хаалга нь дэндүү жижиг тул ачихад хүндрэлтэй, иргэд, оршин суугчидын аливаа дэмжлэг хамтын ажиллагаа огт байдаггүй байна.

b.1.5. Хог хадгалах задгай цэг

Иргэд хогоо байрны гадаа, хогны түр цэг гэж тодорхойлсон газар хаядаг бөгөөд тэндээс нь хогийг ачдаг байна. Энэхүү систем нь хог хаягдал замбараагүй тархах байдлын эх үүсвэр болж улмаар байгаль орчин болон хүрээлэн буй орчны гаднах байдалд сөрөг нөлөө үзүүлэхийн сацуу иргэдийн ямар ч дэмжлэг, хамтын ажиллагаа байдаггүй тул ачиж цуглуулах ажил ч хүндрэлтэй байдаг байна.



b.1.6. Хогны контейнер сав

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дээр орон сууцны болон ахуйн бус хог хаягдал хадгалах зориулалтын 1м³-ийн багтаамжтай 150 хогны контейнер сав ашиглаж байна. Чингэлтэй дүүргийн ТҮК нь тэрхүү контейнер савыг ачихад зориулсан 20м³ багтаамжтай, өргөх төхөөрмжтэй хоёр нягтруулагч хогны машин ашиглаж байна.

Оршин суугчид дуртай үедээ хог гаргаж хаях нь тэдгээр хүмүүст тохиромжтой боловч дээрх контейнерийг ашиглахад дараах хүндрэл бэрхшээлтэй тулгараад байна.

а) Хогны савны ойролцоо хог хаягдал замбараагүй тархах. Замбараагүй тархах болсон гол шалтгаан:

- Нийтийн хогны савнуудыг хариуцах этгээд байхгүй тул хэн ч тэрхүү савнуудын арчилгаа үйлчилгээг хариуцахгүй байгаа.
- Хаягдал түүхий эд цуглуулж буй хог түүгч нар хог хаягдлыг замбараагүй тараадаг.



б) Өвлийн улиралд хог заримдаа хөлдөж хогны саванд наалдчихдаг тул ачигч нар төмөр труба ашиглан цохиж салгах шаардлага гардаг байна. Ингэж ажиллах нэлээд хүнд ажил бөгөөд цаг хугацаа шаардсан ажил болдог.

в) Орон гэргүй хүмүүс дулаацах зорилгоор хог шатаадаг улмаар шатсан контейнер сав зөндөө байна.

Дээрх байдлаас болж 150 ширхэг контейнерийн хоёрхон жилийн ашиглалтын дараа ихэнх нь, ялангуяа таглаа, дугуй нь эвдэрсэн байна.

b.1.7. Том контейнер (5-10 м³)

5 - 10 м³ багтаамжтай том хэмжээний контейнер сав ашиглаж орон сууцны хог хаягдал цуглуулах төдийгүй их хэмжээний хог хаягдал гаргадаг бизнесийн аж ахуйн нэгжүүдэд тавьж өгдөг байна.

Тухайн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тавьж өгсөн контейнер ашиглалт нь харуул хамгаалалт, арчилгаатай байдаг тул сайн байдаг боловч орон сууцны дунд байрлуулсан контейнер савны өмчийн эзэн нь тодорхойгүй тул ашиглалт нь таруухан байна. Контейнер савны орчим ариун цэврийн бус байдалтай, хог хаягдал замбараагүй тархсан, доторх хог нь байнга шатдаг явдал гардаг байна.



b.2 Төлөвлөгдөөгүй бүс

b.2.1. Шуудай

Төлөвлөгдөөгүй бүсийн оршин суугчидын гаргах нийт хог хаягдлын 90 гаруй хувь нь дулааны зорилгоор ашиглах нүүрсний үнс байдаг байна. Ихэнх айлууд үнсээ нүүрс худалдаж авсан шуудайн дотор хийж хашаандаа хадгалж байгаад хаядаг. Тэрхүү шуудай нь нэг удаагийн ашиглах зориулалтын материалаар хийсэн болон нэг шуудай үнсний жин ойролцоогоор 30 орчим кг байдаг тул үнстэй хог хаягдал хадгалах тун тохиромжтой гэж үзнэ.

b.2.2. Хоосон боошиг

200 литрийн багтаамжтай бүтэн эсвэл тал боошиг ашиглаж хог хаядаг. Тал боошигонд хийсэн үнсийг зөөхөд боломжтой бол боошиг дүүрэн үнсэн хог хаягдлыг зөөх, ачих ажил нь нэлээд хүндрэлтэй болдог. Иймд 200 литрийн боошиг нь дэндүү том тул ашиглах нь тохиромжгүй юм.

3.2.2 Хог хаягдлыг цуглуулах ба тээвэрлэх

а. Цуглуулах систем

а.1 Төлөвлөгөөтэй бүс

Цуглуулах аргачлал

Хог хаягдлыг ачиж цуглуулах ажилд оролцох иргэд, оршин суугчидын хамтын ажиллагааны хувьд хог хаягдал цуглуулах ажлыг хоёр төрлөөр ангилж болно.

Орон сууцны хорооллын зарим нутаг дэвсгэр дээр хог хаягдлыг дуудлагаар цуглуулах үйлчилгээний хэлбэрийг ашиглаж байна. Оршин суугчид орцондоо хогоо гаргаж хаях бөгөөд СӨХ-өөс ажиллуулж буй орцны жижүүр орцны тодорхой нэг газар цуглуулж байгаад хогны машин ирж сигналдах тохиолдолд орцны жижүүр, цэвэрлэгч болон оршин суугчид машинд хогоо зөөж аваачиж өгдөг байна. Энэхүү систем нь хүрээлэн буй амьдрах орчныг цэвэрхэн байлгах, хүмүүсийг гарч иртэл бага зэрэг хүлээх шаардлагатай боловч хог ачих ажлыг хөнгөвчлөх сайн талуудтай. Иргэд, оршин суугчидын хамтын ажиллагаа өндөр түвшинд байхын зэрэгцээ энэхүү систем нь сайн ажиллаж байна.

Нөгөө систем нь хогны машины ачигч нар хог хадгалах түр цэг буюу аливаа тусгай өрөө, байр, задгай цэг, хогны бункер зэрэг газруудаас хог хаягдал цуглуулна. Энэхүү систем нь одоогоор хотын хэмжээнд нэлээд өргөн хүрээнд ашиглагдаж байгаа систем бөгөөд иргэд оршин суугчидын хамтын ажиллагаа, тэдгээрийн оролцоо байхгүй болон ашиглахад хүндрэлтэй байр савнаас хог ачих зэрэг нь явдал нь хог ачиж цуглуулах ажлыг нэлээд хүндрүүлдэг. Энэхүү системийн хүрээнд оршин суугч огт хамтран

ажилдаггүй тул хогны машин хогоо хэзээ ч, орой ч, бүр шөнө ч ачих явдал гардаг байна.

Хогны машины баг нь жолооч болон нэг, хоёр ачигч нараас бүрддэг. Судалгааны бүсэд ажиллаж буй хог ачих ачигч нарын тоо дэндүү цөөн боловч нийтлэг үзэгдэл бөгөөд тэрхүү байдал нь одоогор мөрдөж буй түрээсийн гэрээ нь ачигч нарын тоог аль болох цөөн байлгах сонирхолыг төрүүлж байна.

Хог хаягдлыг ачиж цуглуулах үйлчилгээний давтамж

Одоогийн мөрдөж буй хог хаягдал цуглуулах системийн хүрээнд хог хаягдал гаргагч нь хэзээ ч хогоо хаях боломжтой тул тэр нь цуглуулах давтамжийн талаар мэдэхгүйн сацуу хэд байх талаар ч санаа зовдоггүй.

Ер нь бол хог хаягдлыг долоо хоногт 3 удаа, хогны бункерийн хогийг 1 удаа тус тус ачих ёстой байдаг боловч хогны бункерийн хог хаягдлыг хугацаанд нь ачихгүй, заримдаа сард ч нэг удаа ачих тохиолдол гардаг байна. Хогны бункер нь том хэмжээтэй байдаг болохоор энэхүү удаан хугацаанд байлгадаг боловч арин цэвэр, эрүүл ахуйн асуудлын хүндрүүлж бий болгодог.

Ачиж цуглуулах систем

Нийт хог хаягдлыг хамт буюу ялгаж ангилахгүйгээр цуглуулдаг. Заримдаа ачигч нар хог ачих ажлын явцад хаягдал түүхий эд дараа нь худалдах зорилгоор цуглуулдаг боловч тэр ихэвчлэн үе үе хийх, тохиолдолын чанартай юм байна.

Хог хаягдал ачиж цуглуулах хуваарь

Таруухан менежмент, техникийн бүрэн бус байдал зэрэг байдлаас шалтгаалан хог хаягдлыг цуглуулах тогтсон цагийн хуваарь байдаггүй. Түүнчлэн маршрут нь тогтсон байдаггүй бөгөөд жолооч нь хэзээ ч өөрийн дураар өөрчлөх боломжтой.

Хог хаягдал цуглуулах болон тээвэрлэх төхөөрөмж

Олон төрлийн машин төхөөрөмж ашиглах боловч ихэвчлэн компактор төрлийн битүү машин ашигладаг байна. Тэрхүү машинуудыг үйлдвэрлэсэн улсаар нь гурван төрөлд хуваана.

ОХУ-д үйлдвэрлэсэн М53 маркийн хогны машин байна. Тэрхүү төрлийн машин нь маш хуучирсан, 20 гаруй жил ашиглагдаж байна. Энэхүү машин нь гадна талаасаа компактор буюу хог хаягдал нягтруулж ачдаг машин шиг харагдах боловч нягтруулагч нь огт ажилдаггүй, тэвшний арын төхөөрөмж нь зөвхөн хог ачиж оруулах зориулалттай тул энэхүү маркийн машин нь компактор машинаас хамаагүй бага хэмжээний, нэг удаагийн рейсээр зөвхөн 1.5 орчим тонн хог хаягдал тээвэрлэдэг.

ОХУ-д үйлдвэрлэсэн КО-440 маркийн нягтруулагчтай компактор төрлийн хоёр машин нь 7.0 м³ багтаамжтай, 2.4 дахин нягтруулах хүчин чадалтай. Энэхүү машин 0.7 м³ багтаамж бүхий тусгай контейнер савтай, өргөх төхөөрөмжтэй боловч савны ам жижиг, байрлал нь дэндүү өндөр тул хог хаягдал хийх нь хүндрэлтэй байдаг.

2002 онд Хятад улсаас хандивласан хоёр компактор машин байна. Машины даац нь 12.2 тонн, багтаамж нь 21 м³ бөгөөд өргөх контейнер савны хэмжээ нь 1 м³ багтаамжтай. Энэ хоёр машиныг Чингэлтэй дүүрэг дээр ашигладаг боловч тухайн нутаг дэвсгэрт дэндүү томдож байгаа болно.

Судалгааны бүсэд одоогоор Японы улсад үйлдвэрлэсэн хуучин компактор машинуудыг мөн ашиглаж байна. Тэдгээр нь 4-8м³ багтаамжтай бөгөөд хогийг 1.5-2 удаа нягтруулах хүчин чадалтай. Сүүлийн үед худалдан авч буй машинууд нь иймэрхүү төрлийн машинууд бөгөөд автопаркийн олонхийг бүрдүүлэх болж байна.

Хятадад үйлдвэрлсэн дизель хөдөлгүүртэй дээрх хоёр машинаас бусад нь бензин ашигладаг.

Нэг өдөрт хийх дундаж рейсийн тоо

Өдөрт гурван удаа рейс хийдэг СБД-ээс бусад ТҮК нь хэдий орой болсон ч үл харгалзан өдөрт хоёр удаа рейс хийдэг.

Тээвэрлэх систем

Хог хаягдлыг замдаа шилжүүлэн ачихгүйгээр хогны машинууд шууд хогийн төвлөрсөн цэг дээр тээвэрлэн буулгадаг.

а.2 Төлөвлөгдөөгүй бүс

Цуглуулах аргачлал

Төлөвлөгдөөгүй бүсийн хог хаягдлыг ачиж цуглуулах ажил хогны төлбөр хураах ажилтай хамт хэрэгждэг. Хогны төлбөр хураах байцагч хог ачигч нартай хамт явж ажилладаг бөгөөд ачигч нар төлбөр төлсөн айлын хогийг ачдаг байна.

Гэр хорооллын хог хаягдлын бүтцийг аваад үзвэл өвлийн улиралд 90 гаруй хувь нь үнс байдаг бөгөөд зуны улиралд ихэнх хог хаягдал нь өвс мод шороо байдаг тул жилийн турш гэр хорооллоос хүнд жинтэй хог хаягдал гардаг байна.

Хог хагдлыг ачихад оршин суугчид хогны машин дээр зөөж ачих үүрэгтэй байдаг тул иргэдийн хамтын ажиллагаа сайн байдаг.

Ихэвчлэн хогны машинд жолооч, байцаагч, нэг эсвэл хоёр ачигч байдаг. Шаарлагатай болон ажлын ачааллаас хамаарч нэг ажилтан нэмж ажиллах тохиолдол байдаг байна.

Хог хаягдлыг ачих давтамж

Давтамж нь ихэвчлэн сард нэг удаа байдаг бөгөөд тэрхүү байдал нь хогны төлбөр сард нэг удаа хураадагтай холбоотой. Гэсэн хэдий ч энэхүү хугацаа сунжирч заримдаа 45 хоног болох тохиолдол ч гардаг байна. Оршин суугчид одоогийн хог хаягдал цуглуулах давтамжийг дэндүү бага, нэг удаа мэдэлгүй өнгөрөөчих тохиолдолд дараа нь бүтэн сар хүлээх шаардлагатай болдог байна.

Цуглуулах систем

Нийт хог хаягдлыг ялгалгүйгээр хамтад нь цуглуулдаг бөгөөд гэр хорооллын хог хаягдлаас дахин ашиглах боломжтой хог хаягдал бараг гардаггүй тул ачигч нар бараг хаягдал түүхий эд цуглуулдаггүй байна.

Хог хаягдлыг цуглуулах хуваарь

Таруухан менежмент, техникийн бүрэн бус байдал зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан хог хаягдлыг цуглуулах тогтсон цагийн хуваарь байдаггүй. Түүнчлэн маршрут нь тогтсон байдаггүй бөгөөд жолооч нь хэзээ ч өөрийн дураар өөрчлөх боломжтой

Хог хаягдал цуглуулах болон тээвэрлэх төхөөрөмж

Ихэнх хогны машинууд нь 6 тонн даацтай, бензин түлшээр ажилладаг самосвал машинууд. Энэ төрлийн самосвал машин нь Улаанбаатар хотод нэлээд түгээмэл бөгөөд жолооч нарт ч гарын доор засаж сэлбэх боломжтой машин юм.

Самосвал машин өргөх төхөөрөмжгүй байдаг тул хүнд жинтэй хог хаягдлыг ачихад нэлээд хүндрэлтэй. Ихэвчлэн нэг ачигч машин дээр зогсож хог хүлээж авч ачих, нөгөө нь оршин суугчидын дэмжлэгтэйгээр доороос нь өргөж өгдөг байна. Хог хаягдлын ихэнх нь үнс байдаг тул ачих явцад тоос шороо ихээр босч бужигнадаг байна. Залуу настай, эмэгтэй хүн ч хогоо гаргаж ачиж өгөхөд тусалдаг байдал нь хог цуглуулах

ажилд иргэд, оршин суугчидын оролцоо, хамтын ажиллагаа маш өндөр түвшинд байна гэж үзнэ.

Нэг өдөрт хийх дундаж рейсийн тоо

Өдөрт гурван удаа рейс хийдэг СБД-ээс бусад ТҮК нь хэдий орой болсон ч үл харгалзан өдөрт хоёр удаа рейс хийдэг.

Тээвэрлэх систем

Хог хаягдлыг замдаа шилжүүлэн ачихгүйгээр хогны машинууд шууд хогийн төвлөрсөн цэг дээр тээвэрлэн буулгадаг.

а.3 Хог хаягдал цуглуулах хувь хэмжээ ба үйлчилгээ үзүүлэх нутаг дэвсгэр

а.3.1. Хог хаягдал цуглуулах ажлыг гүйцэтгэгч байгууллагууд, хороо болгоноор

Хүснэгт 3-11 -аар хороо болгоноор хог хаягдал цуглуулах үйлчилгээний өнөөгийн байдлыг үзүүлэв. Өвлийн улиралд ТҮК нь нийт 97 хороо, хорооны ЗДТГ нь 18 хороо болон СХД-ийн 1 дүгээр хорооны хог хаягдлыг хувийн компани тус тус ачиж цуглуулж байна. Хог хаягдал цуглуулах үйлчилгээ авдаггүй хороо байхгүй.

Хүснэгт 3-11: Цуглуулах үйлчилгээний байдал

ДҮҮРЭГ	Хорооны №	Төрөл	Хүн ам	Өвөл				Зун			
				ТҮК	Хороо	Хувийн	Үйлчилгээгүй	ТҮК	Хороо	Хувийн	Үйлчилгээгүй
Баянгол	1	Орон сууц	8,561	•				•			
	2	Орон сууц	5,437	•				•			
	3	Орон сууц	8,872	•				•			
	4	Орон сууц	10,596	•				•			
	5	Орон сууц	7,390	•				•			
	6	Орон сууц	9,047	•				•			
	7	Орон сууц	7,913	•				•			
	8	Орон сууц	7,447	•				•			
	9	Гэр	10,469		•				•		
	10	Гэр	9,714	•				•			
	11	Гэр	9,807	•				•			
	12	Орон сууц	10,649	•				•			
	13	Орон сууц	6,125	•				•			
	14	Орон сууц	5,902	•				•			
	15	Орон сууц	5,735	•				•			
	16	Гэр	5,853	•				•			
	17	Орон сууц	5,581	•				•			
	18	Орон сууц	8,568	•				•			
	19	Орон сууц	7,112	•				•			
	20	Орон сууц	2,784	•				•			
	Р _т		153,562	19	1	0	0	19	1	0	0
Баянзүрх	1	Орон сууц	5,765	•				•			
	2	Гэр	22,963	•				•			
	3	Орон сууц	4,909	•				•			
	4	Орон сууц	9,250	•				•			
	5	Орон сууц	11,684	•				•			
	6	Орон сууц	7,801	•				•			
	7	Орон сууц	8,024	•				•			
	8	Гэр	9,746	•				•			
	9	Гэр	8,297	•				•			
	10	Гэр	10,860	•				•			
	11	Гэр	3,459	•				•			
	12	Гэр	8,957	•				•			
	13	Гэр	7,462	•				•			
	14	Гэр	6,657	•				•			
	15	Орон сууц	5,253	•				•			
	16	Орон сууц	11,401	•				•			
	17	Гэр	8,260	•				•			
	18	Орон сууц	7,924	•				•			
	19	Гэр	8,954	•				•			
	20	Гэр	5,198	•		•			•		
	Р _т		172,824	19	1	0	0	19	1	0	0
Налайх	1	Гэр	5,807	•				•			
	2	Орон сууц	6,820	•				•			
	3	Гэр	4,120	•				•			
	4	Гэр	4,453	•				•			
	5	Гэр	2,500	•				•			
	6	Гэр	987	•				•			
	Р _т		24,687	6	0	0	0	6	0	0	0

ДҮҮРЭГ	Хорооны №	Төрөл	Хүн ам	Өвөл				Зун			
				ТҮК	Хороо	Хувийн	Үйлчилг ээгүй	ТҮК	Хороо	Хувийн	Үйлчилг ээгүй
Сонгино хайрхан	1	Гэр	12,785			•					
	2	Гэр	4,649	•				•			
	3	Гэр	9,389	•				•			
	4	Гэр	8,160	•				•			
	5	Гэр	9,629	•				•			
	6	Гэр	13,100	•				•			
	7	Гэр	11,179	•				•			
	8	Гэр	6,964	•				•			
	9	Гэр	11,815	•				•			
	10	Гэр	10,201	•				•			
	11	Гэр	12,552	•				•			
	12	Орон сууц	6,305	•				•			
	13	Орон сууц	6,938	•				•			
	14	Орон сууц	7,023	•				•			
	15	Орон сууц	6,864	•				•			
	16	Орон сууц	6,694	•				•			
	17	Гэр	7,204	•				•			
	18		9,237	•				•			
	19		9,527	•				•			
	20		7,876	•				•			
	21	Гэр	4,062	•				•			
Р _т		182,153	20	0	1	0	20	0	1	0	
Сүхбаатар	1		3,329	•				•			
	2	Орон сууц	5,262	•				•			
	3	Орон сууц	5,419	•				•			
	4	Орон сууц	3,786	•				•			
	5	Орон сууц	4,744	•				•			
	6	Орон сууц	4,624	•				•			
	7	Орон сууц	7,054	•				•			
	8	Орон сууц	9,037	•				•			
	9	Орон сууц	9,360		•				•		
	10	Орон сууц	7,429	•				•			
	11	Гэр	9,658		•				•		
	12	Гэр	5,910		•				•		
	13	Гэр	6,458		•				•		
	14	Гэр	5,167		•				•		
	15	Гэр	9,672		•				•		
	16	Гэр	9,258		•				•		
Р _т		106,167	9	7	0	0	9	7	0	0	
Чингэлтэй	1	Орон сууц	4,561	•				•			
	2	Орон сууц	3,700	•				•			
	3	Орон сууц	4,587	•				•			
	4	Орон сууц	5,005	•				•			
	5	Орон сууц	4,782	•				•			
	6	Орон сууц	5,381	•				•			
	7	Гэр	8,900		•				•		
	8	Гэр	5,588		•				•		
	9	Гэр	6,666	•				•			
	10	Гэр	6,404	•				•			
	11	Гэр	6,300	•				•			
	12	Гэр	9,167	•				•			
	13	Гэр	7,314	•				•			
	14	Гэр	7,136	•				•			
	15	Гэр	8,065		•				•		
	16	Гэр	8,645		•				•		
	17	Гэр	8,400		•				•		
	18	Гэр	11,882	•				•			
	19										
Р _т		122,483	14	5	0	0	14	5	0	0	
Хан-Уул	1	Орон сууц	7,605	•				•			
	2	Орон сууц	7,630	•				•			
	3	Орон сууц	6,795	•				•			
	4	Гэр	5,803	•				•			
	5	Гэр	5,709	•				•			
	6	Гэр	6,655	•				•			
	7	Гэр	5,023	•				•			
	8	Гэр	7,541	•				•			
	9	Гэр	10,251	•				•			
	10	Гэр	4,990	•				•			
	11	Гэр	4,030		•				•		
	12	Гэр	4,719		•				•		
	13	Гэр	2,778		•				•		
	14	Гэр	1,611		•				•		
Р _т		81,140	10	4	0	0	10	4	0	0	
Нийт	ш	-	-	97	18	1	0	97	18	1	0
	%			83.6%	15.5%	0.9%	83.6%	15.5%	0.9%		

Дээрх хүснэгтийн дагуу хог хаягдал цуглуулах үйлчилгээний хувь хэмжээ нутаг дэвсгэрээр нь аваад үзвэл өндөр гарч байгаа боловч хогны төлбөрөө төлөх өрхүүдэд хог хаягдлыг ачиж цуглуулах үйлчилгээ үзүүлдэг тул хүн амын хувьд цуглуулах үйлчилгээний хувь хэмжээ доогуур үзүүлэлттэй гарч байна. Үйлчилгээ үзүүлж буй хүн

амыг нь аваад үзвэл төлөвлөгөөтэй бүсэд хог хаягдал цуглуулах үйлчилгээг 100%, төлөвлөгдөөгүй бүсэд 50 орчим хувьтай үзүүлж байна.

ТҮК нь судалгааны бүсийн нийт хорооны 83.6%, хорооны ЗДТГ нь 15.5%-ийг хамарч үйлчилгээ үзүүлж байна.

Тухайн хороо нь өөрсдөө хогоо ачиж цуглуулдаг тохиолдолд засаг дарга нь хогны төлбөрийг хэсгийн ахлагч эсвэл олон нийтийн байцагч ажиллуулан хурааж ачих өдөр хогны машин, жолооч, ачигчийн хамт хөлсөлдөг байна. Тухайн дүүргийн ТҮК-ийн хүчин чадал хангалтгүй байх тохиолдолд зарим хороо нь өөрсдөө хогоо цуглуулдаг байна. Иймд хог хаягдал ачиж цуглуулах үйлчилгээг үзүүлэхэд санхүүгийн хувьд хүндрэлтэй хороонд ТҮК хогийг нь ачих сонирхолгүй байдаг байна. Өөрсдөө хогоо ачдаг хороо нь ихэвчлэн төлөвлөгдөөгүй бүсэд байдаг бөгөөд хогны төлбөр хураах хувь хэмжээ нь төлөвлөгөөтэй бүстэй харьцуулахад нэлээд доогуур байдаг байна.


Зөвхөн Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороонд хувийн компани, БТЖ, хог хаягдлыг ачиж цуглуулах болон хогны төлбөрийг хураах ажлыг 2005 оны 1 дүгээр сараас гүйцэтгэдэг болосн боловч үр дүн одоогоор тийм ч хангалттай бус байна.

а.3.2. ТҮК-иас гадна хог хаягдал цуглуулах үйлчилгээ

Хог хаягдлыг цуглуулах ажлын өнөөгийн байдлын талаар ТҮК-иас гадна, хогоо өөрсдөө ачдаг 19-ийн хорооны ЗДТГ-аас ярилцаж саналыг нь авсан. Судалгааны дүнг дараах хүснэгтэд хурангуйлан оруулав.

Хүснэгт 3-12: ТҮК-иас гадна хог хаягдал цуглуулах үйлчилгээ үзүүлэх газруудын судалгааны хураангуй


Зүйл	Ололтууд																
1. Ерөнхий мэдээлэл																	
Судалгаанд хамрагдсан хорооны тоо	19 хороо																
Хэсгүүдийн тоо	Нийт: 205 хэсэг, Дундаж: нэг хороонд 10.8 хэсэг ногдох																
Нийт өрхийн тоо	Нийт: 29,113 өрх, Дундаж: нэг хороонд 1,532 өрх ногдох																
Хорооны ЗДТГ-ын ажилтан нарын тоо	15 хороонд 3 ажилтан, 2 хороонд 4 ажилтан, 2 хороонд 9 ажилтан (ХУД-ийн 13-р хороо, БЗД-ийн 20-р хороо) тус тус байна																
Компьютер ашиглалт	18 хороо компьютертэй, 1 хороо байхгүй.																
2. Хог цуглуулах систем																	
Давтамж	Сард нэг удаа: 63% Тогтмол бус: 21%																
Өдөрт хийх рейсийн тоо	өдөрт 2-3 удаа																
Машин төхөөрөмж	2 хороо өөрсдийн өмчийн машинаа ашигладаг. 17 хороо машин хөлсөлдөг.																
Хогийн төвлөрсөн цэг	<ul style="list-style-type: none"> ■ Улаанчулуут: 14 хороо (гэхдээ Улаанчулуутын хогийн цэг рүү тээвэрлэж буйг хэн ч шалгадаггүй.) ■ Улаанчулуутаас бусад: Хан-Уул дүүргийн 11, 12, 13, 14 ба Баянзүрх дүүргийн 20-р хороо 																
Гэрээний тогтолцоо	Гэрээ хийдэггүй: 7 хороо Хорооны ЗДТГ болон жолоочийн хооронд байгуулах гэрээ: 5 хороо Бусад болон хариулагүй: 7 хороо																
3. Төлбөрийн хураамж																	
Хураах төлбөр	<p style="text-align: center;">Хогны төлбөр</p> <table border="1"> <caption>Хогны төлбөрийн хэмжээ</caption> <thead> <tr> <th>Хогны төлбөр (төг/сард)</th> <th>Хороодын тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>500</td> <td>3</td> </tr> <tr> <td>800</td> <td>1</td> </tr> <tr> <td>700</td> <td>1</td> </tr> <tr> <td>1000</td> <td>5</td> </tr> <tr> <td>1500</td> <td>6</td> </tr> <tr> <td>2000</td> <td>3</td> </tr> <tr> <td>2500</td> <td>3</td> </tr> </tbody> </table>	Хогны төлбөр (төг/сард)	Хороодын тоо	500	3	800	1	700	1	1000	5	1500	6	2000	3	2500	3
Хогны төлбөр (төг/сард)	Хороодын тоо																
500	3																
800	1																
700	1																
1000	5																
1500	6																
2000	3																
2500	3																

Хогны төлбөр хураах хүн	<p style="text-align: center;">Хогны төлбөр хураах хүмүүс</p> 
Төлбөрөө төлдөггүй хүмүүст авах арга хэмжээ	Арга хэмжээ авдаггүй: 7 хороо Захиргааны арга хэмжээ: 9 хороо
Төлбөрөө төлөх чадваргүй өрхүүдийн хувь хэмжээ	25.1%
Төлбөр хураах хувь хэмжээ	38.7%
Төлбөр хураах тогтолцооны бүртгэл хөтлөлт	<ol style="list-style-type: none"> 1) Төлбөрийн баримт өрх дээр бус хэсгийн ахлагч дээр хадгалагдах: 1 хороо 2) Төлбөрийн баримтыг хорооны ЗДТГ бус өрхүүд өөрсдөө хадгалах: 4 хороо 3) Төлбөр хийсэн бүртгэлийг хороо хийж төлбөрийн баримтын хувийг өрх дээр хадгалах: 10 хороо 4) Төлбөрийн баримтыг өрх дээр хадгалж бүртгэлийг өрх, хороонд тус тус хөтлөх: 3 хороо
Төлбөр авахгүйгээр хог хаягдлыг ачиж цуглуулах	<ul style="list-style-type: none"> ▪ Төлбөр төлдөггүй ч хог хаягдлыг нь ачиж цуглуулах: 7 хороо ▪ Төлбөр төлөхгүй бол хог хаягдлыг нь ачихгүй: 9 хороо
Төлбөр хураагчийн цалин	17 хороо хураасан төлбөрийн хэмжээ эсвэл хийсэн рейсийн тоон дээр үндэслэсэн урамшуулалын систем ашигладаг. 2 хороо ажиллах өдрийн тоон дээр үндэслэн цалингийн систем ашигладаг. Сард 30,000 - 40,000 төгрөг.

Өнөөдөр хог хаягдлын талаар тулгамдаж буй асуудлуудын талаар хорооны ажилтан анрын хэлсэн саналыг Зураг 3-8 -т үзүүлэв.

Асуудлуудын хамгийн тулгамдаж буй асуудал бол хогны төлбөр цуглуулах асуудал бөгөөд хоёрдугаарт, хууль бус хог хаях явдал юм байна.

Судалгааны явцад хорооны ажилтан нар хог хаягдал ачиж цуглуулах ажлыг ТҮК гүйцэтгэдэггүй тул хийхээс өөр араггүй болдог гэж илэрхийлжээ.



Зураг 3-8: Хог хаягдлын салбарт тулгарч буй өнөөгийн асуудлууд

а.4 Хог хаягдал цуглуулах машин төхөөрөмж

Машин төхөөрөмжтэй холбоотой хамгийн хүнд асуудал бол одоогийн ашиглаж байгаа машин төхөөрөмжийн нөхцөл байдлыг ойлгоход маш хэцүү асуудал юм.

2004 онд Улаанбаатар хотын захиргаа болон ТҮК хооронд байгуулсан гэрээнд машин төхөөрөмжийн талаар дараах чухал заалтууд тусгагджээ.

- ТҮК нь Улаанбаатар хотын өмч болох хог хаягдал цуглуулах машин төхөөрөмж болон гаражийг гэрээний хугацаа дуустал 3 жил ашиглах эрхтэй.
- ТҮК нь Улаанбаатар хотын өмч болох хог хаягдал цуглуулах машин төхөөрөмж болон байгууламжийг гэрээний хугацаа дуустал 3 жилийн хугацаанд худалдан авах эрхтэй.

Энэхүү гэрээг хоёр тал байгуулсан тул Нийслэлийн өмчийн харилцааны газар хүнд байдал орж цаашид хог хаягдал цуглуулах машин төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэхэд дурамжхан хандаж байна. Иймд дээрх байдлыг ойлгомжтой болгохын тулд бүх ТҮК-аас мэдээлэл цуглуулах шаардлагатай болно. Гэтэл ТҮК болгон машин төхөөрөмжийн бүртгэлийг өөр өөрөөр хөтөлдөг тул нийтэд нь хураангуйлан дүгнэхэд нэлээд хэцүү болж байгаа юм. Түүнчлэн машин төхөөрөмжийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн буюу 2004 оны 4 дүгээр сараас хойш ТҮК өөрсдөө шинээр худалдаж авсан төхөөрөмж бараг байхгүй байна. Иймд Улаанбаатар хотын захиргааны хэмжээнд өөрийн өмчийн эсвэл ашиглаж буй хог хаягдал цуглуулах машин төхөөрөмжийн талаар хэн ч ямар ч ойлголтгүй байна.

Хог хаягдал цуглуулах машин төхөөрөмжийн ерөнхий байдлыг дараах Хүснэгт 3-13-г үзүүлэв.

Хүснэгт 3-13: ТҮК-ийн хог хаягдал цуглуулах машин төхөөрөмжийн жагсаалт

Зүйл	нэгж	БГ	БЗ	СХ	СБ	ХУ	Ч	На	Нийт
Жагсаалтанд байгаа нийт төхөөрөмжийн дүн	ш	34	37	38	35	25	28	11	208
Жагсаалтанд байгаа хог хаягдал цуглуулах төхөөрөмжийн нийт дүн	ш	27	24	31	25	16	20	10	153
Одоогоор ажиллаж байгаа төхөөрөмжийн дүн	ш	22	12	22	17	14	14	4	105
Хогны машины ашиглалтын дундаж хугацаа	жил	10	15	16	8	п.а.	16	19	-
Хамгийн хуучин машины ашиглалтын хугацаа	жил	29	31	32	23	п.а.	22	25	-
Хамгийн шинэ машины ашиглалтын хугацаа	жил	2	4	6	1	п.а.	5	16	-

п.а. – мэдээлэл байхгүй

ТҮК-ийн одоогийн ашиглаж буй машин төхөөрөмжийн онцлог, үзүүлэлтүүд. Үүнд:

- a) Ихэнх машинууд хуучирч муудсан тул тэдгээр байнга эвдэрч байдагийн сацуу түлш их хэмжээгээр зарцуулдаг. Зарим машинууд нь өглөө асдаггүй, аккумулятор муу тул олон хүнээр түлхүүлж асаах шардлагатай болдог. Иймд замдаа машинаа унтраачихгүйн тулд орой гараждаа буцаж иртлээ мотор нь байнгын ажиллагаатай байх шаардлагатай болдог явдал маш зардал ихтэй байдаг. Аккумулятор суух асуудал нь хүйтэн цаг агаартай холбоотой юм.
- b) Дэндүү олон төрлийн машин ашиглах нь үйл ажиллагаа болон засвар үйлчилгээг хүндрүүлж үр ашгийг нь бууруулдаг.
- c) Ихэнх машинууд бензин түлш ашигладаг буюу ОХУ-д үйлдвэрлэсэн бензин хөдөлгүүртэй юм. Дизель хөдөлгүүртэй зөвхөн хоёр машин л байна. Ингэх болсон нь дараах шалтгаантай.

- ОХУ-д үйлдвэрлэсэн бензин хөдөлгүүр нь маш энгийн бөгөөд засахад хялбар. Өөрөөр хэлбэл, ТҮК нь дизель хөдөлгүүр засварлах боловсон хүчин-засварчин, засварын төхөөрөмжгүй байна гэсэн үг.
- Бензин нь дизелийг бодвол хямд. 2005 оны 1 дүгээр сарын байдлаар бензин түлшний үнэ 1 литр нь 580 төгрөг байсан бол дизель 760 төгрөг байжээ.

а.5 Ажлын хүч

ТҮК-иудын нийт ажилчдын тоог Хүснэгт 3-14-т үзүүлэв. Тэдгээрээс 30% нь цэвэрлэгээ хийх ажилчид, 20% нь шууд бус ажилтай, 50% нь хог хаягдал цуглуулах ажилд ажилладаг.

Хүснэгт 3-14: ТҮК-иудын нийт ажилчдын тоо

Зүйл	нэгж	БГ	БЗ	СХ	СБ	ХУ	Ч	На	Нийт
Нийт ажилчдын тоо	х	143	151	142	135	137	145	42	895

а.6 Ажлын ерөнхий нөхцөл байдал

Хог хаягдал ачиж цуглуулах ажлын албан ёсны ажлын цаг гэж байдаггүй, тухайн нэг хогны машины баг өөрсдөө ажиллах цагааг шийддэг. Хогны машин ихэвчлэн өглөө 8.30-10.00 цагийн хооронд ажилдаа гарч орой 6-11 цагийн хооронд буудаг байна. Зарим нь маш эрт, зарим нь шөнө гарч ажилладаг явдал ч байдаг байна. Улаанчулуулуутын хогийн төвлөрсөн цэг дээр тухайн өдрийн сүүлийн машин шөнө 4 цагт, хамгийн эхний машин өглөө 6 цагт ирдэг байна.

Хог хаягдал цуглуулах тогтсон өдөр байхгүй, тогтмол бус байдлаар хог хаягдал ачдаг болохоор хог хаягдал гаргагч буюу оршин суугчид, ААН-д хог хэзээ ачдаг өдрийг мэддэггүй.

Түүнчлэн тогтсон маршрут байхгүй тэр нь жолоочоос л хамаардаг байна. Иймд олон жолооч нар замаа товчлох, замгүй газраар явах хүртэл тохиолдол гардаг байна.

Хогны машины жолооч болон ачигч нар ажлын дүрэмт хувцас гэж байхгүй. Чингэлтэй дүүргийн ТҮК нь ажилчиддаа саван, алчуур болон бээлийгээр тогтмол хангадаг байна.

Олон жолооч, ачигч нар бэлэн мөнгө тэр болгон биедээ авч явдаггүй тул өдрийн хоолонд орохгүй, тасралтгүй 10 гаруй цаг ажиллах явдал гардаг байна. Заримдаа ачиж буй хог хаягдлаасаа олсон хаягдал түүхий эдийг зарж өдрийн хоол авч дийлэхгүй, ойр зуурын боов, печень авдаг байна.

а.7 ТҮК-ийн менежментийн систем

Техникийн тогтолцоо болон иргэдийн оролцоо, хамтын ажиллагааны асуудлаас ч илүү өнөөгийн институцын тогтолцоо нь хог хаягдал цуглуулах ажлын үр ашиг, үр дүнд ихээр нөлөөлжээ. Иймд одоогийн хог хаягдал цуглуулах үйл ажиллагаанд ноцтойгоор нөлөөлж буй институцын тогтолцоог доор тайлбарлав.

Судалгааны бүсэд хамрагдах нутаг дэвсгэр дээр хог хаягдлыг цуглуулах үйлчилгээг 2004 оны 4 дүгээр сараас хувьчлагдсан Улаанбаатар хотын зургаан ТҮК үзүүлдэг байна. ТҮК нь одоогоор хогны төлбөрийн нийт орлогыг өөртөө хуримтлуулдаг тул хог хаягдал ачих ажлыг гэрээт гүйцэтгэгчийн үндсэн дээр бус харин тухайн бизнесийг дангаараа эрхлэх эрх нь олгогдсон үндсэн дээр гүйцэтгэж байгаа тул ТҮК-д нэлээд эрх чөлөөтэй менежментийн бүтэцтэй юм байна.

Өнөөгийн хог хаягдал ачиж цуглуулах ажлын чанарт ноцтойгоор нөлөөлж байгаа зүйл бол тэдгээрийн менежментийн нэг арга хэмжээ болох жолооч, ачигч нарыг гэрээгээр ажиллуулах явдал юм. Одоогоор ТҮК-дийн жолооч, ачигч нарын цалингийн систем нь үндсэн ажлын цаг болон илүү цагийн ажил гэсэн хөдөлмөрийн хөлсийг төлөх зарчим дээр бус үйлчлүүлэгч нарын хог хаягдлын төлбөрөөс орж буй нийт орлогоос шатахуун,

сэлбэг зэрэг бусад зардлаа хасаад үлдэж буй орлогоос цалинжих зарчим дээр тогтнож байна. Энэхүү систем нь гэрээгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэх хэлбэр боловч ТҮК-дээс жолооч, ачигч нарт төлж буй төлбөрийн хэмжээ тогтмол, ажлын цаг тэдгээрийн орлоготой огт уялдаа холбоогүй байдаг тул ТҮК болон жолооч/ачигч гэсэн хоёр талууд хог хаягдал ачиж цуглуулах ажлын чанар, үр ашгийг дээшлүүлэх сонирхолгүй байна. Жолооч, ачигч нарын орлогыг дээшлүүлэх цорын ганц арга бол шатахуун хэмнэх болон ачигч нарын тоог багасгахад оршино. Иймд бодит байдал ямар байна гэвэл 1) цаг хугацаа ихээр шаардагдах боловч хог хаягдал ачиж тээвэрлэх зайг аль болох богиносгох ба 2) ачигч нарын тоог багасгах явдал юм. Ийм хөдөлмөрийн систем хог хаягдал ачиж цуглуулах ажлыг сайжруулахад ихээхэн хүндрэл бэрхшээл учруулж байна

Гэр хороололд хог хаягдлын төлбөрөө төлсөн тохиолдолд тухайн айлын хогийг ачдаг тул төлөвлөлтгүй бүсийн хог хаягдал ачиж цуглуулах үйл ажиллагаанд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлс бол хог хаягдлын төлбөр хураах ажил юм. Иймд одоогийн хогийн төлбөр хураах систем нь өөр хог хаягдал ачиж цуглуулах хувилбаруудыг нэвтрүүлэхэд нэлээд саад бэрхшээл болж байна.

Нийт ТҮК-иуд хогны машинд олгох шатахууны хэмжээг нэлээд нарийн хяналт тавьдаг байна. Чингэлтэй ТҮК-ийн хувьд хогны машинуудад дэндүү бага шатахуун олгож байгаа юм болов уу машинууд нь замаа тогтоосон маршрутаар бус замаар товчлох явдал их гарч байна.

Хог хаягдал ачдаг машинууд хогийн төвлөрсөн цэг дээр хог хаягдлаа буулгаж байгааг хянахын тулд Нөөц компани тухайн машиныг хогийн цэг рүү нэвтрэх болгонд тусгай бүртгэлийн баримт олгодог бөгөөд ТҮК нь тэрхүү бүртгэлийн баримтын дагуу өөрсдийн машинуудын Улаанчулуутын хогийн цэг рүү орж буй бүртгэлийг хөтөлдөг боловч зарим хогны машинууд хогийн цэг рүү нэвтрэх нэг оролтоороо тэр өдөр өөрт шаардагдах бүх тусгай бүртгэлийн баримт авчирдаг явдал мэр сэр гарсан тул өнөөгийн хяналтын систем шаардлага хангахгүй болсон нь ойлгомжтой байна.

3.2.3 Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ

Хариуцах байгууллагын хувьд судалгааны бүсэд хамрагдах нийтийн эзэмшлийн газрын цэвэрлэгээг хоёр хэсэгт хувааж үзэж болно. Үүнд, УБ хотын захиргаа болон тухайн дүүргийн тус тус хариуцах нутаг дэвсгэрийн цэвэрлэгээ.

б. УБ хотын хэмжээнд хариуцах цэвэрлэгээ

Нийслэлийн авто замын газар дараах 8 замыг хариуцдаг.

Хүснэгт 3-15: Нийслэлийн авто замын газрын хариуцах зам

	Замын нэр	Урт	Байршил	Гүйцэтгэгч
1	Айдсын давааны зам	10км	Нийсэхийн Цагаан хаалганаас Түргэний голын гүүр хүртэл	Наранбулаг Хан ХХК
2	Найрамдал зуслан явах зам	13.5км	Хүнс трейдийн уулзвараас Найрамдал зуслан хүртэл	Сан Од
3	Зүүн салааны зам	3.5км	Автобусны эцсийн буудлын уулзвараас	Самосон
4	Гэсэр сүмийн уулзвар		Уулзварын дөрвөн замын 16 м тус бүр	Сан Од
5	Нарны зам	8.4км	10 дугаар хорооллын уулзвараас Чулуутын овооны уулзвар хүртэл	Нийслэлийн зам
6	Морин даваа	5км	Нисэхийн автын постоос Морингийн даваа хүртэл	Цэцэгийн зам
7	Энхтайвны гудамж		Төмөр замын гармаас автын 22 дугаар пост хүртэл	Өргөн говь
8	Энхтайвны гудамж		Чулуутын овооны уулзвараас Баянзүрхийн автын пост хүртэл	УБЗЗК

Дээрх замын хөдөлгөөний хувьд ач холбогдол бүхий замын цэвэрлэгээний ажлыг УБ хотын захиргаа ТҮК-ийн замын цэвэрлэгээ хариуцах хүчин чадал бага тул гэрээний

үндсэн дээр хувийн компаниар хийлгэж байна. Дээрх замын цэвэрлэгээний зардлыг Замын сангаас гаргах бөгөөд тэрхүү сан нь замын төлбөр, тээврийн хэрэгслэлийн татвар зэрэг эх үүсвэрээс бүрдэнэ. Замын сан нь хотын төсвөөс тусдаа бие даасан сан бөгөөд хотын дарга зарцуулах эрхийг хариуцдаг байна.

Гэрээгээр ажиллаж буй гүйцэтгэгч компаниудын ажлыг Нийслэлийн авто замын газар сард 4 удаа шалгаж байх ёстой боловч амьдрал дээр цэвэрлэгээ арчилгааны ажлыг одоогоор 2 ажилтан долоо хоногт 3 удаа шалгаж үр дүнг үндэслэн сар болгон тэдгээр компаниудад төлбөрийг нь хийдэг байна.

Гүйцэтгэгч компаниуд нь тайлангаа Нийслэлийн авто замын газар болон Нийтлэг үйлчилгээний газар хүргүүлж байх ёстой юм байна.

2005 оны (2004 оны 12 дугаар сараас 2005 оны 11 дүгээр сар хүртэл) төсөвт зөвхөн 80.0 сая төгрөг туссан боловч эхний 5 сар буюу 12 дугаар сараас 4 дүгээр сар хүртэл хугацаанд гүйцэтгэсэн ажилд 64.3 сая төгрөг компаниудад төлчихсөн байгаа байдал нь Замын газрын санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй тулгарч буйн илэрхийлэл юм.

Зам цэвэрлэгээ, арчилгааны нөхцөл бол замын өргөн харгалзахгүйгээр сард 1 км зам 30,000 төгрөг болно.

Нийслэлийн авто замын газар нь өвлийн улиралд дүүргийн хариуцдаг, хотын ач холбогдол бүхий гэсэн дараах замын цэвэрлэгээ арчилгаанд нэмэлт зардал гарна гэж тооцож Замын сангаас ТҮК-д санхүүгийн дэмжлэг хэлбэрээр төлдөг байна.

Хүснэгт 3-16: ТҮК Замын сангаас нэмэлт төлбөр авч цэвэрлэх зам

	Замын нэр	Байршил	Гүйцэтгэгч
1	Баянхошууны зам	Толгойтын зүүн салаанаас ХМК-ын уулзвар хүртэл, 10	СХД ТҮК
2	Толгойтын баруун салаа	Мон лаа ХХК-ийн урд болон баруун салааны зам, 2+0.5	СХД ТҮК
3	Орбитын зам	Орбитоос нефть хангамж хүртэл, 1	СХД ТҮК
4	Телевиз-Баянхошууны зам	МҮТ-ээс Баянхошууны эцсийн буудал хүртэл	Лүнт сант
5	Хойд зуслангийн зам	Шарга морьтын гүүрнээс хойш	СБД ТҮК
		7 буудлаас Шарга морьтын гүүр хүртэл	ЧД ТҮК
6	Шархадын зам	Цэргийн их сургулиас Шархадны эцсийн буудал хүртэл	БЗД ТҮК
7	Богд уулын хойд зам	Зайсангийн уулзвараас Их тэнгэрийн зүүн тал хүртэл	ХУД ТҮК
8	Баруун дөрвөн замын уулзвар	Энхтайвны гудамж	СБД ТҮК
9	Зүүн дөрвөн замын уулзвар	Энхтайвны гудамж	БЗД ТҮК
10	Төв шуудангийн уулзвар	Энхтайвны гудамж	СБД ТҮК

с. Дүүргийн захиргааны хариуцах нийтийн эзэмшлийн газар

с.1 Цэвэрлэх талбай

Дүүргүүдийн хариуцах авто зам, явган хүний зам, парк, талбай болон ногоон байгууламж зэрэг нийтийн эзэмшлийн газрын нийт талбай нь 3,266,374 м² бөгөөд дараах Хүснэгт 3-17-үзүүлэв. Жил болгон дүүргийн ЗДТГ энэхүү цэвэрлэгээний ажлыг ТҮК-д гэрээгээр гүйцэтгүүлдэг.

Хүснэгт 3-17: Дүүргүүдийн цэвэрлэдэг нийтийн эзэмшлийн бүс

Дүүрэг	Бүс
БГД	598,015м ²
БЗД	517,346м ²
СХД	360,529м ²
СБД	808,684м ²
ХУД	439,700м ²
ЧД	542,100м ²
Нийт	3,266,374м ²

Дүүрэг тус бүрээр хариуцаж цэвэрлэдэг нийтийн эзэмшлийн газруудыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3-18: БГД-ийн цэвэрлэх нийтийн эзэмшлийн газар

№	Зам талбайн нэр	Зам		Ногоон байгууламж	Нийт
		Авто	Явган хүн		
	нэгж	м ²	м ²	м ²	м ²
	ЭНХТАЙВНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ				
1	25-р эмийн сан – Төмөр замын коллеж, уулзварын гэрлэн дохио	700	3,500	5,110	9,310
2	Магсаржавын гудамжны гэрлэн дохионоос Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордон хүртэл	2,000	7,200	6,400	15,600
3	Техник импорт – Хөхбүрд	5,600	15,400	33,600	54,600
	Хөхбүрд – Эмийн сан №25	400	2,200	2,400	5,000
4	Занабазарын гудамж	2,000	2,000	8,900	12,900
5	Сөүлийн гудамж	1,600	5,200	8,960	15,760
6	Амарсанаагийн гудамж	4,000	11,800	7,000	22,800
7	Хувьсгалчдын гудамж	200			200
	баруун дөрвөн замын уулзвараас Гэсэр сүм хүртэл	700	3,200	2,400	6,300
8	Хувьсгалчдын гудамж	200			200
	Гэсэр сүмээс хойшоо	2,300	1,200	1,200	4,700
9	Жамсранжавын гудамж	3,200	900	9,100	13,200
	Гэмтлийн эмнэлэгээс Чингүүнжавын уулзвар		1,650		1,650
10	Дамдинбазарын гудамж, Чингүүнжавын уулзвараас White House хүртэл	2,000	7,000	8,000	17,000
11	Ард Аюушийн гудамж Өргөө кинотеатраас троллебусны эцсийн буудла хүртэл	2,400	10,500	9,600	22,500
12	Троллебусны эцсийн буудлаас Саппоро	7,200	14,400	72,000	93,600
13	Ажилчдын гудамж буюу гурвалжангийн гүүр	3,800	4,750	2,660	11,210
14	Энэбишийн гудамж /Тасганы овооноос/ Петровисын ШТС-аас Өргөө кинотеатр хүртэл	6,800	29,920	27,200	63,920
15	Их тойруу	0	0	0	0
16	Чингүүнжавын гудамж	1,200	6,000	16,200	23,400
		1,600	4,000	4,800	10,400
17	Чингүүнжавын гудамжны үргэлжлэл, Өргөө хүртэл	400	800	0	1,200
18	Хасбаатарын гудамж	2,600	6,300	23,100	32,000
		1,600	0	0	1,600
19	Магсаржавын гудамж Төмөр замын коллежийн уулзвараас вокзал хүртэл	1,200	3,840	10,200	15,240
	ТӨМӨР ЗАМЫН БҮСЭД				
20	Төмөр замчдын 1 дүгээр гудамж	2,400	4,800	14,400	21,600
21	Октябрын гудамж /Нарны замын нөгөө тал/ Автобусны буудлаас Магсаржавын гудамжны уулзвар хүртэл	1,800	2,520	0	4,320
22	Октябрын гудамж /Нарны замын нөгөө тал/ Магсаржавын гудамжны уулзвараас халуун ус хүртэл	1,000	1,400	2,850	5,250
23	Үндсэн хуулийн гудамж Үйлдвэрчний соёлын төв ордон, Занабазар 2 – Нарны зам	700	2,800	2,450	5,950
24	Нарны зам	0	6,000	0	6,000
25	Төмөр замчдын 6 гудамж /Төмөр замын эмнэлгийн урд талд/ Халуун ус – Энхтайвны гудамжны уулзвар	1,000	750	4,000	5,750
26	Наран дэлгүүрийн урд зам Төмөр замчдын гудамж № 6 – Октябр гэсэн арктай байр	800	2,400	1,600	4,800
27	Холбооны газар, Төмөр замчдын 3 дугаар гудамжны гурван угсармал байр болон Жон Бейс төвийн хоорондох зам	1,000	2,000	5,500	8,500
28	Төмөр замчдын 2 дугаар гудамж Төмөр замын цагдаа болон шүүхийн урд зам	1,000	2,000	5,000	8,000
29	Октябрийн 3 дугаар гудамж Ган зам зочид буудал болон рестораны урд зам	1,000	1,500	3,650	6,150
	3, 4 ДҮГЭЭР ХОРООЛЛЫН БҮСЭД	0	0	0	0
30	Нарлаг дэлгүүрээс дээшээ өгсөх туслах зам	400	400	0	800
31	Эх нялхас болон Монгол Телевизийн хоорондын зам	600	1,200	3,900	5,700
32	Өргөө кинотеатрын хажуугийн зам	300	360	1,200	1,860
33	7-р хорооны туслах зам	600	840	5,400	6,840

34	Дүүхээ төвийн дэргэдэх туслах зам	600	840	5,400	6,840
35	Баянгол их дэлгүүрийн хажуугийн туслах зам	600	840	5,400	6,840
36	Шинэ дорно –ын хойд талын туслах зам	200	0	650	850
37	Од кинотеатрын хажуугийн талбай	280	336	147	763
38	28-р дунд сургуулийн баруун талын Энхбаярын гудамж	600	600	0	1,200
39	6 дугаар бичил хорооны арк	100	0	0	100
40	Бичил хорооллын баруун тал /Зүүн наран, 18, 10, 11 дугаар хорооны хоорондын зааг хил/	1,000	1,400	0	2,400
41	Мандах өргөө	400	400	0	800
42	Тролебусны эцсийн буудал, хороо 9, 13-ын хил	0	0	0	0
	10-Р ДУГААР ХОРООЛОЛ				
43	10-р хорооллын туслах зам	1,800	0	16,200	18,000
44	Барилгын коллеж – Сувилагчийн сургуулийн туслах зам	500	0	1,000	1,500
	Нийт хэмжээ	72,380	175,146	337,577	585,103
				Талбай	12,912
				Нийт хэмжээ	598,015

Хүснэгт 3-19: БЗД-ийн цэвэрлэх нийтийн эзэмшлийн газар

№	Зам талбайн нэр	Зам		Ногоон байгууламж	Нийт
		Авто	Явган хүн		
	нэгж	м ²	м ²	м ²	м ²
1	Энхтайвны өргөн чөлөө	94,336	18,784	33,612	146,732
2	Хойд их тойруу, 8 салаа	42,648	4,364	10,976	57,988
3	Намянжу	43,200	2,200	0	45,400
4	Токио	21,600	2,680	3,200	27,480
5	Самбуу, Тунел	43,200	7,200	13,600	64,000
6	Дандарбаатар	19,200	2,800	1,400	23,400
7	Улаанхуаран	19,200	1,200	0	20,400
8	Шархад	19,200	4,800	0	24,000
9	Амгалан-Чулуутын овоо	20,000	500	0	20,500
10	Туул жин пан, Цайз, №16 Хороо	38,400	3,000	0	41,400
11	Жуковын хөшөө	28,336	14,168	3,542	46,046
	Нийт	389,320	61,696	66,330	517,346

Хүснэгт 3-20: СХД-ийн цэвэрлэх нийтийн эзэмшлийн газар

№	Зам талбайн нэр	Зам		Ногоон байгууламж	
		Авто	Явган хүн	Нийт	Нийт
	нэгж	м ²	м ²	м ²	м ²
1	Энхтайвны өргөн чөлөө	60,525	32,021	0	92,546
2	Үйлдвэрчний эвлэлийн гудамж	40,740	1,410	0	42,150
3	1 дүгээр хорооллын хойд зам	19,600	16,300	0	35,900
4	Барилгачдын гудамж	3,850	3,300	0	7,150
5	Залуучуудын гудамж	3,850	3,300	0	7,150
6	Толгойтын зам	23,520	0	0	23,520
7	"Herders" кафены хажуугийн зам	2,800	3,600	0	6,400
8	Үйлчилгээний төвийн урд талбай	0	9,500	0	9,500
9	Хорооллын зам	5,000	500	0	5,500
10	Энхтайвны өргөн чөлөө	0	0	79,955	79,955
11	Үйлдвэрчний эвлэлийн гудамж	0	0	630	630
12	1 дүгээр хорооллын хойд зам	0	0	8,000	8,000
13	Барилгачдын гудамж	0	0	10,918	10,918
14	Залуучуудын гудамж	0	0	12,110	12,110
15	"Herders" кафены хажуугийн зам	0	0	12,600	12,600
16	Үйлчилгээний төвийн урд талбай	0	0	6,500	6,500
	Нийт	159,885	69,931	130,713	360,529

Хүснэгт 3-21: СБД-ийн цэвэрлэх нийтийн эзэмшлийн газар

№	Зам талбайн нэр	Зам		Ногоон байгууламж	Нийт
		Авто	Явган хүн		
	нэгж	м ²	м ²	м ²	м ²
1	Энхтайвны өргөн чөлөө	50,820	12,270	13,700	76,790
2	Олимпийн гудамж	15,600	7,800	32,000	55,400
3	Сөүлийн гудамж	15,800	9,930	13,000	38,730
4	Партизаны гудамж	2,413	1,524	1,700	5,637
5	Намнансүрэнгийн гудамж	2,153	1,722	1,000	4,875
6	Ханддоржийн гудамж	2,151	1,075	0	3,226
7	Цэрэндоржийн гудамж	6,650	3,200	8,200	18,050
8	Усны гудамж	3,080	1,760	1,200	6,040
9	Үндсэн хуулийн гудамж	1,800	1,800	700	4,300
10	Гэндэнгийн гудамж	600	800	240	1,640

11	Чойдогийн гудамж	1,260	480	400	2,140
12	Чингисийн гудамж	12,600	3,600	3,000	19,200
13	Жамьяан гүнийн гудамж	1,800	1,200	2,500	5,500
14	Тээвэрчидын гудамж	25,000	5,000	11,100	41,100
15	Гүүрний хоёр талын эрэг	3,080	400	14,000	17,480
16	Их сургуулийн гудамж	18,200	12,000	5,200	35,400
17	Сүхбаатарын гудамж	9,100	3,000	2,000	14,100
18	Нэгдсэн үндэстний гудамж	6,000	3,000	3,000	12,000
19	Бага тойруу	27,600	8,280	20,000	55,880
20	Амарын гудамж	2,100	1,800	2,000	5,900
21	Их тойруу	43,000	12,900	5,000	60,900
22	Залуучуудын өргөн чөлөө	12,000	4,500	4,800	21,300
23	Эрхүүгийн гудамж	4,900	4,200	5,600	14,700
24	Цагдаагийн гудамж	18,800	6,800	0	25,600
25	Содномын гудамж	2,400	200	0	2,600
26	Эмнэлгийн 1 ба 2 дугаар зам	4,900	2,800	0	7,700
27	Хуримын ордны урд зам	2,100	1,600	1,600	5,300
28	7 буудлын зам	17,000	6,800	800	24,600
29	32-ийн тойрог	2,100	124	1,600	3,824
30	9-р хорооны дундын зам	10,800	12,000	1,200	24,000
31	Дэнжийн мянгын зам	13,300	5,700	3,800	22,800
32	Дамбадаржаагийн зам	8,400	0	0	8,400
33	Дарь эхийн зам	22,400	0	0	22,400
34	Элчин сайдын яамны хойд зам	3,000	600	3,000	6,600
35	Оюутны гудамж	1,309	0	0	1,309
36	Төвийн хоёр паркийн хойд зам	900	0	0	900
37	Зүүн ба төв паркийн хоорондын зам	780	324	0	1,104
38	Баруун ба төв паркийн хоорондын зам	1,116	288	0	1,404
39	Сүхбаатарын талбай	0	44,000	456	44,456
40	Монгол эх цогцолбор	0	200	12,000	12,200
41	Драмын театрын зүүн талбай	0	2,900	900	3,800
42	Төвийн 4 парк	0	45,300	24,100	69,400
	НИИТ	377,012	231,877	199,796	808,685

Хүснэгт 3-22: ХУД-ийн цэвэрлэх нийтийн эзэмшлийн газар

№	Гудамжны нэр	Автозам	Явган хүний зам	Парк /байгалийн/	Мод бут тарьсан бүс	Нийт
		нэгж м ²	м ²	м ²	м ²	
1	Чингисийн өргөн чөлөө	96,000	5,600	19,500	12,800	133,900
2	Зайсангийн зам	72,000	1,600	2,500	1,200	77,300
3	75-р сургуулийн урд	0	0	800	300	1,100
4	75-р сургуулийн зүүн талд	3,600	0	2,400	1,000	7,000
5	Богд хаан ордон музейн орчим	0	6,000	3,200	2,800	12,000
6	19-р хорооллын хойд зам	12,000	0	1,500	500	14,000
7	Арьс ширний үйлдвэр орох зам	48,000	0	800	200	49,000
8	Ноосны үйлдвэр орох зам	7,200	0	800	500	8,500
9	Савхины үйлдвэр орох зам	4,800	0	1,400	1,000	7,200
10	Энгэльскийн гудамж	3,600	0	1,500	1,200	6,300
11	ТЭЦ 3	0	0	6,000	1,000	7,000
12	Тээврийн зогсоол	0	0	5,700	2,500	8,200
13	Төгсөгчдийн парк	3,600	0	1,200	1,000	5,800
14	Зайсангийн хөшөө	4,800	800	5,400	4,100	15,100
15	Зайсангийн хойд тал	0	0	2,500	1,400	3,900
16	Ээрмэлийн үйлдвэрийн парк	0	0	3,500	2,900	6,400
17	Туул, Сэлбэ, Яармагийн гүүрний эрэг	0	0	10,000	0	10,000
18	Засяангийн гүүр	0	0	10,000	0	10,000
19	Орон сууцны бүс	3,600	2,300	8,200	5,500	19,600
20	Стадионы орчим	0	0	24,000	0	24,000
21	Сургууль цэцэрлэгийн бүс	0	0	3,400	2,000	5,400
22	Вангийн зам	3,600	0	4,400	0	8,000
	НИИТ	262,800	16,300	118,700	41,900	439,700

Хүснэгт 3-23: ЧД-ийн цэвэрлэх нийтийн эзэмшлийн газар

№	Зам талбайн нэр	Зам		Ногоон байгууламж	Нийт м ²
		Авто м ²	Явган хүн м ²		
1	Энхтайваны өргөн чөлөө	24,900	9,500	10,863	45,263
2	Бага тойруу	38,700	10,000	22,980	71,680
3	Баруун сэлбэ	28,300	4,100	4,168	36,568
4	Жигжиджавын гудамж	6,000	1,000	1,470	8,470
5	Чоймболын гудамж	8,000	2,400	2,900	13,300
6	Жуулчны гудамж	31,000	6,000	3,152	40,152
7	Төмөр хүн	5,500	1,800	2,014	9,314
8	Дэнжийн 1000	21,000	1,500	2,800	25,300
9	Самбуу	37,400	10,000	11,136	58,536
10	Эрх чөлөөний гудамж	7,000	0	0	7,000

11	Их тойруу	41,000	13,500	8,400	62,900
12	7 буудал	31,000	5,000	5,200	41,200
13	Нэгдсэн үндэстний гудамж	5,000	1,200	3,967	10,167
14	Шинэ зам	36,200	4,500	4,800	45,500
15	Сүхбаатар	28,000	4,000	3,200	35,200
16	Зах орох зам	15,000	7,500	0	22,500
17	Болзооны талбай	0	600	1,800	2,400
18	Асашёругийн парк	0	500	760	1,260
19	ЧД хот харах дээд цэг	0	0	1,190	1,190
20	Явуугийн парк	0	1,000	3,200	4,200
	НИИТ	364,000	84,100	94,000	542,100

с.2 Нөөц болон ажлын аргачлал

Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээнд нийт ТҮК-д 270 хүн, 20 машинтай ажиллаж байна.

Цэвэрлэх аргачлал бол гараар бөгөөд ажилчид шүүр, хогны тосгуур болон дугуйтай хогны сав ашиглаж хог цэвэрлэж дараа нь хогны машинд ачиж хогийн цэг рүү гэвэрлэнэ.

Заримдаа замын хог тоосыг дарахын тулд усны машин ашиглаж зам услана.

Нийтийн эзэмшил газрыг цэвэрлэх үндсэн машин төхөөрөмж бол самосвал, ачааны машин, усны машин, цас цэвэрлэгч зэрэг ашигладаг байна.

Замын хөдөлгөөн ихтэй гудамжаар өглөө эрт хаягдал хог замбараагүй тархах боловч зам цэвэрлэгч болон гудамж руу харсан үйлчилгээний газартай хүмүүс өглөө болгон, заримдаа хаяа нэг цэвэрлэж байдаг тул ерөнхийдөө нийтийн эзэмшлийн газрыг цэвэр, хоггүй байлгадаг байна.

Одоогийн нийтийн эзэмшлийн зам талбай цэвэрлэх ажлыг хангалттай гүйцэтгэж байна гэж үзэж болох боловч өвлийн улиралд цас мөс цэвэрлэх ажил нь ТҮК-д нэлээд хүнд хүчир ажил болдог байна.

d. Холбогдох талуудын үүрэг хариуцлага

ЗАА-ны 2001 оны 9 дүгээр сарын А50 тоот мэдэгдэл дээр холбогдох байгууллагуудын цэвэрлэгээ арчилгааны ажлын үүрэг хариуцлагыг дараах байдлаар тодорхойлжээ.

- ТҮК нь нийтийн эзэмшлийн зам, талбай, гудамж, ногоон байгууламж хариуцана.
- СӨХ нь тухайн байрны 50м орчимын газар болон орцны цэвэрлэгээг хариуцана.
- ОСНААГ нь b)-ийн заалтанд дурьдсан бусад газруудын цэвэрлэгээг хариуцана.
- Албан байгууллага, үйлчилгээний газрууд өөрийн орчимын 50м газрын цэвэрлэгээ, хууль бус хог хаягдал болон цас мөсний цэвэрлэгээ хариуцана.

3.2.4 Рисайкл хийх буюу хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах

а. Рисайкл

Судалгааны бүсийн хог хаягдлыг дахин ашиглах буюу рисайкл үйл ажиллагааны өнөөгийн байдлыг дараах байдлаар тайлбарлав.

- Судалгааны бүсэд хог хаягдлыг рисайкл хийх үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд ихэвчлэн хотын гудамж болон хогийн цэг дээр хог түүгч нар хаягдал түүхий эд цуглуулж түүхий эдийн цэгүүдэд тушаадаг байна. Судалгааны ажлын хүрээнд хийсэн рисайкл зах зээлийн судалгааны хүрэнд түүхий эд авдаг цэгүүд

хог түүгч нарын түүсэн хаягдал түүхий эдийн 85-90 хувийг худалдан авдаг байна.

- Түүхий эд худалдан авагч ялгаж угааж цэвэрлэсний дараа ихэвчлэн Хятад руу экспортлодог байна.
- Хаягдал түүхий эд цуглуулдаг бусад хүмүүс бол хогны машины ачигч болон СӨХ-ийн орцны цэвэрлэгч нар юм
- Рисайкл судалгаагаар төслийн судалгааны бүсэд хаягдал түүхий эдийг ашиглах үйлдвэрийн газар цөөн байна гэж гарчээ. Архи, пивоны шил дахин ашигладаг үйлдвэр байхын сацуу хаягдал цаас, хуванцар, төмөр түүхий эд болгон ашигладаг цөөн тооны жижиг үйлдвэрүүд байна. Хаягдал цаас, хуванцар ашигладаг үйлдвэрүүд нь бүх төрлийн цаас, хуванцарыг түүхий эд болгон ашиглах боломжгүй тул хаягдал түүхий эдийг нь гаргадаг газруудтай гэрээ хийж чанар дээр нь хяналт тавин худалдаж авдаг байна. Хаягдал цаас, хуванцар ашигладаг бүх үйлдвэрүүд судалгаагаар байнга түүхий эдийн хомсдолтой тулгардаг гэж илэрхийлэв.
- Судалгааны бүсийн рисайкл үйл ажиллагааг дан хувийн хэвшил гүйцэтгэж байна.
- Хаягдал түүхий эдийн зах зээл ихэвчлэн төмөр, шилэн лонх, хөнгөн цагаан лааз, хуванцар сав зэрэг нь худалдаалагдаж байна. Хоёрдогч түүхий эдийн зах зээл дээр зэс болон хөнгөн цагаан лааз зэрэг нэлээд үнэтэй, түүнчлэн хуванцар сав мөн гүйлгээтэй байдаг байна. Тэрхүү байдал нь бусад хөгжиж буй орнуудын хотуудтай ижил байгааг судалгааны баг ажиглав.
- Нэг шувууны аж ахуйтай газар шувууны сангас ашиглаж бордоо үйлдвэрлэж байсан боловч тэрхүү бордоогоо хөршүүддээ үнэгүй өгдөг байв.
- Хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгааны дагуу махны лангууны худалдагчид хаягдал ясаа хоёрдогч түүхий эд болгон зардаг байна. ДЭМБ-ын зүгээс махны дэлгүүрүүдээс гардаг хаягдал ясны талаар судалгааны хийсэн бөгөөд тэрхүү судалгааны зүгээр цуглуулсан ясыг нийтэд нь Хятад руу экспортлож тэндээ тос, бордоо зэргийг үйлдвэрлэдэг байна.


в. Дунд шатны боловсруулалт

Эмнэлгийн хог хаягдал шатаадаг жижиг хэмжээний зуухаас өөр дунд шатны хог хаягдал боловсруулах байгууламж байхгүй болно. Томоохон эмнэлгүүд халдвартай хог хаягдал боловсруулах жижиг зуухтай байдаг. Тэдгээр хэдий хуучирсан ч ажиллагаатай байна.

Шувууны сангас ашиглан бордоо үйлдвэрлэхээс өөр бордооны үйлдвэрлэл байхгүй бөгөөд тэрхүү шувууны сангасаар бордоо хийж буй газар нь үйлдвэрлэл бус хашаандаа зөвхөн овоолж цуглуулж байна. Хотын хог хаягдлын бүтцийг аваад үзвэл хүнсний хог хаягдал бага бөгөөд судалгааны бүсийн хог хаягдал нь бордоо үйлдвэрлэхэд тохирмжгүй юм.


3.2.5 Хогийн төвлөрсөн цэг

Судалгааны бүсэд гурван төвлөрсөн цэг байдаг. Тэлгээр нь 25-40 жилийн хугацаанд дунджаар ашиглагдаж байна. Хөрсөөр хучих, хашаа барих, бохир шингэний байгууламж зэргийг барьж байгуулаагүй байна.



Зураг 3-9: Хогийн төвлөрсөн цэгүүдийн байршил

а. Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэг (УЧХЦ)




Зураг 3-10: Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэг

- Судалгааны бүсийн нийт хог хаягдлын 95 орчим хувийг хүлээн авдаг цэг нь УЧХЦ юм. Тэрхүү цэг нь Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хотын баруун хойд зүгт, Сүхбаатарын талбайгаас 13км зайд оршино.
- УЧХЦ нь тодорхой хил хязгаар гэж байхгүй боловч ойролцоогоор 8 орчим га газар хамардаг байна.
- Гэр хорооллын хог хаягдал өвлийн улиралд ихээхэн үнстэй байдаг тул ландфил дотор нэвтрэх боломж нь асуудалгүй бөгөөд зуны улиралын нэвтрэх боломжийг цаашид судлах шаардлагатай.
- Засмал замаас УЧХЦ хүртэл 2 орчим км шороон замтай. Тэрхүү шороон замын гадаргуу нь хатуу хөрс тул хогны машин зорчиход хүндрэлгүй боловч замын

тоос шороо ихээр босч хүрээлэн буй орчин, ялангуяа амьдрах орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна.

- УЧХЦ-ийн үйл ажиллагааг Хотын захиргааны дэргэдэх Нөөц компани хариуцдаг. Тэрхүү компани нь хоёр бульдозер, нэг оператортой боловч сэлбэг болон техникийн хэт хуучирсан байдлаас болж бульдозерууд байнга эвдэрдэг байна.
- Хогийн цэг дээр зөвхөн ил задгай байдлаар хог хаягдлыг хаях технологи ашиглаж байгаа тул байнга гал гарч утаатай болж байгаль орчинд ихээхэн ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна.
- Хогийн цэг рүү явах замын арчилгаа муу болон өгсүүр байдлаас шалтгаалан зам дагуу хог хаягдал замбараагүй тархаж хүчтэй, ялангуяа хаврын улиралд гарах салхинаас болж гчлгар уут цэгийн орчимд ихээр тархжээ.
- УЧХЦ дээр хэдэн зуун хог түүгч нар хуванцар, металл, хуванцар сав, шилэн лонх зэрэг худалдаж болох хоёрдогч түүхий эдийг цуглуулж байна. Хог түүгч нар бульдозер болон хогны машины үйл ажиллагаатай давхцаад бараг дэргэд нь шахуу хог түүж байгаа тул аливаа осол аюул гарч болзошгүй байдал байна.
- Бульдозерийг шөнийн цагт байрлуулах гараж байхгүй тул өглөө, ялангуяа өвлийн улиралд, асаах ажил нь цаг хугацаа шаардсан нэлээд хүнд хүчир ажил болдог.
- Хогийн цэг дээр хог буулгахаар ирж буй машинуудыг Нөөцийн ажилтан гараар бичилт хийж бүртгэж байна. Бүртгэл хөтлөх 3 диспетчер 24 цагийн ээлжээр буюу 1 өдөр гарч 2 өдөр амардаг юм байна.

в. Морин давааны хогийн төвлөрсөн цэг



Зураг 3-11: Морин давааны хогийн төвлөрсөн цэг

- МДХЦ нь Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хотын баруун урд, Сүхбаатарын талбайгаас 23км, УБ хотын олон улсын нисэх буудлаас 5км зайд оршино.
 - МДХЦ нь тодорхой хил хязгаар гэж байхгүй боловч ойролцоогоор 9 орчим га газар хамардаг байна.
 - МДХЦ дээр зөвхөн Хан-Уул дүүргийн хог хаягдал буудаг бөгөөд судалгааны бүсийн нийт хог хаягдлын 5 орчим хувийг эзэлж байна.
 - Засмал замаас МДХЦ хүртэл 1 орчим км шороон замтай. Тэрхүү шороон замын гадаргуу нь хатуу хөрс тул хогны машин зорчиход хүндрэлгүй бөгөөд оршин суух бүс байхгүй тул замын тоос шороо нь нэг их хүндрэл учруулдаггүй юм.
 - Цэг дээр нэг диспетчерийн байр болон гараж байх бөгөөд бульдозер байхгүй, шаардлагатай тохиолдолд УЧХЦ-ээс тээвэрлэн авчирч ашигладаг байна.
 - Хогийн цэг дээр зөвхөн ил задгай байдлаар хог хаягдлыг хаяж хөрсөөр хучих үйл ажиллагаа явагдаггүй. Иймд гал, утаа гарах явдал тохиолдох боловч хог хаягдлын хэмжээ бага тул хүрээлэн буй орчинд нөлөөлөх сөрөг байдал нь хязгаарлагдмал юм.
 - МДХЦ дээр 10-20 хог түүгч нар хуванцар, металл, хуванцар сав, шилэн лонх зэрэг худалдаж болох хоёрдогч түүхий эдийг цуглуулж байна. Хогны машины олноор ирдэггүй тул аливаа осол аюул гарах нь бага.
- с. Налайхын хогийн төвлөрсөн цэг (НХЦ)**
- НХЦ нь Налайх дүүрэг, Улаанбаатар хотын зүүн урд, Сүхбаатарын талбайгаас 38 орчим км зайд оршино. Хогийн цэгийг зөвхөн Налайх дүүрэг ашигладаг бөгөөд судалгааны бүсэд хамрагдах бусад газраас хог дарж булдаггүй.
 - Налайхын хогийн төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг Налайх ТҮК хариуцдаг боловч хог хаягдлыг түрэх, тэгшлэх, нягтруулах техникгүй тул жилд нэг удаа ойролцоох цэргийн баазаас техник авч ажиллуулдаг байна.
 - Цэг нь ерөнхийдөө нэлээд тал газар тул тодорхой хил хязгаар гэж байхгүй.
 - Налайхад бойны газар үйл ажиллагаа явуулдаг тул мал амьтны сэг хогийн цэг дээр хаягдаж эггүй үнэр гарах зэрэг хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлдөг байна.

3.2.6 Машин, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ

Улаанбаатар хотын захиргаа нь өөрийн өмч болох хог хаягдал цуглуулах техник, гаражийг ТҮК-д түрээслүүлдэг боловч механикийн менежментийн үйл ажиллагаа болон өөрийн гэсэн засвар үйлчилгээний цех байхгүй. Тэрхүү нийт тоног төхөөрөмжийг ТҮК хариуцаж менежментийг нь хийдэг байна.

ТҮК нь менежментээр давуу эрх авч үйл ажиллагаагаа эрхлэж тэрхүү техникийг ашиглан хог хаягдал цуглуулах, булах болон бусад тохижилт цэвэрлэгээний ажил тухайн дүүрэгт гүйцэтгэж орлого олдог байна. Орлогынхоо хүрээнд дээрх техник төхөөрөмжийн менежментийг хариуцдаг байна.

а. Техник төхөөрөмжийн одоогийн байдал

ТҮК-ийн ашиглаж буй ихэнх техник төхөөрөмж нь анхнаасаа хуучин техник байсан бөгөөд тэдгээр нь одоогоор 15 ба түүнээс дээш жил, зарим нь 30 гаруй жил ашигладсан ч байна. Техник төхөөрөмжийн 90% ОХУ-д, бусад 10% нь Хятад, Япон зэрэг улсад үйлдвэрлэгдсэн байна.

Иймд, ихэнх техник төхөөрөмжийг бүрэн капитал засварт оруулах болсон эсвэл үндсэн эд ангиудын солих цаг нь болжээ. Капитал засвар үйлчилгээ хийгдэхгүй байгаа гол шалтгаан нь юуны түрүүнд төсөв хөрөнгийн хүрэлцэхгүй байгаа байдал болон сэлбэг хэрэгслэлийн олдцотой холбоотой, ялангуяа Япон Улсад үйлдвэрлэсэн компактор болон 20-иос дээш жил ашигласан ОХУ-д үйлдвэрлэсэн машины техникийн сэлбэг олоход хүндрэлтэй байдаг байна. Машиныудын эвдэрч сатах гол шалтгаан нь машины хөдөлгүүрийн болон дугуй, кропка зэрэг явах эд ангийн эвдрэлээс болдог байна. Ажиглалт судалгааны үндсэн дээр машин техникийн ажиллах чадвар нь нэлээд доогуур байна гэж үзэж байна. Иймд ойрын 3-5 жилд дээрх төхөөрөмжүүдийг ашиглах боломж нь багасаж солих шаардлагатай болно.

б. Үйлчилгээ арчилгааны систем

Өнөөдөр ТҮК-д механикийн цехийн ажилтан, засварын цех, байгууламж, тусгай багаж хэрэгслэл, агуулах зэрэг асуудлаар олигтой завсар үйлчилгээний менежментийн систем байхгүй байна.

Машин техникийн засвар үйлчилгээний хяналтын асуудал нь дараах онцлог системтэй байна. Хогны машины жолооч нь хог хаягдал цуглуулах ажлыг хариуцахын сацуу машин техникийн засвар үйлчилгээг ч бас давхар хариуцдаг байна. Энэхүү системийн хүрээнд ихэнх ТҮК нь засвар үйлчилгээний зардлыг сар болгон жолоочийн орлогоос хасч тооцдог байна. Чингэлтэй болон Налайх ТҮК нь тэрхүү системийг мөрддөггүй боловч жолооч нь машиныхаа засвар үйлчилгээг хариуцдаг байна.

Засвар болон шинэ сэлбэг хэрэгслэлийн зардал хуваах систем нь тухайн ТҮКээс хамаарах бөгөөд дараах байдалтай байна. Үүнд:

- Хан-Уул ТҮК: Тухайн засвар үйлчилгээний зардал 50,000 төгрөгөөс бага байх тохиолдолд зардлыг жолооч хариуцах бөгөөд ТҮК-тэй хувааж гаргадаг байна.
- Сүхбаатар, Баянзүрх ТҮК: Компани, жолооч хоёр зардлыг хуваадаг.
- Баянгол ТҮК: Засвар үйлчилгээний зардлыг сар болгон цалингаас нь 3%-иар суутгаж жилийн эцэст үлдэгдэл мөнгийг жолоочид эргүүлэн олгодог байна.
- Налайх ТҮК: Жолооч нь 5000 төгрөгөөс доошх засвар үйлчилгээний зардлыг хариуцдаг бөгөөд түүнээс дээш гарсан зардлыг ТҮК хариуцдаг байна. Гэхдээ сэлбэг хэрэгслэл ихэвчлэн 5000 төгрөгөөс дээш үнэтэй байдаг тул ихэвчлэн ТҮК зардлыг төлдөг байна.

Дээрх систем нь зөвхөн ерөнхий засвар үйлчилгээг хамрах боловч техникийн ээлжит засвар үйлчилгээний ихэнх зардлыг ТҮК нь хариуцдаг боловч Баянгол, Хан-Уул, Чингэлтэй болон Налайх ТҮК нь зөвхөн фильтр, тос маслаар л хангадаг байна.

ТҮК-д машин төхөөрөмжийн засвар үйлчилгээний менежментийн хяналтыг хариуцах ажилтан нь жолооч нарын хяналт тавьж техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэх бус харин зардал тооцоог нь хариуцдаг байна.

с. Техникийн ээлжит засвар үйлчилгээ (тогтмол хийх үйлчилгээ)/ Ерөнхий үйлчилгээ (энгийн үйлчилгээ)

Энэхүү үйлчилгээг ихэвчлэн явсан зай (км) эсвэл хугацаа (цаг эсвэл сар) дээр үндэслэн зохицуулж хийдэг боловч тэрүү хугацааг сунгах, хойшлуулахын сацуу огт хийхгүй байх ч явдал гардаг байна. Ээлжит үйлчилгээний зардлыг жолооч нар хариуцах ёстой байдаг тул тэдгээр нь нэмэлт мөнгө төлбөр зарцуулах сонирхоггүй байдаг байна. Иймд үйлчилгээг хийвэл зохих хугацаанаас эсвэл явсан зайнаас нь хоёр дахин нэмэгдүүлэн хойшлуулж улмаар машин техникийн бүрэн бус байдалд нөлөөлж байнга эвдрэх явдал гардаг байна.

Дээрх асуудлуудыг гаргахгүй байлгах зорилгоор Баянгол, Хан-Уул, Налайх, Сүхбаатар ТҮК-д ээлжит засвар үйлчилгээний зардлыг гаргаж өгдөг байна.

Машины ерөнхий засвар үйлчилгээний ажлыг заримдаа жолооч өөрөө дүгнэлт гаргаж хийдэг байна. Мэргэжлийн түвшинд найдвартай зөвлөмж өгөх техникийн ажилтан байхгүй байдаг тул хийвэл зохих шаардлагатай техник үйлчилгээг цаг хугацаанд нь хийлгүй өнгөрөөчих боломж байна.

Түүнчлэн, заввар хийхэд шаардлагатай сэлбэг хэрэгслэл худалдан авах үнийн түвшин тогтоож өгсөн түрээсийн гэрээний систем нь (тодорхой хэмжээнээс дээш г.м.) жолоочийг ерөнхий засвар үйлчилгээний ажлыг чанартай гүйцэтгүүлэхэд хүндрэлтэй болгосон байна.

d. Байгууламж, багаж болон гарын авлага

Засварын цех гэж нэрлэж болох байгууламж болон багаж хэрэгслэлтэй цех ихэнх ТҮК дээр байхгүй байна. Жолооч нар өөрсдийн гар доорх багаж түллхүүр ашиглан засвараа хийдэг байна.

Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянгол, Баянзүрх, Налайх ТҮК-д нь гагнуурын аппараттай байв. Түүнчлэн Баянзүрх, Налайх ТҮК нь компрессортой, Баянзүрх ТҮК нь гаражийн зориулалтаар ашигладаг өргөгч домкраттай байсан боловч тохиргоо болон хэмжилт хийх зориулалтын тусгай багаж аль ч ТҮК-д байсангүй.

Монгол хэл дээр бичигдсэн техникийн гарын авлага огт байхгүй байв. ОХУ-ын техникийн сэлбэгийн каталог Монгол хэл дээр бичсэн байв. Япон машины хувьд зөвхөн Япон хэл дээр гарны авлага байсан бөгөөд тэрхүү машин нь зөвхөн Японы зах зээлд зориулж үйлдвэрлэсэн хуучин машин байв.

e. Боловсон хүчин болон мэргэжил дээшлүүлэх сургалт

Ихэнх ТҮК нь техникийн мэргэжлийн хүн байхгүй бөгөөд зөвхөн тоног төхөөрөмж хариуцдаг ажилтан жолооч нарыг зохицуулан удирдаж байв.

Засвар хийхэд туслах ажилчин буюу засварчин эсвэл гагнуурчин ажиллах боловч ихэнх ТҮК-д дээр техникийн мэргэжлийн ажилтан огт ажилдаггүй байв. Түүнээс гадна, машинаа засдаг ихэнх жолооч нар засварын ажлыг хэрхэн хийх тухай албан ёсоор суралцаагүй болно.

Механикч болон жолооч нарт зориулж сургалт хэрэгжүүлдэггүй бөгөөд зохион байгуулах төлөвлөгөө ч байхгүй байна.

f. Сэлбэг

Сэлбэг хэрэгслэлтэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- a) Японд үйлдвэрлэсэн компактор нь дотоодын зах зээлд зориулж үйлдвэрлэсэн байдаг тул машины сэлбэг, ялангуяа цахилгааны болон гидр өргөгчийн сэлбэг (нягтруулах эд ангийн хэсэг) олоход хүндрэлтэй байдаг байна.

- b) Тос, тормосны шингэн, маслын фильтр, түлшний фильтр зэрэг хамгийн наад захын шаардлагатай сэлбэгийн нөөц байхгүй.
- c) Шинэ сэлбэг хэрэгслэлийг хувь хүн эсвэл сэлбэгийн дэлгүүрээс худалдаж авдаг (техникийн захаас) тул чанар, аюулгүйн байдал нь нэлээд эргэлзээтэй байдаг байна.
- d) ОХУ-д үйлдвэрлэсэн машин болон хүнд даацын техникийн сэлбэг олдцотой боловч үнэтэй байдаг байна.
- e) Зарим ОХУ-ын сэлбэг нь үйлдвэрлэж нийлүүлэхгүй болсонтой холбогдуулаад олж авах огт боломжгүй болжээ.

g. Бүртгэл хөтлөх

Бүртгэл хөтлөх нь машин техникийн засвар үйлчилгээний менежментийг хийхэд хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Ихэнх ТҮК нь техник төхөөрөмжийн болон засвар үйлчилгээний бүртгэл хөтөлдөг боловч хоорондоо уялдаа холбоо муутай, менежмент нь сул байгаа нь харагдаж байна

Техник төхөөрөмжийн бүртгэлийг ТҮК болгон дээр өөр өөр аргачлалаар хөтөлдөг тул техникийн өнөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх нь маш хэцүү байна. Жолоочтойгоо гэрээгээр ажилдаг нэг ТҮК дээр засвар үйлчилгээний мөнгийг суутгаж тооцож байх зорилгоор бүртгэл хөтөлж байна.

h. Яаралтай авах арга хэмжээ

Яаралтай нөхцөл байдал үүсэхэд дараах арга хэмжээг авахыг зөвлөж байна. Үүнд:

- a) Машин техникийн өнөөгийн байдлыг амархан дүгнэж үнэлгээ өгөхийн тулд техник төхөөрөмжийн болон засвар үйлчилгээний бүртгэлийн баримт бичгүүдийг нэг загварт оруулж стандартлах.
- b) Тоног төхөөрөмж хариуцах ажилтан холбогдох бүх бүртгэлийг хөтлөх шаардлагатай.
- c) Машин техникийн өмчийн эзэн болох Улаанбаатар хотын захиргаа одоогоор ТҮК-ийн ашиглаж буй техникийн нөхцөл байдлын тухай ойлголттой болсон байх шаардлагатай.
- d) Одоогийн машин техникийн бүрэн бус байдлын (засварлах шаардлагатай болон сэлбэг хэргцээтэй) тухай жагсаалт гаргах шаардлагатай.
- e) Засварын ажлыг бага том гэлгүй тусгай төсөв гаргаж өгөх.
- f) Техникийн засвар үйлчилгээний хороо байгуулж тэрхүү авбал зохих арга хэмжээний талаар ярилцаж байх.

i. Дүгнэлт


Тоног төхөөрөмжийн үр ашигтай менежмент хийсэн тохиолдолд хог хаягдлын менежментэд шууд нөлөөлж сайжруулах болно.

Хотын захиргааны зүгээс ТҮК-ийн машин төхөөрөмжийн ашиглалтын стандарт (долоо хоног, сараар машины зохицуулалтын төлөвлөгөө, төхөөрөмжийн үйл ажиллагааны сар болгоны дүгнэлт) болон төхөөрөмжийн засвар үйлчилгээний журмыг (засвар үйлчилгээний нэгдсэн хугацаа бусд зүйлүүдийн, бүртгэл, засварын ажлын сарын тайлан зэрэг баримт бичгүүд) батлах шаардлагатай байна.


Төхөөрөмжийн ажиллагааны байдлыг дордуулж актлах хүртэл хүргэж буй ТҮК-дын байгуулж буй түрээсийн гэрээг даруй болиулах шаардлагатай байна (3-т тайлбарлав)

Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний системийг сайжруулах явдал нь аливаа хандивлагч орноос санхүүгийн дэмжлэг авахад зайлшгүй тавигдах нэг нөхцөл шаардлага болно.


Баянгол ТҮК

Нэгж	Төрөл	Нөхцөл байдал	Ажлын хүч/Мэргэшил				Засвар үйлчилгээ/Хуваарь /Материалын бүртгэл	Байгууламжууд		Сэлбэг
			Инж/Тех.	Механик	Туслах	Жолооч		Засварын цех	Багаж хэрэгсэл	
11 6 3 1 2 2 2	Самосвал (Орос) Компактор (Орос) Изуу, Мицуб. Ниссан Задгай тэвшгүй машин Орос ба Сууки Трактор (Компакт) -ачигч & бульдозер- дугуй өргөгч (Орос) Бохир машин (Орос) Цас& усны машин Бага оврын машин	11-Хангалттай 5-Хангалттай 1-Худалдах 3-Хангалттай 1-Хангалттай 2-Хангалттай 1-Хангалттай 2-Хангалттай 1-Хангалттай 1-Худалдах	0 Ханагч Жолооч	1 0 0 29	4 0 0 29	<ul style="list-style-type: none"> Урьдчилсан засвар үйлчилгээг км-ээр хийдэг (5000км бүр). Гэрээ дээр суурилсан засвар үйлчилгээний системтэй. Цалингаас сар бүр 3% -ийн хэсэг, сэлбэгийн зардалд шилжүүлдэг. Урьдчилсан засвар үйлчилгээний сэлбэгийг компани бэлтгэдэг. Тоног төхөөрөмжийн тайлан болон засвар үйлчилгээний дэвтэртэй. 	<ul style="list-style-type: none"> Гараж хангалттай зайтай. Бүрэн утгаараа засварын цех байхгүй. Цалингаас сар бүр 3% -ийн хэсэг, сэлбэгийн зардалд шилжүүлдэг. Урьдчилсан засвар үйлчилгээний сэлбэгийг компани бэлтгэдэг. Тоног төхөөрөмжийн тайлан болон засвар үйлчилгээний дэвтэртэй. 		<ul style="list-style-type: none"> Орос улсад үйлдвэрлэсэн сэлбэг авахад хялбар. Япон улсад үйлдвэрлэсэн компактторын сэлбэг авахад хүндэрлэлийг, учир нь тэдгээр машинууд дотооддоо хэрэглэхээр зориулагдсан. 	


Баянзүрх ТҮК

Нэгж	Төрөл	Нөхцөл байдал	Ажлын хүч/Мэргэшил				Засвар үйлчилгээ/Хуваарь /Материалын бүртгэл	Байгууламжууд		Сэлбэг
			Инж/Тех.	Механик	Туслах	Жолооч		Засварын цех	Багаж хэрэгсэл	
14 7 3 1 3 2 2 3	Задгай тэвшгүй машин (Орос) Компактор (Орос) Компактор (Изуу) Бохир машин (Орос) Цас& усны машин (Орос) Экскаватор (Орос) Үйлчилгээний машин Циорлогч/хууч машин	14-Хангалттай 7-Хангалттай 3-Хангалттай 1-Хангалттай 3-Хангалттай 2-Хангалттай 5-Хангалттай 3-Хангалттай	0 Засварчин Механик	1 1 4	4 1 39	<ul style="list-style-type: none"> Урьдчилсан засвар үйлчилгээг км-ээр хийдэг. Гэрээ дээр суурилсан засвар үйлчилгээний системтэй. Ердийн засвар үйлчилгээг хувааж төлөө ба компаниас компактторын сэлбэгийг гаргадаг. Зөвхөн засвар үйлчилгээний хувиралт хуулаас байдаг. 	<ul style="list-style-type: none"> Гараж хангалттай зайтай. (Засварын цех болон ашигладаг Тоног төхөөрөмж) 2- гагнуурын агрегат (авсаархан -Жердани) 1-ингтруулагч 1-нижний блок 1-гаралын домкрат 		<ul style="list-style-type: none"> Орос улсад үйлдвэрлэсэн сэлбэг авахад хялбар. Япон улсад үйлдвэрлэсэн компактторын сэлбэг авахад хүндэрлэлийг, учир нь тэдгээр машинууд дотооддоо хэрэглэхээр зориулагдсан. 	



Сонгинохайрхан ТҮК

Нэгж	Төрөл	Нөхцөл байдал	Ажлын хүч/Мэргэшил				Засвар үйлчилгээ/Хуваарь /Материалын бүртгэл	Байгууламжууд		Сэлбэг
			Инж/Тех.	Механик	Туслах	Жолооч		Засварын цех	Багаж хэрэгсэл	
19 2 1 6 1 1 2 1 1 2 2	Самосвал (Орос) Компактор (Изуу) Компактор (Мицуб) Компактор (Орос) Бохирын машин Задгай тэвшгүй машин Экскаватор Кран Дугуй өргөгч Мини трейллер Хяналтын машин	9-Сайн 10-Хангалттай Хангалттай Хангалттай 1-Сайн 4-Засвартай 1-Зарах Хангалттай Хангалттай Хангалттай Засвартай Сайн Хангалттай 1-Сайн 1-Зарах	0 Засварчин 1 Гагнуурчин	1 1 1 26	4 1 1 26	<ul style="list-style-type: none"> км & өдрөөр (1500км эсвэл 45 хоног бүр). Засварын ажлын бүртгэл (Төхөөрөмжийн бүртгэл) байхгүй. Жолооч засварын ажлыг гүйцэтгэдэг. 	<ul style="list-style-type: none"> Хангалттай зайтай ч (1500м2) засвар хийдэггүй. Зөвхөн 1- засвар хийх нүхтэй. 1-Гагнуурын агрегат 1-Rath машин 1- Өрмийн аппарат 1-Өргөгч кран 		<ul style="list-style-type: none"> Тосон болон төхөөрөмжийн эзэлгээний бүртгэл байхгүйн улмаас сэлбэг авахад хүндэрлэлийг. Ихэнх сэлбэгийг техникийн захсаг худалдан авдаг. 	



Сүхбаатар ТҮК

Нэгж	Төрөл	Нөхцөл байдал	Ажлын хүч/Мэргэшил				Засвар үйлчилгээ/Хуваарь /Материалын бүртгэл	Байгууламжууд		Сэлбэг
			Инж/Тех.	Механик	Туслах	Жолооч		Засварын цех	Багаж хэрэгсэл	
7 11 2 2 1 2 6 1 1	Самосвал (Орос) Задгай тэвшгүй машин (Орос) Компактор (Орос) Компактор (Изуу) Компактор (Мицуб) Универсал & жижиг трактор (Орос ба Ха.) Цас ба усны машин Бага оврын ачааны м Жийп	7-Сайн 1-Сайн 6-Хангалттай 4-Засварлах шаардлагатай 2-Засварлах шаардлагатай 2-Сайн 1-Сайн 2-Засварлах шаардлагатай Трактор (Орос ба Ха.) 1-Сайн 3-Засварлах шаардлагатай 2-Мехч байгуу Засварлах шаардлагатай Хангалттай	1 0 0 0 34	0 0 0 34	<ul style="list-style-type: none"> Бүх засвар үйлчилгээг жолооч гүйцэтгэдэг бөгөөд икшер нь зөвхөн жолооч нарыг хянадаг. Жолооч болон компани хооронд гэрээ байгуулах Сэлбэгийн зардал жолооч ба компани хувааж төлөх Төхөөрөмжийн бүртгэлийн дэвтэр болон засварын үйлчилгээний бүртгэлийн дэвтэртэй 	<ul style="list-style-type: none"> Засварын цех байхгүй, зөвхөн гаражтай. Засварын цехийн төхөөрөмж бүрэн хэмжээгээр байдаггүй. Гар багаж хэргээр дамгал Тохиргоо болон хэмжилт хийх тусгай багаж байхгүй Бүх гар багажыг жолооч зохицуулдаг. 		<ul style="list-style-type: none"> Тосон болон төхөөрөмжийн эзэлгээний бүртгэл байхгүйн улмаас сэлбэг авахад хүндэрлэлийг. 		




Хан-Уул ТҮК

Нэгж	Төрөл	Нөхцөл байдал	Ажлын хүч/Мэргэшил				Засвар үйлчилгээ/Хуваарь /Материалын бүртгэл	Байгууламжууд		Сэлбэг	
			Инж/Тех.	Механик	Туслах	Жолооч		Засварын цех	Багаж хэрэгсэл		
9	Задгай тэвштэй машин (Орос)	3-Сайн 5-Хангалттай	0	1	1	25	<ul style="list-style-type: none"> Урьдчилсан засвар үйлчилгээг км-ээр мийдэг. Гэрэн дээр суурицсан засвар үйлчилгээний системтэй. Компаннас тогтмол засвар үйлчилгээний сэлбэг болон ерийн засвар үйлчилгээнд 50000 тг. Гаргах бөгөөд бага мөнгө гаргах тохиолд, жолооч хариуна. 50000тг-өөс дээш зардалг компанийг хувааж төлнө. 	<ul style="list-style-type: none"> Засварын газар гэх газар байхгүй. Тонг төхөөрөмжгүй 	<ul style="list-style-type: none"> Гар багаж хязгаарлагдмал Тохиргоо болон хэмжилт хийх тусгай багаж байхгүй 	<ul style="list-style-type: none"> Төсөв болон төхөөрөмжийн эдлэлтний бүртгэл байхгүйн улмаас сэлбэг авахад хүндрэлтэй. 	
2	Компактор (Орос)	1-Сайн 1-Засварт			Засварчин 2	Гагнуурчин				<ul style="list-style-type: none"> Компактор (Орос) 	<ul style="list-style-type: none"> Усны машин
2	Компактор (Изуу)	2-Хангалттай									
1	Компактор (Мицуби)	1-Хангалттай									
1	Усны трактор	Засварт									
2	Усны машин	Сайн									
2	Бохир машин(Орос)	1-Хангалттай									
1	Усны машин	1-Засварт									
6	2-Үйлчилгээний машин 4-Бага орчин машин	2-Хангалттай 4-Сайн					<ul style="list-style-type: none"> Механик нь зөвхөн жолоочид хяналт тавих бөгөөд засварчин болон гагнуурчин жолоочид тусалдаг. Тонг төхөөрөмжийн тайлан болон засвар үйлчилгээний дэвтэртэй. 				






Чингэлтэй ТҮК

Нэгж	Төрөл	Тех. байдал	Ажлын хүч/Мэргэшил				Засвар үйлчилгээ/Хуваарь /Материалын бүртгэл	Байгууламжууд		Сэлбэг	
			Инж/Тех.	Механик	Туслах	Жолооч		Засварын цех	Багаж хэрэгсэл		
4	Компактор (ОХУ)	Хангалттай	1	1	0	29	<ul style="list-style-type: none"> Байгын засвар үйлчилгээг 6000 км тутам эсвэл улиралд нэг удаа хийдэг. Машин бүр дээр гаргасан эд анги, үйлчилгээг хийсэн тэмдэглэлийн дагуу эд ангийн менежментийг хийдэг. 	<ul style="list-style-type: none"> Үйлчилгээ хийх засварын байгууламж байхгүй Гаражийн зай хангалттай 	<ul style="list-style-type: none"> Гар багаж хязгаарлагдмал Зөвхөн 10-15 ш ам.түгшүүр Гар багаж хязгаарлагдмал (кольцо, бэхлэх, холбох түлхүүр) Бүх гар багаж жолоочид байдаг. 	<ul style="list-style-type: none"> Ихэнх сэлбэгийг техникийн захиас худалдан авдаг. Сэлбэгийн агуулах байдаггүй. 	
2	Компактор (Изуу)	Хангалттай									
12	Задгай машин(ОХУ)	Хангалттай									
1	Компактор(Ниссан)	Явахгүй									
1	Компа.(Мицубиши)	Хангалттай									
1	Бохир машин(ОХУ)	Хангалттай									
2	Цас, усны маш(ОХУ)	Хангалттай									
5	Бусад (жилий, хонго тэргэ, чиргүүл)	Хангалттай					<ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэсэн он: он-дугаар Компактор (ОХУ); 85-1, 00-1, 02-2 Компактор (Изуу); 91-1, 93-1 Задгай машин(ОХУ); 83-2, 84-1, 93-8, 99-1 Компактор(Ниссан); 94-1 Компактор(Мицубиши); 93-1 Бохир машин (ОХУ); 02-1 Цас, усны машин (ОХУ); 83-2 	<ul style="list-style-type: none"> Их засварын ажлын тодорхой хэсгийг хувийн засварын цехээр хийгддэг бөгөөд бусад байнгын болон их засварын зарим ажлыг өөрийн засварын цех дээр хийдэг. Ихэнх засварын ажлыг жолооч нар гүйцэтгэдэг. Төхөөрөмж түрээслэх гэрээ байхгүй 			<ul style="list-style-type: none"> Задгай тэвштэй машин (ОХУ) ба байгууламж байхгүй Гараж

Налайх ТҮК

Нэгж	Төрөл	Нөхцөл байдал	Ажлын хүч/Мэргэшил				Засвар үйлчилгээ/Хуваарь /Материалын бүртгэл	Байгууламжууд		Сэлбэг	
			Инж/Тех.	Механик	Туслах	Жолооч		Засварын цех	Багаж хэрэгсэл		
5	Задгай машин (Орос)	2-Хангалттай 3-Явахгүй болон	0	0	0	6	<ul style="list-style-type: none"> Урьдчилсан засвар үйлчилгээг км-ээр эсвэл сарар хийдэг. Төхөөрөмжийн гэрээ байхгүй, гэхдээ 5000тг-өөс доош сэлбэгийг жолооч, 5000 тг-өөс дээш зардалг компани хариуцдаг. Эгсэн хэдий ч ихэнх сэлбэг 5000 тг-өөс дээш үнэтэй байдаг тул компани ихэнхдээ төлдөг. Зөвхөн засвар үйлчилгээний хуваарь болон сэлбэг худалдан авсанг тэмдэглэсэн дэвтэр байдаг. 	<ul style="list-style-type: none"> Засварын цехгүй, гаражтай. Тонг төхөөрөмж 2- гагнуурын агрегат (авсаархан Асрдин) 1-инг-трүүлалч 1-гай машин 	<ul style="list-style-type: none"> Түлхүүр, мөбч, кольцо зэрэг бага хэмжээний багажтай. 	<ul style="list-style-type: none"> Оросод үйлдвэрлэсэн сэлбэг олоход хялбар боловч үнэтэй. 	
3	Чиргүүдтэй трактор (Орос)	2-Хангалттай 1-Явахгүй болон									
2	Уль-трактор (Орос)	1-Хангалттай 1-Явахгүй болон									
1	Жийн (Орос)	Хангалттай									
		Бүх төрөөрөмж нь Орос улсад үйлдвэрлэгдсэн ба ихэнх машины ашиглалтын хугацаа дүүрсэн (худалдан авснаас хойш болон эхний жилийг нь тэмдэглэсэнг хойш 15 жил өнгөртөй байгаа)	<ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэсэн он: жил-тоо Задгай машин; 89-1, 03-1 Чиргүүдтэй трактор; 89-1, 96-1 Ульн-трактор; 97-1 Явахгүй болсон машиныг тэмдэглээгүй. 								<ul style="list-style-type: none"> Ульн-трактор (Орос) Задгай машин (Орос) Гагнуурын агрегат

Нооц

Нэгж	Төрөл	Нөхцөл байдал	Ажлын хүч/Мэргэшил				Засвар үйлчилгээ/Хуваарь /Материалын бүртгэл	Байгууламжууд		Сэлбэг	
			Инж/Тех.	Механик	Туслагч	Жолооч		Засварын цех	Багаж хэрэгсэл		
3	Бульдозер (Орос)	2-Ажиллаж байгаа 3-Явахгүй болон	0	1	1	3	<ul style="list-style-type: none"> Цагар (200-300кг) Бүх засварын ажлыг хогийн төвлөрсөн цэг дээр гүйцэтгэдэг. Төхөөрөмжийн бүртгэлийн дэвтэр (засвар үйлчилгээний бүртгэлийн дэвтэр) нь тайлан байхгүй. 	<ul style="list-style-type: none"> Засвар үйлчилгээний цех байхгүй Гагнуурын агрегат нь хогийн төвлөрсөн цэг дээр байдаг. 1-Гагнуурын агрегат 1-Машин засварлахад По ачигч ашигладаг 	<ul style="list-style-type: none"> 1-Багаж хэрэгсэлтэй жижиг хайрцаг (жижиг хэмжээтэй штепель, түлхүүрүүдтэй) 	<ul style="list-style-type: none"> Ихэнх сэлбэгийг техникийн захиас худалдан авдаг. Сэлбэгийн агуулах байдаггүй. 	
1	По ачигч (Орос)	Ажиллаж байгаа									<ul style="list-style-type: none"> Дугуй өргөгч (По ачигч) Төхөөрөмж өргөхөд ашигладаг Багаж (Зөвхөн гар багажтай ба Хөдөлгөөнт гагнуурын машины засвар үйлчилгээний тусгай багаж байхгүй. Хөдөлгөөнт гагнуурын агрегат
1	Усны машин	Ажиллаж байгаа									
		* Ажиллаж байгаа ч техникийн шаардлагыг сайн хангахгүй байгаа Үйлдвэрлэсэн он: Бульдозер (1989-1, 1995-2), По ачигч (1989-1), Усны машин (2004-1)									
		Бульдозер					Т170 Бульдозер (Орос)				

3.3 Институдын тогтолцоо

Судалгааны явцад санал болгосон зөвлөмжийн дагуу байгууллага, институтын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоонд өөрчлөлт орсон бөгөөд энэхүү бүлэгт тайлбарлах

институтын бүтэц зохион байгуулалтын тогтолцоо нь 2005 оны 5 дугаар сарын байдлаар байгаа гэдгийг анхаарна уу.

3.3.1 Захиргаа, зохион байгуулалт

а. Оршил

Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежменттэй холбогдох гол байгууллага болон тэдгээрийн хоорондын харилцааг дээрх 1.2.1 дугаар бүлэгт дурьдсан бөгөөд илүү дэлгэрэнгүйгээр доор тайлбарлав.

б. Яам

2004 оны Улсын Их Хурлын 201 тоот тогтоолын дагуу Дэд бүтцийн яамны бүтэц өөрчлөгдөж хог байгуулалтын хөгжлийн бодлого болон хатуу хог хаягдлын менежментийн асуудлыг оролцуулан орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээний асуудлыг шинээр байгуулагдсан Барилга хот байгуулалт, хөгжлийн яам хариуцах болсон. Барилга, нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газар нь хатуу хог хаягдлын менежментийн бодлого, шинэ хуулийн төсөл боловсруулах, Засгийн газарт гадаад орны зээл тусламжийн асуудлаар зөвлөмж өгөх асуудлыг хариуцаж байна.

Өмнөх Засгийн газрын бүтцийн хүрээнд хот байгуулалтын бодлогын хэрэгжилтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар хариуцаж байсан шинэ бүтцийн хүрээнд Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв хариуцах болсон. Тэрхүү төв нь шинээр хатуу хог хаягдлын менежментийн үндэсний стандарт тогтоох болон менежментийн байдлыг сайжруулах зэрэг бодлогын хэрэгжилтийг шинээр хариуцах болсон боловч одоохондоо салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байна.

Байгаль орчны яам нь аюултай хог хаягдлын асуудлыг оролцуулан хатуу хог хаягдал байгаль орчинд нөлөөлөх байдлын асуудлыг хариуцдаг.

Эрүүл мэндийн яам нь дээрх 1.6 дугаар бүлэгт дурьдсан шинэ хууль эрх зүйн орчин бий болгох талаар нэлээд идэвхтэй ажиллаж байгаа. 2002 он хүртэл яам нь байнгын хяналтын ажлыг гүйцэтгэж байсан бөгөөд улмаар Ерөнхий сайдын дэргэд арван хяналтын байгууллагын үүрэг функцийг нэгтгэсэн Улсын мэргэжлийн хяналтын газар байгуулагдаж хяналтыг хариуцах болсон. Эрүүл мэндийн яам нь эмнэлгийн хог хаягдлын асуудал хариуцах бөгөөд тэрхүү хаягдлын асуудлыг судлахад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр эмнэлгийн хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгааг хийж гүйцэтгэсэн байна.


с. Хотын хэмжээний байгууллагууд

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хот тохижилтын хэлтэс нь Ерөнхий менежер болон НЗДТГ-ын даргад тайлагнах бөгөөд хэлтэст дараах 6 төрлийн байгууллага тайлагнана. Үүнд:

- 9 дүүргийн тохижилтын хэлтэс,
- 9 дүүргийн ТҮК,
- Нөөц компани,
- Ус сувгийн байгууламжийн компани,
- Ногоон байгууламжийн компани,
- Гэрэлтүүлэг чимэглэлийн компани.

Хот тохижилтын хэлтсийн 8 ажилтаны нэг нь хотын хэмжээнд хатуу хог хаягдлын менежмент, гурван ажилтан нэг нэг дүүргийн хатуу хог хаягдлын менежмент, ногоон


байгууламж, тохижилтын ажил хариуцахын сацуу Нөөц эсвэл Ус сувгийн байгууламжийн компани зэрэг бусад асуудлыг тус тус хариуцдаг (доорх зургийг үзэх). Бусад ажилтан нар нь Ногоон байгууламжийн компани, хотын нийтийн эзэмшлийн газар гэрэлтүүлэг реклам чимэглэлийн зөвшөөрөл олгодог Гэрэл чимэглэлийн компанийн үйл ажиллагаа, хэлтсийн статистик, нягтлан бодох зэрэг асуудлуудыг тус тус харицаж ажилладаг байна.



Зураг 3-12: ЗАА-ны Хот тохижилтын хэлтсийн зохион байгуулалтын бүтэц

1993 онд байгуулагдсан Нөөц компани нь өмнө нь металл болон яс зэрэг хоёрдогч түүхий эдийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэж байсан байна. Нөөц компани нь ЗАА-ны дэргэд хотын төсвөөс санхүүждэг байгууллага бөгөөд шууд Хот тохижилтын хэлтсийн харьяанд ажиллаж сар болгон тайлангаа хүргүүлдэг байна. Одоогийн байдлаар хогийн төвлөрсөн хоёр цэгийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Гол төлөв (1) хогийн цэг дээр ирж буй хогны машины бүртгэлийг тус тусын дүүрэг болон хогны төрлөөр хөтлөх; болон (2) хог хаягдлыг дарж нягтруулах ажлыг гүйцэтгэж байна.

Зураг 3-13-д компанийн бүтцийг үзүүлэв. Компани нь 17 ажилтантай. Улаанчулуут, Морин давааны хогийн төвлөрсөн цэг дээр тус тус ОХУ-д үйлдвэрлэсэн Т-170 маркийн бульдозер байдаг боловч бульдозерийн зөвхөн нэг оператортой. Бульдозерийн техникийн бүрэн бүтэн байдал нэлээд асуудалтай боловч тэрхүү хоёр бульдозерийг засаж сэлбэх хөрөнгө мөнгө шийдэгдсэн гэж ойлгож байна. Түүнчлэн нэг усны машин байгаа бөгөөд компанийн механик засварчин нь жолоодож цэг дээрх ажилчидад ус хүргэх, гал унтраах зэрэг ажилд оролцдог байна.




Зураг 3-13: Нөөц компанийн зохион байгууллагын бүтэц

Нөөц компанийн төсвийн зардал нь зах зээлийн эдийн засгийн зарчим баримтлах шаардлагатай бол орлого дээрээ компани нь үйлчилгээгээ өөрөө үнэлэх ямар ч эрх мэдэлгүй тул сүүлийн хэдэн жил төсвийн хүнрэлтэй ажиллаж ирсэн. 2004 оны санхүүгийн жилд хогийн цэг дээр хүлээн авсан нийт хог хаягдлын 17.5% нь гэрээгээр буюу байгууллагын хог хаягдал байсан бөгөөд тэдгээр байгууллагуудаас Нөөц компани дарж булах зардал гэж 250 төг/м³ –ийн нэхэмжилж авадаг бол компаний бусад үйл ажиллагааг шууд хотын төсвөөс санхүүжүүлдэг байна. 2004 онд хүлээн авах хог хаягдлын хэмжээ 280,000 м³ гэж тооцож төсвийн жилийн санхүүжилт нь 280 сая төгрөгөөр олгосон байна. 2003 онд нийт 298,000 м³ хог хаягдал хүлээн авсан байтал 2004 онд санхүүжилтийг 6%-иар бууруулсан нь ЗАА Нөөц компанийн үйл ажиллагаа багасах болно гэж урьдчилан тооцсон боловч бодит 2004 оны эцсийн байдлаар нэмэлт 28,000 м³ хог хаягдал дарж булсан бөгөөд тэрхүү нэмэлт зардлыг хотын төсвөөс санхүүжүүлтийг нь олгоогүй байна. 1999 онд түлшний үнэ нэг литр нь 280 төгрөг байхад Нөөц компани 1м³ хог хаягдлыг дарж булах зардалд 160 төгрөг төсөвлөж байсан бол хотоос зөвхөн 100 төгрөгөөр баталсан байна. 2004 оны 12 дугаар сарын байдлаар 1 литр түлшний үнэ 770 төгрөг болсон боловч компанийн нийт төсвийг хөдөлгөнгүй 100 төг/м³ хэвээр байхаар үлдээж одоог хүртэл тэр хэмжээндээ байна. Гэтэл бодит дарж булах зардал одоогоор 311 төгрөг байна гэсэн тооцоо гарсан. Нөөц компанийн ажилчдын сарын дундаж цалин нэг хүнд 60,000 төгрөг байгаа нь одоогоор нийт хотын хэмжээнд түүнтэй адилхан албан тушаалын цалингаас хамаагүй бага, өөрийн төсөв мөнгийг төлөвлөж зарцуулах эрх мэдэл байхгүй тул хэлэлцээ хийх чадвар сул, нийт хотын хэмжээнд ингэж гадуурхагдаж байгаа цорын ганц компани юм. Иймд тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал хангалтгүй байгаад гайхах зүйлгүй бөгөөд компанийн боловсон хүчин нь байнга солигдож тогтвортой ажилдаггүй байна. Улаанбаатар хотын захиргаа нь саяхнаас Нөөц компанийн хог хаягдлыг дарж булах 1 м³ зардлыг 100 төгрөгөөс 300 төгрөг хүртэл нэмэгдүүлж баталсан гэж ойлгож байна.


Усны байгууламж компани нь үерийн ус зайлуулах суваг, Ус, суваг ашиглалтын газар нь гэр хорооллын усны хангамж болон газар доорх шугам сүлжээ хариуцдаг байна. 2004 оны төсөв нь 50 сая төгрөг байсан бөгөөд түүнээс 10 сая төгрөгийг насосны засвар үйлчилгээнд зарцуулсан байна. Компанийн захирал болон туслах ажилтан нараас гадна 14 байнгны ажилтантай. Тэдгээрээс 2 инженер нь нэг насосны станцын 4 насос хариуцан ажиллаж 3 засварын ажилчин нь 45 км урттай усны шугам сүлжээ, нийт 700 бохир усны нүхний засвар үйлчилгээг хариуцдаг байна. Жил болгон 4 дүгээр сараас 7 дугаар сарын хоронд 18 улирлын чанартай ажилчид хөлсөлж борооны ус зайлуулах системийг цэвэрлүүлдэг бөгөөд түүндээ нийт 3 сая төгрөг зарцуулдаг.

2005 онд Ногоон байгууламж компанийн жилийн төсөв 30 сая, Гэрэлтүүлдэг чимэглэл компанийн төсөв нь 125 сая төгрөг тус тус байв.

Улаанбаатар хотын захиргааны хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Байгаль орчныг хамгаалах газар нь нийслэлийн хөрс, агаар, ус, ногоон байгууламж зэрэг байгаль орчны зохистой ашиглалтыг хангах, хамгаалах, нөхөн сэргээх үүрэгтэй газар юм. Үйл ажиллагааны ерөнхий үүрэг функцийг доорх зурагт үзүүлэв. Байгаль орчин хамгаалах асуудлаар нийслэлийн албан ёсны байр суурийг илэрхийлж ойжуулах, дахин ойжуулах, ойн аж ахуйн бүтээгдэхүүний ашиглалт, газар нөхөн сэргээх, гал унтраах, хортой шавьж устгал хийх зэрэг асуудлыг хариуцахын сацуу цаашид хуучин хатуу хог хаягдлын төвлөрсөн цэгийн нөхөн сэргээлтийн асуудлыг хариуцах төлөвтэй байна. Түүнчлэн хууль бус хог хаях явдал зэрэг асуудлыг хаянаж байх үүрэгтэй боловч хатуу хог хаягдлын мненемтийн үйл ажиллагаанд оролцдоггүй байна. Байгаль орчин хамгаалах асуудлаар Байгаль орчны яаманд тайлагнаж менежментийн асуудлаар ЗАА-д тайлагнадаг байна.



Зураг 3-14: Нийслэлийн Байгаль орчин хамгаалах газрын үндсэн үйл ажиллагаа



Зураг 3-15: Нийслэлийн байгаль орчин хамгаалах газрын бүтэц

Нийслэлийн байгаль орчин хамгаалах газар нь байгаль орчны үнэлгээний тухай хуулийн дагуу холдогдох төсөл, арга хэмжээнд үнэлгээг өгөх ажилд оролцохын сацуу тухайн үнэлгээний тайланг батлах, шинэчлэх, буцаах зэрэг асуудал дээр саналаа өгдөг байна. Стогколын конвенцийн дагуу дүүргүүдийн хамт жилд хоёр удаа аюултай, жилд нэг удаа байгаль орчинд удан ялзардаг хог хаягдлын талаар судалгаа хийдэг байна.

Дээрх зургийн дагуу Нийслэлийн байгаль орчин хамгаалах газрын боловсон хүчний тоог үзүүлсэн бөгөөд нийт 41 албан хаагчаас 33 нь байгаль орчин хамгаалах байцагч нар бөгөөд нэг цагдаа газрын бүтцэд орж ажилладаг байна. Цагдаагийн албан тушаалын хүн ажиллууснаар холбогдох торгуулийн арга хэмжээг үр дүнтэй авах бололцоо бүрддэг байна. Ерөнхийдөө хууль бус хог хаядал хаях этгээдэд арга хэмжээ авч саналга өгөх боловч үндсэн үүрэг функц нь биш юм.

Нийслэлийн өмчийн харилцааны газар нь ТҮК-иудын ашиглаж буй хөрөнгийн эзэмшигч бөгөөд менежментийн гэрээний нэг тал болон гарын үсэг зурдаг.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар нь 2003 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын “хуулийн хэрэгжилтийг хангах” 7 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 39 дүгээр тогтоол, Улсын мэргэжлийн хяналтын газрын 29 дүгээр тогтоолоор байгуулагдсан. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар нь улирал болгон ЗАА-нд, жилд хоёр удаа Улсын мэргэжлийн хяналтын газарт тус тус тайлагнадаг байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар нь тухайн салбарын бодлого, үйл ажиллагаанд санал өгөх эрхтэй байдаг. Жишээлбэл, одоогоор барилга барих тусгай зөвшөөрөл олгох болон хяналт хийхэд ухсан шороог хэрхэх болон ухсан газрыг хэрхэн нөхөн сэргээх асууудлаар нарийвчилсан төлөвлөгөөг оруулж байхыг Байрилга, хот байгуулалтын яаманд саналаа хүргүүлээд байна. Хуулийн дагуу түүний хотын хэмжээнд хэрэгжилтийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар хангах бөгөөд зарим хотын хэмжээнд болон хөдөө орон нутагт Монгол Улсын хууль журмын хэрэгжилтийг Улсын мэргэжлийн хяналтын газар хариуцаж хангадаг байна.

Нийт 21 тусгай газар, агентлагийг нэг дор нэгтгэж таван хэлтэстэй, нэг лаборатори, 214 байцагчидтай газар болгожээ. Доор зургийн дагуу Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын бүтцийг үзүүлсэн бөгөөд бүтцийн дагуу Байгаль орчин, дэд бүтцийн хяналтын хэлтэс нь ерөнхий, үйлдвэрийн болон аюултай хог хаягдал, Нийтийн эрүүл мэндийн хяналтын хэлтэс эмнэлгийн хог хаягдлын эх үүсвэрийн хяналтыг тус тус хийдэг байна. Тэрхүү хэлтэс нь хоёр хэсэгтэй бөгөөд нийт 36 байцагчидтай. Дэд бүтцийн хэлтэс нь 21 байцагчидтай, инженерийн байгууламж, барилга, тээвэр, холбоо, эрчим хүчний хяналтыг хариуцдаг байна.



-Зөвхөн Байгаль орчин, дэд бүтцийн хяналтын хэлтсийг дэлгэрэнгүй үзүүлэв.

Зураг 3-16: Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын бүтэц

Байгаль орчны хэлтэс нь 15 байцагчидтай бөгөөд тэдгээр нь байгалийн нөөц баялаг, хөрс, ургамал, агаарын чанар, ойн, газар, ан агнуур, геодези зэрэг салбарт 6 олон улсын конвенц, 33 хууль, 300 орчим журмын хэрэгжилтийг хангаж хаянах үүрэгтэй. Байцагч нар тус тусын холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангаж байдаг бөгөөд нийт 15 байцагчийн 7 байцагч нь автын пост дээр хууль бус мод, арьс шир хог руу тээвэрлэж оруулах явдлыг хянах ажлыг гүйцэтгэдэг. Ерөнхий болон хатуу хог хаягдлын хяналтыг зөвхөн нэг хүн хариуцдаг бөгөөд тэрхүү байцагч нь хөрсний бохирдолын нэн чухал асуудлууд болох арьс ширний үйлдвэрээс гарах хортой лаг, мах боловсруулах үйлдвэрийн хаягдал зэрэг асуудлуудыг мөн хариуцаж байна.

Тухайн жилийн төлөвлөгөө, хатуу хог хаягдлын хяналт болон байгаль орчныг сайжруулах арга хэмжээг жилийн эхний 10 хоногт бэлтгэж гаргадаг байна. Тэрхүү төлөвлөгөөг сар, улирлаар нарийвчлан гаргадаг байна. Газар дээр нь очиж танилцах асуудлууд гардаг боловч өдөр тутмын хяналтын ажлыг зохион байгуулах боломжгүй юм. Түүнчлэн төлөвлөгөөт ажлаас гадуур тухайн цаг үед нь шийдвэрлэх шаардлагатай, ялангуяа иргэд, ТҮК-ниас ирж байгаа барилгын хууль бус хог хаягдлын талаарх гомдол саналын дагуу ажилладаг байна.

d. Дүүргийн бүтэц, зохион байгуулалт

Дүүргийн тохижилт, үйлдвэр үйлчилгээний хэлтэс нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн хатуу хог хаягдлын менежментийг хариуцдаг. Ажлаа тус тус дүүргийн Засаг даргад тайлагнах бөгөөд ЗАА-ны зүгээс хатуу хог хаягдлын менежментийн талаар хяналт хийж заримдаа ЗАА-тай хамтран түүний дэмжлэгтэйгээр тохижилтын ажлыг гүйцэтгэдэг байна. Дүүргийн тохижилт хариуцсан ажилтан нь жилд дөрвөн удаа нийтийн эзэмшил газрын тохижилт, нийтийн тохижилт цэвэрлэгээний ажлыг оролцуулан хатуу хог хаягдлын асуудлаар ЗЗА-д тайлангаа хүргүүлдэг байна.

Дүүргийн Засаг даргын тамгын газрын бүтцийг Засгийн газрын тогтоолоор батлах боловч амьдрал дээр тогтоосон бүтцээс өөр байдаг байна. Жишээлбэл, Хан-Уул дүүргийн хувьд ОСНААГ-ын харьяа байгууллагуудыг давхар хариуцаж ажилладаг байна (доорх зургийг үзэх). Гэхдээ хэлтэс болгон үндсэн 5 ажилтантай. Үүнд: (1) хэлтсийн дарга, Сүхбаатар дүүргийн хувьд хэлтсийн дарга нь үйлдвэр үйлчилгээний (үсчин гэх мэт) салбарын ажилтан давхар хариуцдаг; (2) худалдаа хариуцсан мэргэжилтэн, (3) зочид буудал, ресторан зэрэг бизнесийн аж ахуйн нэгж, (4) дэд бүтэц, (5) дүүргийн тохижилт, байгаль орчин, хатуу хог хаягдал асуудлыг хариуцсан тус тусын мэргэжилтэнгээс бүрдэнэ.

Дүүргийн хатуу хог хаягдлын асуудлыг, тэр дундаа орон сууц, гэр хороолол болон албан байгууллагын хог хаягдлыг дүүрэг бүрийн ТҮК цуглуулж үйл ажиллагааг нь хангадаг байна. Сүхбаатар дүүргийн хувьд бусад ТҮК-дтай харьцуулахад машин техник хангалттай боловч албан ёсоор машины техник хангалтгүй гэдэг шалтгаанаар ТҮК-ийн оролцоогүй бие даасан хатуу хог хаягдлын менежментийн бие даасан систем ажилладаг байна. Дүүргийн 6 гэр хорооллын хувьд Тохижилтын хэлтэс нь тухайн хариуцах нутаг дэвсгэр дээрээ иргэд олон нийтэд мэдэгдэхүйц үйл ажиллагаа явуулж буйг харуулахын тулд тус тусын хорооны засаг дарга нартай нэлээд санаачлага гарган идэвхтэй ажиллах шаардлагатай. Жишээлбэл, шоронгийн хоригдол, түр хорионд орсон архичид нарыг ашиглаж цэвэрлэгээ хийлгэх болон оюутан сурагч нарын дунд элдэв арга хэмжээ, тэмцээн зохион байгуулан орчны цэвэрлэгээ тохижилтыг хийдэг боловч тэрхүү нийтийн хамарсан цэвэрлэгээний дараа удалгүй цэвэрлэсэн газар хог шороондоо дарагддаг байна.

Доорх зураг-т Хан-Уул болон Сүхбаатар дүүргийн ТҮК-ийн зохион байгуулалтын бүтцийг үзүүлэв. Дүүрэг болгон ТҮК-ийг коммунист үеийн үүрэг функцийн системтэй хүлээж авсан. Үүнд: 1. Зам гудамжны эд хогшил, ногоон байгууламжийг сайжруулан тохижилт үйлчилгээг хангах; 2. Нийтийн эзэмшил бүсийг цэвэрлэх; 3. Хатуу хог хаягдлын менежмент зэрэг болно. ТҮК-ийн институтын бүтцийг илүү нээлттэй,

чөлөөтэй болгох алхамыг 2004 оны 3 / 4 дүгээр сараас эхлүүлж гурван жилийн хугацаанд тухайн бизнесийг дангаараа эрхлэх эрхийг нь олгож менежментийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Гэрээнд Засгийн газрын зүгээс гурван тал оролцож гарын үсэг зурна. Үүнд: (1) ЗАА-ны Хот тохижилтын хэлтэс; (2) Хогны машин зэрэг Нийслэлийн өмч хариуцах Нийслэлийн өмчийн харилцааны газар; (3) холбогдох дүүргийн тохижилт, үйлдвэр, үйлчилгээний хэлтэс. ТҮК нь жилд хоёр удаа эдгээр байгууллагуудад тайлагнах бөгөөд тухайн үед шинэчилж өөрчлөх асуудлыг хэлэлцдэг байна. Хотын хөрөнгийг өмчийн асуудлыг Нийслэлийн өмчийн харилцааны газар хариуцдаг байна. Чингэлтэй ТҮК нь эдгээр компаниудын нийтлэг хэв шинжийг агуулсан компани бөгөөд компани нь өмнөх засаг төрийн тогтолцооноос хүлээн авсан тогтолцоо буюу машины парк, төв албан контор, засварын цех, болон гаражийг үнэ төлбөргүй түрээслэдэг бол Чингэлтэй ТҮК нь дүүргийн байрны подвал ашигласны түрээс төлдөг байна. Хан-Уул ТҮК нь бусад компаниудтай харьцуулахад хөрөнгийн менежмент нь арай өөр бөгөөд компанийн албан конторын байранд 3 дугаар хорооны цагдаагийн удирдлага болон бусад байгууллагууд байрладаг байна. Түүнчлэн Хан-Уул ТҮК нь гаражтай, 30 орчим хогны машинтай бөгөөд тэдгээрээс 19 нь 2003 онд худалдаж авсан 2-4 тонны даацтай Ниссан маркийн компактор машинууд байна. Тэрхүү хөрөнгө нь компанийн нэр бүртгэгдсэн гэж ойлгогдож байгаа боловч худалдан авах тохиолдолд зөвхөн барьцаа хийсэн төдий байдалтай байна. Компани байгуулагдсанаас хойш нэмэлт хөрөнгө орж бүртгэгдээгүй байна.

Дүүргийн төсвөөс гудамжны эд хогшил, ногоон байгууламжийг сайжруулан засаж арчилах, нийтийн эзэмшил газрыг цэвэрлэх зэрэг ажлуудыг санхүүжилдэг бол хатуу хог хаягдлын менежментийн зардлыг дараах эс үүсвэрээс санхүүжүүлдэг. Үүнд:

- ОСНААГ-аар дамжуулан орон сууцанд оршин суух иргэдийн төлбөр;
- байгууллагатай гэрээ байгуулж шууд хийх төлбөр;
- гэр хорооллын иргэдийн шууд төлбөр.

Зам талбайн цэвэрлэгээ болон ногоон байгууламжийн талаар хийсэн тайланг Хан-Уул ТҮК нь Тохижилт, үйлдвэр, үйлчилгээний хэлтсийн дарга бус дүүргийн Засаг даргад тайлагнаж, хэлтсийн дарга нь менежментийн төлөвлөгөөг хянаж, Засаг дарга нь ажлын төлөвлөгөөний биелэлтийг хаянадаг байна.

Тухайн дүүргийн төрийн болон аж ахуйн нэгж болгон дүүргийн ТҮК-тай хатуу хог хаягдлын менежментийн гэрээг байгуулдаг. Хан-Уул ТҮК нь 285 гэрээтэй байдаг бол Сонгинохайрхан дүүрэг нь 1450 гэрээ байгуулж өдөр тутам эсвэл гэрээний нөхцлийн дагуу хог хаягдлыг нь цуглуулах үйлчилгээ үзүүлдэг байна. Гэрээнд тусгадаг дундаж төлбөр 100,000 орчим төгрөг байдаг бол Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд дундаж нь 35,000 төгрөг, Баянзүрх дүүрэгт 230,000 төгрөг байдаг байна. Байгууллагууд өндөр үнэтэй төлбөр нэхдэг талаар нэлээд гомдол гаргахын сацаа өндөр байшинд олон байгуулага түрээслэн байрлаж нийтийн хогны сав ашиглах тохиолдолд жижиг ААН-ээс төлбөр авах нь нэлээд хүндрэлтэй байдаг байна.

Орон сууцны оршин суугчид нэг хүн 200 төгрөг сард төлдөг бөгөөд сүүлийн гурван жил ийм тарифтай байна Орон сууцны оршин суугчдын хогны төлбөрийг одоогоор хувьчлагдсан байгаа ОСНААГ-ын харьяа байгууллагууд хурааж 4%-ийн шимтгэл авдаг байна. Үлдсэн хувийг ТҮК-д шилжүүлэх бөгөөд төлбөрийн нийт дүнгийн 8%-ийг орон сууцны байрны орчимын нийтийн эзэмшлийн газрыг цэвэрлэхэд зориулдаг байна. Ерөнхийдөө ТҮК болгон 150 орчим хогны савтай бөгөөд ихэвчлэн өдөр тутам тэдгээрээс хог хаягдлыг нь цуглуулдаг. Хогийн төвлөрсөн цэг рүү явах дундаж зай нь Сүхбаатар дүүргийн ТҮК-ийн хувьд 29км бөгөөд нэг 3.5м³ / 5 тонн машин нь 18-25,000 орчим төгрөг зардалг гардаг гэж хэмээж байна.


Гэр хорооллын хог хаягдлал цуглуулах үйлчилгээ нь сард нэг удаа, шууд хашааны хаалганаас нь ачдаг систем одоо үйлчилж байна. Ихэнх иргэд хог хаядаг түр цэг дээр

хогоо хаясан талаар үгүйсгэж үйлчилгээний төлбөр төлөхөөс дургуйцдаг тухай судалгаагаар тогтоодсон бөгөөд ерөнхийдөө хогны төлбөрийг хог хаягдал ачсан өдрийн орой нь хураадаг байна. Хашаанаас гарах нүүрс, түлээний үнсийг нүүрс худалдан авдаг тааранд хийж хаядаг байна. Чингэлтэй ТҮК-ийн захирал Хорооны Засаг дарга нартай тохирч иргэд, оршин суугч нарт хог хаягдал ачих хугацааг урьдчилан зарлаж улмаар хогоо хашаанасаа гаргаж тавих талаар ажил зохион байгуулсан байна. Тийм арга хэмжээ авахгүй тохиолдолд иргэд дуртай цагтаа хогоо хаяж, хашаа хороо хоосон хүнгүй байхад хог түүгч нар болон мал нохой хог хаягдлыг замбараагүй гудамжаар тараах явдал гардаг байна. Зарим гэр хорооллын айлууд өвлийн улирал болон газар хувьчлагдаж зах зээлийн эргэлтэнд орсноор иргэд хашаагаа аль болох том хэмжээтэй барих зорилгоор гудамжийг хэт нарийн болгож хогны машин нэвтрэх боломжгүй, хэдэн зуун метрийн цаанаас буцаж үйлчилгээ үзүүлэх боломжгүй болгодог байна.


Жил болгон дүүргийн гэр хорооллын зүгээс хог хаягдлын төлбөрөө төлөх чадваргүй, улмаар тэдгээрийг шахааж шаардаж болохгүй айл өрхүүдийн жагсаалтыг гаргадаг байна. Бусад төлбөр төлвөл зохих өрхүүдээс хураах хувь хэмжээ бараг 100%-тай байдаг байна. Хорооны Засаг дарга нар төлбөр хураах ажилд туслах үүрэгтэй боловч ихэнх тохиолдолд тэрхүү үйл ажиллагаанд оролцохгүй байна. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар албан ёсоор хогны төлбөрийн хэмжээг 700-1,000 төгрөг гэж хэдэн жилийн өмнө тогтоосон бол бодит байдал бол хамгийн доод хэмжээ нь 1,000 төгрөг ба хог хаягдал ихээр гаргадаг этгээдэд түүнээс дээш хэмжээ ногдуулдаг байна. 2004 оны 11 дүгээр сарын 15-наас Чингэлтэй ТҮК түлш болон сэлбэг хэрэгслэлийн үнийн өсөлтийг зардалдаа тусгах зорилгоор хогны төлбөрийг 1,000-аас 2,300-3,500 төгрөг хүртэл огцом нэмэгдүүлсэн буюу иргэдийн зүгээс, үйлчлүүлэгчийнхээ хувьд аливаа эсэргүүцэл гараагүй гэж хэмээв. Үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэхэд аливаа захиргааны шийдвэр гаргуулах шаардлаггүй гэж Чингэлтэй ТҮК-ийн захирал үзэж байна.

Хатуу хог хаягдлын менежментийг гэрээгээр гүйцэтгүүлэх болон хатуу хог хаягдлыг үнэ төлбөргүй зайлуулах талаар ТҮК-д эн тэндээс даралт шахалт ирж байна


ТҮК-ийн үндсэн мэдээлэл дээр хийсэн судалгаанаас харахад Хан-Уул болон Чингэлтэй ТҮК-ийн хувьд бохирын хог хаягдал цуглуулан тээвэрлэх ажлын хэмжээ нь гэр хорооллын хог хаягдал зайлуулах ажлын хэмжээнээс их байгаа нь харагдаж байна. Хан-Уул ТҮК гэхэд л 2004 оны сүүлийн хагас жилийн байдлаар хотын шугам сүлжээнд холбогдоогүй Яармагийн бүс орчимоос зөвхөн сургууль болон бусад байгууллагуудын бохирын хог хаягдлыг цуглуулах зорилгоор нийт 1,923 рейс буюу 11,538м³ хаягдал тээвэрлэжээ. Бохир хог хаягдлыг хотын цэвэрлэх байгууламжинд тэвэрлэж байна.



Зураг 3-17: Хан-Уул дүүргийн Төхижилт, үйлдвэр, үйлчилгээний хэлтсийн бүтэц



Зураг 3-18: Хан-Уул дүүргийн ТҮК-ийн бүтэц



Зураг 3-19: Сүхбаатар дүүргийн ТҮК-ийн бүтэц

е. ТББ-д

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Дэлхийн зөн байгууллага нь урт хугацаад төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд одоогоор 6 жилийн турш үйл ажиллагаа явуулаад байна. 2003 оны 9 дүгээр сард ЖАЙКА-ийн хүрээнд Дэлхийн зөн байгууллага нь Улаанбаатар хотын агаарын бохирдолыг багасгах талаар ТЭЗҮ судалгаа хийжээ.

Судалгааны бүсийн суурь судалгаа хийсний үндсэн дээр Дэлхийн зөн эмзэг бүлгийн иргэдийг хамруулсан таван жилийн хөтөлбөр бэлтгэсэн бөгөөд төслийн хүрээнд хамрагдах иргэдийн 80% нь ядуу иргэд байна. Монгол Улсад хэрэгжүүлэх хөтөлбөр нь дараах зургаан чиглэлтэй байна. Үүнд:

1. Эрүүл мэнд – хүүхдийн эндэгдэл, гэр хорооллын оршин суугчдын бичил орчин г.м.,
2. Боловсрол – сургуулийн өмнөх насны хүүхдийг хамруулах, сургуулийн менежмент, ёс зүй г.м.,
3. Орлого нэмэгдүүлэх – бизнесийн сэтгэлгээтэй ядуу иргэдийг сургалтанд хамруулж зээл олгох г.м.,
4. Иргэний нийгэм – иргэдийн өөрсдийн удирдах чадвар г.м. тогтвортой хөгжлийн хөтөлбөр,
5. Байгаль орчин – ирээдүйд энэхүү салбарт нийтийн анхаарал татах: мод зүлэг тарих, хатуу хог хаягдлын менежмент, агаарын бохирдол, бохирын систем, газар ашиглалтын асуудлууд,

6. Хүүхдийн эрх ба өмгөөлөл – орон гэргүй хүүхдийн эрхийг хамгаалах, хоригдол хүүхэд болон бусад шоронгийн хоригдол нарыг буцаан энгийн нийгэм амьдралд оруулах. Түүнчлэн хүүхдийн өөрсдийн удирдан зохион байгуулах чадварыг нэмэгдүүлэх.

Монголын уламжлалт нийгэмд олон нийтийн хамтын ажил нэг их хүчтэй байдаггүй боловч Дэлхийн зөнгийн иргэдийн дунд явуулах арга хэмжээ нь ерөнхийдөө иргэдийн хамтын ажиллагаан дээр үндэслэх бөгөөд тэдгээрийн туршлагаас харахад хэрэв иргэд, олон нийтийг тухайн нэг төсөл арга хэмжээний зураг төсөл болон барилга угсралтын ажилд анхнаас нь идэвхтэй оруулцуулах тохиолдолд ашиглалтанд орсоны дараа иргэд, оршин суугчид тухайн байгууламжийг хайрлан хамгаалж арчилдаг нь ажиглагдаж байна. Одоогоор Монголд Дэлхийн зөнгийн 12 олон нийтийн иргэдийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн 6 нь Улаанбаатар хотын гэр хороололд үйл ажиллагаа явуулж байна. Дээрх 6 байгууллагуудын идэвхтэй, гишүүнчлэлийн төлбөр төлдөг гишүүдийн тоо 5,000 хүрч тухайн орон нутгийн нийт хүн амын 5-10% төлөөлж байна. Үүнд:

- Баянзүрх дүүрэгт – гэр хорооллын нийт хороодод (2 иргэдийн олон нийтийн байгууллага);
- Сүхбаатар дүүрэгт – гэр хорооллын бараг нийт хороодод (1 иргэдийн олон нийтийн байгууллага);
- Налайх дүүрэгт - гэр хорооллын нийт хороодод (1 иргэдийн олон нийтийн байгууллага);
- Сонгинохайрхан дүүрэгт– 21 хорооны 15-д, өөрөөр хэлбэл бараг бүх хороодод (2 иргэдийн олон нийтийн байгууллага);
- Хан-Уул болон Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаагаа эхэлж байна.

Дэлхийн зөн нь хатуу хог хаягдал цэвэрлэх кампанит ажил зохион байгуулах, хатуу хог хаягдлын менежментийн талаар иргэдийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх, зарим хороодод хог хаягдал цуглуулах цэг байгуулж ТҮК болон иргэдийн олон нийтийн байгууллагуудад цаашдын үйл ажиллагааг хангуулахаар хүлээлгэн өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулав. Түүнчлэн Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн хог түүгч, ялангуяа, хүүхдүүдийн дунд тодорхой ажил зохион байгуулсан байна. Ихэнх хог түүгчид гэр оронгүй, хөдөөнөөс ирсэн бичиг баримт, бүртгэлгүй, хотод садан төрөлгүй хүмүүс байдаг тул тэдгээр хүмүүсийг нийгэм энгийн амьдралд буцаан оруулах зорилго тавин ажиллаж байгаа юм байна. Дэлхийн зөн нь хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах буюу рисайкл үйл ажиллагаан дахь оролцоо нь бага боловч өөрсдийн байгуулсан иргэдийн олон нийтийн байгууллагуудыг өөр төрийн бус байгууллагатай хамтран ажиллахыг санал болгож ногоо хураах ажлын дараа шилэн савыг уурамшуулалттай цуглуулах ажлыг зохион байгуулсан боловч цаашид хог хаягдлыг анхан шатанд ангилан ялгуулах талаар сонирхож болох бөгөөд тэрхүү саналыг ЖАЙКА-д тавьж хамтран ажиллахыг дэмжих болно.

“Тогтвортой хотуудын олон улсын төв” ТББ нь “Улаанбаатар хотын хог түүгчдын нөхцлийг сайжруулах” төслийг боловсруулан одоогоор төслийн хэрэгжилтийг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрэлхийлж байна (2004 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар). Тэрхүү байгууллага ижил төрлийн төслийг Зүүн Өмнөд Азид хэрэгжүүлж байсан туршлагатай (Зүүн Өмнөд Азийн орон нутгийн хатуу хог хаягдлыг сайжруулах төсөл-SEALSWIP) бөгөөд холбогдох байгууллагуудад түншилж хэрэгжүүлэх санал тавьдаг.

Хатуу хог хаягдлын менежментийн талаар ажилладаг бусад ТББ-ын дундаас үйлчилгээний байгууллагуудын хог хаягдлыг ангилан ялгуулах талаар цэнхэр уутны кампанит ажил зохион байгуулж байсан Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Байгаль

Эрдэнэ сан, ДБХС, Туул 21, Ариун орчин, Монголын экологчдын холбоо, Сууц өмчлөгчдийн үндэсний зөвлөлдөх хороо зэрэг болно.

f. Хоёрдогч түүхий эд авах жижиг хэмжээний компани ба албан бус сектор

ДЭМБ-ын судалгаагаар Улаанбаатар хотын нийт хог хаягдлын 20-30 орчим хувийг дахин ашиглаж боловсруулах боломжтой гэж тооцон үзжээ. 2003 онд Хотын захиргаанаас 100,000 хогны уутыг 4 сая төгрөгөөр худалдан авч ТҮК-ээр дамжуулан иргэд оршин суугч нарт төрөл төрлийн хог хаягдлыг ангилан ялгуулахаар тараасан боловч тэрхүү арга хэмжээ нь бүтэлгүйтэж ихэнх тараасан уут алга болсон байна.

Хатуу хог хаягдлын менежментийн салбарт албан бусаар үйл ажиллагаа явуулж агентууд нь одоохондоо институц, зохион байгуулалтанд ороогүй хатуу хог хаягдлын менежментийн салбарын нэг бүрэлдэхүүн хэсэг боловч яваандаа цаашид төлөвшиж албан ёсны бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжтой. Ялангуяа, хог түүгч болон гудамж, орон сууцны бүс нутагт шил авдаг хүмүүс хоёрдогч түүхий эд ангилан цуглуулж ченжүүдэд худалдах бөгөөд хоёрдогч түүхий эдийг рисайл хийж буй цөөн хэдэн жижиг бизнес идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор тэрхүү хоёрдогч түүхий эдийн зах зээлд үйл ажиллагааг зурвас ажиглахад дөнгөж гарч ирж байгаа бизнес гэж хэлж болох боловч сайн ажиглах тохиолдолд нэлээд өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж байсан хоёрдогч түүхий эдийн үйлдвэрлэлийн шинж тэмдэгийн илэрхийлэл гэж хэлж болно.

Хог түүгч нарын тоо хэд байна вэ гэдэг тооцоо байгууллага бүрээр өөр өөр байна. Жишээлбэл, Дэлхийн банк Улаанбаатар хотод 5,000-7,000 хог түүгч нар, тэр дундаа олон хүүхдүүд байгаа гэсэн тооцоо (Монголын байгаль орчны мониторинг, 2004) гаргасан бол Тогтвортой хотуудын олон улсын төв нь 500-1,000 хүн байна гэж тооцжээ. Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэг дээр 300 орчим хог түүгчид байна гэж Нөөц компани тооцоо хийсэн бол Тогтвортой хотуудын олон улсын төв нь 200-250 хүн байна гэж тооцоо гаргажээ. Зарим хог түүгчид идэх хоол унд хайж байгаа бол ихэнх хог түүгчид лааз, металл, хуванцар, шил, картон цаас зэрэг хог хаягдлыг ангилан ялгах ажилд оролцож байна. Нөөц компани зарим хог түүгчидыг өөрийн ажилтан болгож нийгмийн идэвхтэй амьдралд оруулж чадсан бол олон хүмүүс хог түүгч нарыг иргэж нийгэмд орох дургүй гэж үзэж байна. Жишээлбэл, хотоос олгосон гэрийг тэдгэр хүмүүс зарж орон гэргүй байх сонирхолтой байдаг байна.

Хог түүгч нарын ангилан цуглуулсан хог хаягдлыг Улаанчулуут дээр очих ченжүүд худалдан авдаг байна. Хуванцар хаягдлын хувьд Нөөц нь хаягдал материалыг нь тээвэрлэж өгөх үнэгүй унаа гаргаж өгөхөд дэмжлэг үзүүлдэг байна. Хог түүгч өдөртөө 3,000 төгрөгийн орлого олдог. Айл өрхүүд өөрсдөө тушаадаг шил, лонхноос гадуур бусад хаягдал түүхий эдийг буталж нягтруулаад Хятад руу тээвэрлэн гаргадаг байна. Худалдан авагч нарын талаар мэдээлэл олох нэлээд хэцүү бөгөөд зах зээлээ хамгаалах зорилгоор мэдэгдэх сонирхолгүй байдаг байж болзошгүй. Хаягдал түүхий эдийн зарим анхны үнийн жишээг Хүснэгт 3-24-т үзүүлэв.

Хүснэгт 3-24: Хаягдал түүхий эдийн анхны худалдах үнэ

Хаягдал түүхий эд	нэгж	Үнэ (төг)
Хуванцар лонх сав – бохир	кг	50
Хуванцар лонх сав – цэвэр	кг	250-300
Архины шил	ш	20-70
Чанамал жимсний сав	ш	10-20
Лааз	kg	600
Зэс	кг	1,200
Гууль	кг	600
Хөөсөнцэг	кг	100

Мэдээллийн эх үүсвэр: Нөөц компанийн захирал, 2004.

Улланбаатар хотын нийт хэмжээнд эн тэнд төрөл төрлийн түүхий эд авдаг цэгүүд зах ажиллаж орон сууцны бүсэд худалдаа хийх гэж шил авдаг хүмүүс зарлан дуудаж ажилладаг байна. Тэрхүү түүхий эд авдаг цэгүүд дээр бөөнөөр худалдан авах чэнжүүд очиж хаягдал түүхий эдийг бөөндөж Хятадуудад эсвэл хятадаар яарьдаг худалдаачидад зарж тэдгээр нь цааш нь Хятад руу тээвэрлэн борлуулдаг байна. Зарим иргэд, өрхүүд социализм, комунизмын нийгэмд хийж дассан зангаараа хаягдал түүхий эдийг нэг бүрчлэн ангилан ялгаж дараа нь худалддаг байна. Лаазнаас зөвхөн хөнгөн цагаан лаазны зах зээл нэлээд хөгжсөн бөгөөд дотоодын зах зээлд шилэн лонх, савыг идэвхтэй дахин ашигладаг бол хагаргахай шилийг шууд хогийн цэг дээр дарж булдаг байна. Одоогоор Улаанбаатар болон Дархан хотод хуванцар сав угааж бутлах үйл ажиллагаа нь ашиггүй ажиллаж байна.

Хотод байдаг зарим нэг Хятадын тахианы аж ахуй нь яс боловсруулдаг бөгөөд түүгээр тос гаргаж Хятад руу экспортлох болон дотооддоо ашигладаг байж болзошгүй. Ясны тос болон бордоо үйлдвэрлэх яс боловсруулах гол үйлдвэрийн үйл ажиллагаа дампуурснаас болж махны үйлдвэрүүд ясыг аль болох хямдаар дарж булах сонирхолтой байхын сацуу түүнийгээ хууль бусаар хаях явдал нэг биш удаа гардаг байна. Ихэнх сургуулиуд цаасан хог хаягдлыг 30,000 төг/тонн худалдаж рисайкл хийхээсээ илүү шатаахыг эрмэлздэг байна.

3.3.2 Хуулийн хэрэгжилтийг хангах

Дээр 1.6 дугаар бүлэгт хатуу хог хаягдлын асуудалтай холбоотой гол хуулийн тайлбарыг өгсөн. Улсын мэргэжлийн хяналтын газрын хуулийн хэрэгжилт явуулж буй бүхий л салбарт дараах зургаан шатны захиргааны хэрэгжилтийг төвлөрүүлэх зорилготой бодлогын чанартай арга хэмжээнүүдийг янз бүрийн амжилттайгаар авч болно.

1. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар;
2. ЗАА-ны Хот тохижилтын хэлтэс;
3. Нийслэлийн байгаль орчин хамгаалах газар;
4. Дүүргүүдийн тохижилт, үйлдвэр, үйлчилгээний хэлтэс;
5. Хорооны Засаг дарга;
6. Дүүргүүдийн ТҮК.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцагч нар байгаль орчинд ноцтой хохирол учруулж үйл ажиллагааг зогсоох бүрэн эрхтэй бөгөөд үүнд, журам стандарт зөрчиж буй үйл ажиллагааг түр зогсоох; хууль зөрчигч этгээдэд торгууль ногдуулах; байгаль орчин хамгаалах болон нөхөн сэргээх орон нутгийн хөтөлбөр гаргах; судалгаа, мониторингийн хүрээнд цуглуулсан байгаль орчны мэдээллийг холбогдох үндэсний мэдээлэл боловсруулах агентлаг, системд хүргүүлэх; үйлдвэр, ААН-ийн үйл ажиллагааг зохицуулан хянах зэрэг ажлууд болно. Торгуулийн хэмжээг хуулинд тусгасан байдаг бөгөөд шинээр 2004 оны 7 дугаар сард хүчин төгөлдөр болсон Хатуу хог хаягдлын менежментийн холбогдох хуулинд ч мөн торгуулийн хэмжээг заасан байдаг байна. Нийтийн эдэлбэр газар хог хаягдал хаясан иргэнийг 1,000-10,000 хүртэл төгрөгөөр, хууль бус хог хаягдал хаясан иргэнийг 1,000-15,000 хүртэл төгрөгөөр торгуулана гэж заажээ. Хуулийн нэг сонирхолтой заалт бол дарж булсан хог хаягдлыг ашиглах иргэн буюу хог түүгчид 30,000-50,000 төгрөг, ААН-д 150,000-250,000 төгрөгний торгууль ногдуулна гэжээ. Нэлээд ноцтой хууль зөрчсөн тохиолдолд хуулийн хэрэгжилтийг хангахад НМХГ нь УМХГ –г хандах шаардлагтай байдаг.

Хот тохижилтын хэлтэс хууль зөрчиж буй талаар дүүрэг болон ТҮК-д мэдээллэх бөгөөд түүнээс өөр арга хэмжээ авах боломжгүй.

Нийслэлийн байгаль орчин хамгаалах газар 33 байгаль орчин хамгаалагчидтай боловч тэдгээр нь зөвхөн сануулга өгөх бөгөөд үндсэн үүрэг функц нь бус тус газрын зөвхөн нэг цагдаагийн ажилтан үр дүнтэй торгуулийн арга хэмжээ авдаг.

Дүүргийн тохижилт, үйлдвэр, үйлчилгээний хэлтэс нь дүүргийн Засаг дарга нарын хамт хяналтын ажил хийж иргэдийн санал гомдол хүлээн авах бөгөөд аливаа зөрчил илэрсэн тохиолдолд авах арга хэмжээ нь хязгаардлагдмал тул зөвхөн ТҮК-д мэдэгдэж шаардагдах арга хэмжээ авахыг зааварчилдаг байна.

Ихэнх дүүргийн ТҮК-д хуулийн хэрэгжилтийг хангах эрх мэдэл байхгүй боловч Сүхбаатар ТҮК нь хоёр улсын байцаагч ажиллуулдаг бөгөөд тэдгээр нь (а) төлбөр хураах; (б) хуулийн хэрэгжилтийг хангах; (с) нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, автобусны буудлын байгууламж г.м. эвдсэн этгээдэд төлбөр ногдуулах зэрэг үүрэгтэй.

Хорооны Засаг дарга хуулийн арга хэмжээ авахад нэлээд эрх мэдэлтэй гэдэг боловч торгууль ногдуулах боломжгүй тул хууль бус хог хаягдал гэрээгээр ачуулах зэрэг ажилд зарцуулах хөрөнгийг гаргуулахад иргэдээс төлбөр хураах талаар ухуулга, хүсэлт тавихаас өөр арга хэмжээ авдаггүй байна. Зарим тохиолдолд Засаг дарга нар өөрийн эрх үүргийг гүйцэтгэхэд дэндүү завгүй байна гэж хандах эсвэл ерөөсөө биелүүлэхгүй байх хандлагатай байдаг.

Иймд дээр дурьдсан байгууллагуудын, Сүхбаатар ТҮК-ээс бусад нь, зөвхөн нэг ба тавдугаар этгээд нь хууль бус хог хаягдал цэвэрлүүлэхэд доривтой арга хэмжээ авч чадах бөгөөд мэргэжлийн хяналтын газрын хүрээнд хяналтын байгууллагуудыг нэгтгэснээр бусдын эрх нэлээд буурч – зөвхөн аливаа хууль зөрчсөн асуудал гарахад ТҮК-д хандаж шийдвэрлэх талаас анхаарлаа хандуулахыг хүсдэг байна.

3.3.3 Хувьчлал ба ажил үйлчилгээ гэрээгээр гүйцэтгүүлэх тогтолцоо

Дээр дурьдсаны дагуу Монгол Улсын эдийн засаг зах зээлийн тогтолцоонд шилжих явцад тендерийн үндсэн дээр ТҮК-дын менежментийг хувьчилсан. ТҮК-ийн менежментийг хувьчлах тендер нь техникийн төдий үйл явц байсан бөгөөд үйл ажиллаганы туршлага, компанийн хүчин чадлыг харуулахад оршиж байв. Аливаа санхүүгийн нөхцөл, болзлыг тавиагүй аж. Тендер дуусч түүний ялагчид сая ямар ажил хийх, түүний хүрээ болон хэдийн хэмжээний санхүүжилт хийх тухай зааварчилж мэдээллэсэн болно. Тендер оролцох хуулийн этгээдийн тоо дүүрэг дүүргээр өөр өөр байсан бөгөөд Чингэлтэй дүүргийн хувьд анхны дуудлагаар зөвхөн нэг оролцогч байсан тул дахин тендер зарлах шаардлага гарсан боловч өмнө нь оролцсон компанийн захирал өөрийн ажиллах хүчний дэмжлэгтэйгээр бүх шатны тендерт ялалт байгуулсан. Гэрээ байгуулах тохиолдолд заримдаа гэрээнд бизнес төлөвлөгөө хавсаргаж түүнд нийт гэрээнд тусгасан хугацаанд хийх ажлыг нарийвчлан дурьдсан байна.

Менежментээр хувьчлагдсан компаниуд нь ерөнхийдөө 100% хувийн компани гэх боловч тэдгээрийн үл ойлгогдох статус нь зарим компаниудын захиралын нэрийн хуудас дээр Монол Улсын соёмбо тавигдаж дүүргийн ЗДТГ-ын нэг бүрэлдэхүүн хэсэг гэж ойлголт төрүүлэхээр болж байна.

Шинэ тогтолцооны хүрээнд ТҮК-ийн захирлууд өөрсдийн компанидаа өөрчлөн сайжруулах ажил хийх боломжтой болов. Чингэлтэй ТҮК-ийн захирал 4 жилийн туршлага хуримтлуулсны дүнд дараах арга хэмжээнүүдийг авчээ. Үүнд: 1.Ногоон байгууламжийн чиглэлээр мэргэжилтэн/инженер шинээр авч ажиллуулж тус нэгжийн

ажилчидыг нэг чиглэлээр дагнан мэргэжих бус олон талын чиглэлээр ажилладаг чадвартай болох; 2.бизнесийн үйл ажиллагаагаа хянаж байх зорилгоор нягтлан бодогч дээр нэмж эдийн засагч авч ажиллуулах; 3.менежментийн түвшинд боловсон хүчин авч ажиллуулах; 4. төмөр эд ангийн засвар угсралтын ажлын үр өгөөжийг сайжруулах зорилгоор шинэ засварын цех 2005 оны 4 дүгээр сард ашиглалтанд оруулах зэрэг болно. Түүнчлэн боловсон хүчний болон санхүүгийн менежерийн хэлтэст хоёр хүн ажиллаж байна. Тэдгээр нь 1.дүүргийн санхүүгийн төсвийн хүрээнийн үйл ажиллагааны бүс; 2. хатуу хог хаягдлын цуглуулалт болон тээвэрлэлт хариуцсан тус тус нэг хүн ажиллаж байна

Нийтийн эзэмшлийн зам талбайн бүсийн цэвэрлэгээний ажлыг хэрхэн зохион байгуулах талаар Чингэлтэй ТҮК-ээс нэлээд судалгаа хийж хувь хүн болон бүлэг хүмүүст тухайн нэг хэсэг газрын байнгын цэвэрлэгээ арчилгааг хувьчлан гүйцэтгүүлж байна. Энэхүү арга, ажлын зохион байгуулалт нь зардлын хувьд үр ашигтай хувилбар байх боловч Чингэлтэй ТҮК-ийн бэлэн мөнгөний уурсгалаас шалтгаалан төлбөрийг цаг хугацаанд тогтмол найдвартай хийх бололцоо бүрдээгүй байна.

Хан-Уул ТҮК нь өөрийн үйл ажиллагааныхаа хүрээнд хувьчлалыг тодорхой хэмжээнд нэвтрүүлжээ. 2004 оны 4 дүгээр сарын хувьчлалын дараа тус дүүргийн гэр хорооллын долоон хороо тус бүрт нэг төлбөр хураах байцагч, машинтай жолооч болон хоёр ачигч нэг баг болон ажилласан байна. Хороо болгоны ажлын ачааллын талаар судалгаа хийж түүний дүнг харгалзан ТҮК нь багийн гишүүн бүртэй гэрээ байгуулсан байна. Төлбөр хураах байцагч нь түлшний мөнгийг шууд төлдөг бөгөөд долоо хоног болгон багийн гишүүдийн ажлын хөлсийг төлж үлдэгдэл балансыг долоо хоног бүрийн нэг дэх өдөр компанийн төв байранд ирж тооцоо хийдэг байна. Энэхүү ажлын зохицуулалт нь амжилттай хэрэгжиж байгаа гэх боловч 2004 оны хоёрдугаар хагасын кассын орлого буурсан байна.

3.3.4 Хог хаягдал гаргасны төлбөр ба хураах тогтолцоо

а. Өнөөгийн хог хаягдал гаргасны төлбөр хураах тогтолцоо

а.1 Хог хаягдал гаргасны төлбөр болон төлбөрийн хураалтын хувь хэмжээ



ТҮК-ний хогны төлбөрөөс орох орлого нь гэр, орон сууцны хороолол болон албан байгууллагын хог хаягдал гаргасны төлбөр болно.

Төвийн зургаан дүүргийн өрхийн хогны төлбөрийн сарын хэмжээ нь – Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар болон Чингэлтэй – орон сууцны иргэд сард 1 хүн 200 төгрөг, гэр хорооллын хувьд тээвэрлэх зай болон хог хаягдлын хэмжээнээс хамаарч нэг өрх сард 500-2,500 төгрөг төлдөг байна. Налайх дүүргийн хувьд орон сууцны иргэд сард нэг хүн 150 төгрөг, гэр хорооллын өрх сард нэг өрх 700 төгрөг төлдөг байна. ААН, байгууллагуудын хогны төлбөр нь тээвэрлэх зай болон хог хаягдлын хэмжээнээс хамаарч 1,000-27,000 төгрөг байдаг байна.

Зургаан дүүргийн орон сууцны хорооллын хогны төлбөрийн хэмжээг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Ерөнхий менежер тогтоох эрхтэй байдаг бол ТҮК-ийн захирал гэр хороолол болон албан байгууллагуудын хогны төлбөрийн хэмжээг тогтоодог байна. Налайх дүүргийн хувьд холбогдох хогны төлбөрийн хувь хэмжээг дүүргийн Засаг дарга тогтоох эрхтэй байдаг. Одоогийн орон сууцны хорооллын хогны төлбөрийн хэмжээг 2001 онд тогтоосон бөгөөд одоог хүртэл өөрчлөлт оруулаагүй бол бусад хогны төлбөрийн хувь хэмжээг 2004 онд өөрчилж зарим нь нэмэгдсэн байна.


Орон сууцны хорооллын хог хаягдлын төлбөрийг бусад орон сууцны ашиглалт үйлчилгээний хураамжтай хамтран авдаг тул нийт дүүргүүдэд төлбөр хураалтын хэмжээ 80 - 85%-тай байдаг боловч гэр хорооллын хувьд дүүрэг дүүргээр өөр өөр байдаг байна.

Хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоо эсвэл төлж байгаа, дүүрэг бүрийн гэр хорооллын хогны төлбөр хураах хувь хэмжээ зэрэг мэдээлэл орсон нэг сарын хогны төлбөрийн хэмжээг дараах схем зурагт үзүүлэв.



Зураг 3-20: Гэр хорооллын өрхийн сарын хогны төлбөр
Эх үүсвэр: ТҮК ба ЖАЙКА-ийн Судалгааны багийн тооцоо

Зураг 3-21: Гэр хорооллын хогны төлбөр төлж байгаа
болон төлвөл зохих өрхийн тоо
Эх үүсвэр: ТҮК ба ЖАЙКА-ийн Судалгааны багийн
тооцоо



Зураг 3-22: Гэр хорооллын хогны төлбөр
хураах хувь хэмжээ
Эх үүсвэр: ТҮК ба ЖАЙКА-ийн Судалгааны багийн тооцоо

ТҮК-иудын гэр хороололд мөрдөж буй хогны төлбөрийн хэмжээний хооронд орон сууцны хороололтой харьцуулахад ихээхэн зөрүүтэй байна.

Гэр хороололд хогны төлбөрөө бодитоор төлж байгаа өрхийн тоо бага байгааг дээрх зурагт үзүүлэв. Ялангуяа, Баянзүрх, Сонгинохайраhn ТҮК-ийн хамрах бүс нутгийн хэмжээнд хогны төлбөрөө төлдөггүй айлуудын тоо хамгийн их байна. Өөрөөр хэлбэл, хууль бусаар хог хаях явдал энэ дүүргүүдэд ихээр гарч байна.

Хогны төлбөр хураах хувь хэмжээ гэр хороололд их доогуур байгаа байдлыг дээрх зурагт үзүүлэв. Төлбөрийн хэмжээ Налайх болон Хан-Уул ТҮК-ийн хамрах хүрээнд хамгийн бага (өрх бүр 700 ба 750 төгрөг тус тус) байхад хамгийн өндөр төлбөр нь Баянзүрх ба Чингэлтэй ТҮК-ийн төлбөр байна (1,500 ба 2,400 төгрөг тус тус). Нөгөөтэйгүүр Налайх ба Хан-Уул дүүрэгт хогны төлбөр хураах хувь хэмжээ хамгийн өндөр (24% ба 20% тус тус) байхад Баянзүрх ба Чингэлтэй дүүргийн хувьд хогны төлбөр хураах хувь хэмжээ нь хамгийн бага (тус тус 11%-тай) байгаа бөгөөд тэрхүү байдал нь төлбөрийн хэмжээ болон хураах хувь хэмжээ хоёр хоорондоо эсрэгээр холбоотой байгаа харьцааг харуулж байна. Түүнчлэн тухайн дүүргийн ТҮК-ийн гэр хорооллын бүс нь Баянзүрх, Сонгонохайрхан, Чингэлтэй зэрэг дүүрэгт том байх тусам

төлбөр хураах хувь хэмжээ нь бусад, нутаг дэвсгэр нь бага гэр хороололтой ТҮК-тэй харьцуулахад хогны төлбөр хураах хувь хэмжээ нь бага байгааг тэмдэглэх нь зүйтэй.

а.2 Хогны төлбөр хураах аргачлал ба хяналт

Төвийн зургаан дүүргийн орон сууцны хорооллын өрхийн хогны төлбөрийг гэрээгээр ОСНААГ-аар дамжуулан хураадаг бол гэр хорооллын хогны төлбөрийг ТҮК нь өөрөө хураадаг байна. Налайх дүүргийн хувьд бүх төлбөрийг ТҮК нь өөрөө хураадаг байна.

ОСНААГ нь орон сууцны хорооллын өрхийн хогны төлбөрийг бусад байрны ахуйн үйлчилгээний төлбөртэй хамт хурааж 4%-ийн шимтгэл авч ТҮК-д төлбөрийг нь шилжүүлдэг байна. Аливаа нэгэн айл өрх байрны төлбөрөө төлөхгүй байх тохиолдолд ОСНААГ цахилгааныг нь тасалдаг тул ихэнх орон сууны иргэд хогны төлбөрөө байрны төлбөрийн хамт төлөхөөс өөр аргагүй болдог. Нөгөөтэйгүүр, хогны төлбөрийн хэмжээг гэр бүлийн гишүүдийн тоогоор тооцдог – 200 төг. ОСНААГ нь ихэвчлэн гэр бүлийн гишүүдийн тоог тэр болгон мэдэх боломжгүй байдаг бөгөөд зарим иргэд цөөн гэр бүлийн гишүүдийг ОСНААГ-т бүртгүүлдэг байна. Улмаар ОСНААГ-ын хогны төлбөрийн хураах хэмжээ 80-85 хувьтай байдаг. ОСНААГ нь ТҮК-д хийх төлбөрийг гурваас таван сараар хойшлуулан байж шилжүүлдэг тул заримдаа ТҮК-дыг бэлэн мөнгөний хомсдолд оруулдаг байна.

Гэр хорооллын өрх, жижиг бизнесийн ААН-ийн хогны төлбөрийг ТҮК-ийн байцаагч хашаанаас нь хогийг нь ачихдаа хураадаг бөгөөд тухай айл өрх/ААН төлбөрөө төлөхөөс татгалзвал ТҮК-ийн ачигч нар хогийг нь мөн ачдаггүй байна.

Орон сууцны хороололд байрлалтай жижиг бизнесийн ААН сард нэг удаа ТҮК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр ТҮК-ийн байцагчид шууд хогны төлбөрөө төлдөг байна.

Дунд болон томоохон ААН-үүд нь ТҮК-тай байгуулсан гэрээний дагуу хогны төлбөрөө банкны шилжүүлгээр хийдэг байна. Зарим ААН, албан байгууллага нь ТҮК-тэй гэрээ байгуулахгүй, өөрсдийн унаагаар эсвэл хувийн этгээд хөлсөлж хогоо тээвэрлэдэг байна. Ингэхэд тэрхүү хог хаягдал нь хаана хаягдаж байгаа нь тодорхойгүй байдаг байна.

Зуслангийн бүс нь ихэвчлэн хотын хойд хэсэгт байрлах тул тэндээс хог хаягдлыг татан зайлуулах асуудлыг Сүхбаатар болон Чингэлтэй ТҮК хариуцдаг байна. Хотын бусад дүүргүүдээс ч айл өрх зуны улиралд зусланд гарч амьдардаг байна. Зусланд гарсан зарим айл өрхүүд хотын төвд ойр амьдардаг гэр хорооллын айлуудтай харьцуулахад чинээлэг амьдардаг боловч хогны төлбөрийн хэмжээ зусланд бага байдаг байна. Зуслангийн бүсээс хогны төлбөр хураах тогтолцоонд дутуу дулимаг зүйл ажиглагдаж байна. Зуслангийн айлууд дээрх хоёр ТҮК-ийн байрлуулсан хогны контейнер саванд хогоо хаядаг бөгөөд ачигч нарт шууд шилжүүлдэггүй байдал нь иргэд зйслангийн оршин суугчид төлбөр хураах цагт төлөхгүй, татгалзах явдал их гардаг байна.

Хогны төлбөр хураах байцагч нь хураасан мөнгөний дүнгийн нийт хэмжээний тогтсон хувийг ТҮК-иас авдаг байна. ТҮК нь өөрсдийн байцагч нарын хууран мэхлэх үйл явдлыг тогтооход хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна. Баянгол, Хан-Уул, Налайх зэрэг ТҮК нь төлбөр хураах байцагч нарын ажлыг шалгах зорилгоор үе үе шалгалт хийж айл өрх, ААН-ээр орж төлбөрийн баримт авсан эсэхийг шалгаж хянадаг боловч нийт үйлчлүүлэгч нарыг хамруулж хянах боломжгүй юм. Хогны төлбөр хураах байцагч нар айл өрхийн хогны төлөлтийн байдлыг тусгасан нарийвчилсан жагсаалттай байдаг боловч ямар ч ТҮК хог хаягдал болон төлбөрийн хураалтын байдлыг хянах зорилгоор мэдээллийн бааз огт хийж байгуулаагүй байна¹. Дунд болон томоохон ААН-ийн хогны төлбөрийн хувьд ТҮК нь хогны төлөлтийн байдлыг сайн мэддэг байна.

¹ Налайх болон Сүхбаатар ТҮК нь саяхнаас мэдээлийн сан байгуулах болсон байна.

а.3 Хуулийн хүрээнд төлбөр төлүүлэх

Орон сууцны хорооллын хогны төлбөрийг ОСНААГ буйсад ахуй үйлчилгээний төлбөрийн хамт хураадаг тул хураалтын хувь хэмжээ өндөр байгаа тухай бид дээр дурьдсан билээ. Байрны төлбөрийг цаг хугацаанд нь төлөхгүй айл өрхийн цахилгааныг тасалдаг тул хогны төлбөрийг төлөх хүсэлтэй, хүсэлгүй гэсэн байдлыг үл харгалзан тухайн өрх нь төлөхөөс өөр аргагүй болдог байна.

Гэр хорооллын хувьд хогны төлбөр төлдөггүй этгээдийн эсрэг ТҮК нь торгох эрхгүй байдаг тул доривтой арга хэмжээ авч чадахгүй, зүгээр л хогны төлбөр төлөхгүй айлын хогийг нь ачихаа больж улмаар хууль бус хог хаягдал гарах үндэс болж өгдөг байна.

Албан байгууллагын хог хаягдлын хувьд ч мөн адил тухайн байгууллага хогны төлбөрөө хэдэн сараар төлөхгүй байх тохиолдолд хог хаягдлыг нь цуглуулахаа зогсоодог байна. Орон сууцны байранд байрлах жижиг бизнесийн ААН нь орон сууцны хог хаях түр цэгт өрхийн хогтой хамт хогоо хаячихдаг тул хогны төлбөр төлөхгүй байгаа бизнесийн ААН-ийн этгээдийн эсрэг доривтой арга хэмжээ авахад бас хүндрэлтэй байдаг байна. Дунд болон томоохон хэмжээний ААН-ийн үйл ажиллагаа дүүргийн ЗДТГ болон Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын зүгээс хяналтанд байдаг тул тэдгээр нь ихэвчлэн хогны төлбөрөө төлдөг байна.

Бизнесийн ААН-ийн дүүргийн ЗДТГ болон Мэргэжлийн хяналтын газрын зүгээс хийх шалгалт ба хяналт

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар (НМХГ) нь Улаанбаатар хотын хэмжээнд үйлчилгээний бизнесийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох цорын ганц байгууллага юм. Үйлчилгээний зөвшөөрөл авах өргөдөлийг авсаны үндсэн НМХГ нь байршил, ажлын байр, ажлын нөхцөл боон стандартыг газар дээр нь очиж шалгаж судалдаг байна. Бизнесийн зөвшөөрөл нь хүчинтэй байх хугацаа гэж байдаггүй байна. Мэргэжлийн хяналтын газар нь жижиг ААН нь үйл ажиллагаандаа стандарт, шаардлага хангаж байгаа эсэхийг шалгадаг бөгөөд хангахгүй байгаа тохиолдолд НИМХГ-ын байцаагч зөвшөөрлийг түр түдгэлзүүлдэг байна.

Мэргэжлийн хяналтын газраас зөвшөөрөл авсан тухайн дүүрэгт үйлчилгээний бизнестэй ААН-тэй дүүргийн ЗДТГ-ын ажилтан гэрээ байгуулдаг байна. Жишээлбэл, Чингэлтэй дүүрэг ААН бүрээс үйлчилгээний хураамж гэж нэг удаагийн 500 төгрөг хурааж ариун цэвэр, эрүүл ахуйн стандарт, үйлчилгээний цаг болон хог хаях байдлыг зөрчихгүй байх байдлыг хангах зорилготой юм байна. Тэрхүү гэрээний хугацаа нь гурван сараас жилийн хугацаатай байдаг байна.

Дүүргийн ЗДТГ-ын ажилтан нар өөрсдөө эсвэл мэргэжлийн хяналтын газрын байцагч нартай хамтран шалгалт хийдэг байна. Дүүргийн ажилтан аливаа хууль зөрчсөн үйлдэл тогтоох тохиолдолд торгох болон бизнесийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх эрхтэй мэргэжлийн хяналтын газарт мэдэгддэг байна.

Үйлчилгээний гэрээнд тусгасан заалтуудыг ААН зөрчих тохиолдолд мэргэжлийн хяналтын газрын байцаагчид тухайн байгууллагад тодорхой хугацаа өгч залруулах арга хэмжээ авахыг шаарддаг бөгөөд дараа нь шалгалтыг дахин хийдэг байна. Тэрхүү хугацаанд ААН нь залруулах арга хэмжээ авч чадаагүй тохиолдолд үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлдэг байна.

Үйлчилгээний төлбөрөө төлдөггүй этгээдийн эсрэг торгууль бараг ногдуулдаггүй. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар хууль дүрэм зөрчиж буй этгээдийн эсрэг торгуулийн арга хэмжээ авах чадвартай боловч ТҮК болон Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар хооронд байнгын мэдээлэл солилцох тогтолцоо байхгүй, дүрэм журам хэрэгжүүлэх институтын чадавхи ч байхгүй байна. Одоогоор мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин хамгаалах байцагч нар жилд нэг удаа, зөвхөн аюултай хог хаягдал гаргадаг үйлдвэрүүдийг шалгах бөгөөд дүрэм зөрчсөн этгээдийг зөвхөн хогоо ачуулсан гэсэн баримт гаргаж өгч чадахгүй тохиолдолд л торгодог байна.

б. Тулгамдаж буй асуудлууд ба тэгээрийг шийдвэрлэхэд авах арга хэмжээ

Өнөөгийн хогны төлбөр хураах тогтолцоонд тулгамдаж буй асуудлууд ба тэгээрийг хэрхэн шийдвэрлэх арга хэмжээг дараах байдлаар тодорхойлов:

b.1 Төлбөрөөс орох орлогын хэмжээ болон хогны төлбөр хураалтын хувь хэмжээ бага

- Орон сууцны байрны төлбөр болон хогны төлбөрийг өрхөөр бус өрхийн гишүүн бүрээр хураадаг тул орон сууцны иргэд өрхийн гишүүдийнхээ тоог худал мэдээллэх явдал гардаг байна.
 - ① Авах арга хэмжээ: Улаанбаатар хотын захиргаа нь орон сууцны өрхийн гишүүдийн тоог ерөнхийдөө тогтоох боломжгүй гэж үзэж хогны төлбөрийг өрхийн гишүүний тоогоор бус өрх бүрээр эсвэл орон сууцны талбайн хэмжээгээр төлбөр² тооцох шаардлагатай. Гаргаж буй хог хаягдлын хэмжээг харгалзахгүйгээр төлбөр ногдуулах нь шудрага бус гэж үзэх үзэл бодол байдаг боловч орон сууцны оршин суугчидын тоо болон тэдгээрийн орлогын түвшин хоёрын хооронд эсрэг харьцаатай байдаг тул салбар хоорондын татаасын тогтолцоог нэвтрүүлэх боломжтой.
- ТҮК нь гэр хорооллын айл өрх болон жижиг ААН-ээс төлбөр хураагч нарыг бүрэн хянах боломжгүй байдаг тул тэдгээр нь худал мэдээллээр тайлагнах явдал гардаг байна.
 - ② Авах арга хэмжээ: Хогны төлбөрийн хяналтыг хангалттай түвшинд хийхийн тулд өрхий болон бизнесийн ААН-ийн хогны төлбөр төлөлтийн талаарх мэдээллийн баазтай болох шаардлагатай. Цахилгаан түгээх компанийн үйлчлүүлэгчдийн жагсаалтыг ашиглаж мэдээллийн бааз байгуулах нь үр дүнтэй болно.
- Хогны төлбөрөө төлдөггүй гэр хорооллын айл өрхийн эсрэг авах үр дүнтэй арга хэмжээ бараг байхгүй бөгөөд улмаар хогны төлбөр хураах хувь хэмжээ маш доогуур байж ТҮК-ийн бага орлоготой байгаа гол шалтгаан нь болж байна.
 - ③ Авах арга хэмжээ: Хогны төлбөрийг цахилгааны төлбөрийн хамт авах эсвэл төлдөггүй этгээдэд захиргааны үйлчилгээг үзүүлэхгүй байх зэрэг хогны төлбөрөөс орох орлогын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор төлбөр төлөлтийг хуулийн дагуу хэрэгжүүлэх тогтолцоо нэвтрүүлэх шаардлагатай.

b.2 Хогны төлбөрийн хэмжээний зөрүү болон дүүрэг хоорондын татаасын тогтолцоо байхгүй

- Дүүрэг болгон хог хаягдал цуглуулах үйлчилгээг санхүүгийн хувьд бие даасан хэлбэрээр үзүүлдэг бөгөөд дүүргүүдийн гэр хорооллын хогны төлбөр хооронд ихээхэн зөрүүтэй байна. Тэрхүү зөрүү нь ихэвчлэн гэр хорооллын хэмжээ, түүний хамрах хүрээнээс ихээхэн шалтгаалж байгаа боловч хүндрэлтэй дүүргийг дэмжих дүүрэг хоорондын татаасын тогтолцоо байхгүй байна.
 - ④ Авах арга хэмжээ: Хог хаягдлын төлбөрийг үйлчилгээний сан дээр төвлөрүүлэн салбар буюу дүүрэг хоорондын татаасын тогтолцоог нэвтрүүлж дүүргүүд хоорондоо санхүү хөрөнгө шилжүүлэх боломжтой болгох шаардлагатай. Энэхүү арга хэмжээ авсан тохиолдолд хотын хэмжээнд дүүргээр дамжуулан хогны төлбөр цуглуулах болон сангийн менежментийг хийх асуудлыг хариуцах ёстой бөгөөд хог хаягдлыг

² Дулаан хангамжийн төлбөрийг орон сууцны талбайн үндсэн дээр хураадаг тул айл өрх бүрийн талбайн хэмжээний тухай мэдээлэл ОСНААГ байдаг болно.

цуглуулах үйлчилгээг хувийн компанид гэрээгэр гйүцэтгүүлэх шаардлагтай.

b.3 Хог хаягдлын үйлчилгээг бүрэн бус эсвэл огт авдаггүй гэр хорооллын бүс

- Хог хаягдлын үйлчилгээг бүрэн бус эсвэл огт авдаггүй гэр хороолол байгаа гол шалтгаан нь: (1) зарим гэр хорооллын айлууд дээр очиж хүрэхэд хэцүү; ба (2) төлбөр төлөх чадваргүй эсвэл төлөх сонирхолгүй иргэд байна гэж үзнэ. Төлбөрөө төлөхгүй байгаа өрхөөс хог хаягдлыг нь ТҮК-ийн ачигч нар ачдаггүй тул тэдгээр иргэд ихэвчлэн хууль бусаар хаядаг байна.
 - ⑤ Авах арга хэмжээ: Нийт гэр хорооллыг хог хаягдал цуглуулах үйлчилгээнд хамруулахын тулд холбогдох хуулиудын хэрэгжилтийг найдвартай хангах механизм ажиллах тохиолдолд хогны төлбөрөө төлөх боломжгүй эсвэл төлөх хүсэлгүй байгаа өрхийн хог хаягдлыг төлбөр төлөлтийн абйдлаас хамааралгүйгээр ачиж цуглуулах шаардлагатай. Хогны төлбөрөө төлж дийлэхгүй айл өрхийг бусад хөшүүрэг буюу нийтийн эзэмшлийн зам тайлбайн цэвэрлэгээ гэх мэт ажлыг хийлгэх гэсэн арга хэмжээнүүдийг нэвтрүүлэх шаардлагатай юм.

b.4 Хууль бусаар хаях хог хаягдлын хэмжээ өсөх

- Хотын захиргаа болон дүүрэг нь хог хаягдал ачдаг хувийн компаниудад хяналт тавьдаггүй тул тэдгээрийн хууль бусаар хаях үйлдлийг барих боломжгүй байна.
 - ⑥ Авах арга хэмжээ: Хог хаягдал ачиж цуглуулах үйлчилгээ үзүүлдэг хувийн компаниуд бүртгэлтэй болж лиценз авах ёстой. Хогийн цэг бүртгэл хөтөлж эдгээр компаниудын үйл ажиллагаан дээр хяналт тавьж ажиллах нь зүйтэй.
- Хог хаягдлаа өөрсдөө тээвэрлэдэг бизнесийн ААН-ийн үйл ажиллагаан дээр одоогоор аливаа хяналт тавьсан зүйл байхгүй байгаа бөгөөд зарим нь төлбөр хураамжаас зайлсхийж хууль бусаар хаядаг байдлыг үгүйсгэхгүй.
 - ⑦ Авах арга хэмжээ: ААН-үүдийн хууль бусаар хог хаягдал хаях явдлыг хянах зорилгоор хог хаягдлаа өөрсдөө тээвэрлэдэг компаниуд мөн бүртгэлд орж лиценз авах ёстой. Лицензгүй этгээдийн хог хаягдал тээвэрлэх явдлыг хориглох шаардлагатай.

b.5 Орон сууцны хороололтой харьцуулахад гэр хорооллын хогны төлбөр өндөр байна

- Хог хаягдал ачиж цуглуулах зардлын зөрүүтэй байдлаас шалтгаалан гэр хорооллын хогны төлбөр орон сууцны төлбөрөөс нэлээд өндөр байна. Улмаар гэр хороололд амьдардаг ядуу иргэн нь орон сууцны хороололд амьдардаг хүмүүсээс их хэмжээний хогны төлбөр төлөх шаардлагатай болж байна.
 - ⑧ Авах арга хэмжээ: Гэр болон орон сууцны хорооллын хогны төлбөрийн хэмжээг дахин харж өөрчлөх шаардлагатай бөгөөд хоёр бүс хоорондын зөрүүг багасгаж салбар хоорондын татаасыг тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай.


b.6 Хогийн төвлөрсөн цэг дээр ил задгай байдлаар хог хаягдлыг хаях

- Хотын захиргаанаас хогийн төвлөрсөн цэг дээр явуулах үйл ажиллагаанд зориулдаг төсвийн хөрөнгийн хэмжээ нь бага байдаг тул ихэнх хог хаягдлыг дарж нягтруулах болон хөрсөөр хучих үйл ажиллагааг хийж чаддаггүй байна.

- Хог хаягдал цуглуулх үйлчилгээнээс орох орлогоос төвлөрсөн цэгийн үйл ажиллагаанд зориулж хөрөнгө мөнгө шилжих механизм байхгүй.

⑨ Авах арга хэмжээ: Хотын захиргааны зүгээс хогийн төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хангах шаардлагатай. Хогийн төвлөрсөн цэг дээр дарж булах төлбөрийг хог хаягдал ачиж цуглуулах үйлчилгээний төлбөрт оруулж төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хогны төлбөрийн төвлөрсөн орлого буюу үйлчилгээний сангаас санхүүжүүлэх шаардлагатай.

Хогны төлбөр хураах тогтолцооны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд болон хэрхэн шийдвэрлэх арга хэмжээний талаар дараах зургаар хураангуйлан үзүүлэв.



Зураг 3-23: Хогны төлбөр хураах тогтолцооны тулгамдаж буй асуудлууд болон шийдвэрлэх арга хэмжээ

3.3.5 Холбогдох байгууллагуудын санхүүгийн байдал

а. Зардлын тооцоо

ТҮК болон Нөөц компаниас ирүүлсэн санхүүгийн мэдээ, материал дээр үндэслэн хог хаягдлыг цуглуулах үйлчилгээний орлого, зардлын дүн шинжилгээ хийхэд ашиглав. Зардлын нарийвчилсан нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо аль ч компаниудад байхгүй байсан тул хог хаягдал цуглуулах зардлын тооцоог төрөл төрлөөр нь тухайн компаниудын ня-бо, эдийн засагч нарын ирүүлсэн орлогын баримт болон нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг үндэслэн хийв. (Зардлын задаргааг хавсралт материалаас үзнэ үү)

Компани болгоны зардлын задаргааг дараах байдлаар тооцов:

- *Баянгол ТҮК* Зардлын тайлбар задаргааг тус компанийн ерөнхий нягтлан бодогчийн ирүүлсэн орлогын мэдүүлэг, татварын тайлан болон бусад дотоод санхүүгийн материал дээр үндэслэн тооцов.
- *Баянзүрх ТҮК* Тус компани дараах зардлын задаргааг ирүүлэв. Үүнд: (1) тээвэр хэрэгслэлийн авто парк, (2) зам талбайн цэвэрлэгээ / тохижилт ба ногоон байгууламж, (3) захиргааны болон (4) бусад зардал зэрэг болно. Тээвэр хэрэгслэлийн авто паркийн зардлыг техникийн хүчин чадал багтаамж, тээврийн хэрэгслэлийн татвар, түлш, тос маслын ашиглалтын тайлан зэрэг цуглуулах үйлчилгээ болон 2004 оны 1 дүгээр сарын байдлаарх автомашины ашиглалтын тайлан гэж хооронд нь хуваж тооцоо хийв.
- *Хан-Уул ТҮК* *Баянзүрх* дүүргийн ТҮК нэгэн адил зам талбайн цэвэрлэгээ / тохижилт ба ногоон байгууламж байгуулах үйл ажиллагаа, захиргааны болон тээвэр хэрэгслэлийн автопаркийн үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй тооцоог ирүүлсэн болно. Автопаркийн зардлыг компанийн ерөнхий нягтлан бодогчийн ирүүлсэн кассын орлого, ерөнхий тайлан, бусад санхүүгийн бүртгэл дээр үндэслэн хог хаягдал цуглуулах үйлчилгээ бүрээр хувааж тооцов.
- *Сонгинохайрахн ТҮК* Зардлын дэлгэрэнгүй задаргааг компаниас ирүүлсэн болно. Хог хаягдал цуглуулах үйлчилгээ тус бүрийн талаарх мэдээллийг тус компанийн ерөнхий нягтлан бодогчийн ирүүлсэн тайлан, санхүүгийн бүртгэл, нягтлан бодохын тооцооны материал болон ерөнхий тайлан үндэслэн тооцоо хийв.
- *Сүхбаатар ТҮК* Зардлын дэлгэрэнгүй задаргааг компаниас ирүүлсэн болно.
- *Чингэлтэй ТҮК* Зардлын дэлгэрэнгүй задаргааг компаниас ирүүлсэн бөгөөд тэрхүү мэдээлэл үндэслэн судлагааны баг түлшний зардлын тооцоог хог хаягдал цуглуулах үйлчилгээний холбогдох зардлын зүйл ангиудтай харьцуулан тооцов.
- *Налайх ТҮК* Компаний зардлын задаргааг санхүүгийн болон хөрөнгийн бүртгэл дээр үндэслэн компанийн нягтлан бодогчийн хамт тооцож хийв.
- *Нөөц УҮГ* Компаний зардлын задаргааг сарын санхүүгийн тайлан, орлогын мэдүүлэг болон бусад материал дээр үндэслэн компанийн нягтлан бодогчийн хамт тооцож хийв.

Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар ТҮК-ийн ирүүлсэн мэдээллийн хугацаа 2004 оны 3 дугаар сараас 12 дугаар сарыг хүртэл байсан тул судалгааны баг сарын дундаж бодож жилийн тооцоог хийсэн.

ТҮК-иудын элэгдэл хорогдлын зардлыг судлагааны баг нэг хэлбэрт оруулж дараах байдлаар тооцов. Үүнд: байшин барилга – 50 жил; хүнд даацын машин механизм болон авто техник – 10 жил; албан конторын төхөөрөмж – 5 жил.

Хүснэгт 3-25: Баянгол Тохижилт, үйлчилгээний компанийн 2004 оны
"Орлого-Зарлага-Ашиг"

№	Зардлын зүйл анги	Хог хаягдал цуглуулах үйлчилгээ			Бусад үйлчилгээ (цэвэрлэгээ, тохижилт бусад)	Нийт
		Гэр хороолол	Орон сууцны хороолол	Байгууллага		
1	Орлого	8,744	199,900	128,200	81,401	418,244
	<i>Үйл ажиллагааны зардал:</i>					
2	Цалин, нийгмийн даатгалын зардал	5,232	14,535	14,565	68,916	103,248
3	Түлш, тосолгооны материалын зардал	21,228	39,967	40,050	11,443	112,688
4	Засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл авах зардал	890	2,471	2,476	0	5,837
5	Элэгдэл хорогдлын зардал	4,226	7,956	7,973	2,278	22,433
6	Захиргааны зардал	7,156	15,079	15,110	15,459	52,804
7	Бусад зардал	15,609	33,542	33,610	12,461	95,221
8	Үйл ажиллагааны нийт зардал	54,340	113,551	113,784	110,557	392,231
9	Цэвэр ашиг	-45,596	86,349	14,416	-29,156	26,013
Цуглуулах хэмжээ (тонн/жил) Нэгжийн зардал (төг/тонн)						
10	Сарын хураамж (нэгж: төг/өрх)	1,100	864	19,077		
11	Сарын нэгж зардал (нэгж: төг/өрх)	6,836	491	16,932		
12	Хогны төлбөр төлж буй өрх/байгууллагын дундаж тоо	662	19,280	560		
13	Хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоо	3,800	21,591			
14	Төлбөр хураах хэмжээ (нэгж: %)	17	89			

Эх үүсвэр: Баянгол Тохижилт, үйлчилгээний компани болон ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо

(Тайлбар):

(5) Элэгдэл хорогдлын зардлыг дараах байдлаар тооцов:

- Барилга байшинг 50 жил ашиглана
- Машин, төхөөрөмж 10 жил ашиглана
- Тавилга 5 жил ашиглана

(10-1) ОСНААГ-ын орон сууцны хог хаягдлын төлбөр хураасан шимтгэл нь 200 төг/хүн-ээс 4% гэж тооцов.

(10-2) Дүүргийн өрхийн дундаж хүмүүсийн тоог (4.5) "Улаанбаатар хот -ХХ зуунд" статистикийн эмхэтгэлээс үндэслэн авсан бөгөөд тэрхүү статистикийн мэдээ, тоог ашиглан орон сууцны өрхийн дундаж талберийн хэмжээг тооцов

Хүснэгт 3-26: Баянзүрх Тохижилт, үйлчилгээний компанийн 2004 оны
"Орлого-Зарлага-Ашиг"

№	Зардлын зүйл анги	Тээврийн цэх			Бусад үйлчилгээ (цэвэрлэгээ, тохижилт бусад)	Нийт
		Гэр хороолол	Орон сууцны хороолол	Байгууллага		
1	Орлого	44,898	90,968	166,392	189,409	491,667
	<i>Үйл ажиллагааны зардал:</i>					
2	Цалин, нийгмийн даатгалын зардал	20,209	24,912	48,440	42,416	135,977
3	Түлш, тосолгооны материалын зардал	21,325	21,502	61,553	8,198	112,577
4	Засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл авах зардал	2,839	2,863	8,195	1,091	14,988
5	Элэгдэл хорогдлын зардал	2,836	2,860	8,187	1,090	14,974
6	Захиргааны зардал	11,935	13,370	31,424	25,549	82,277
7	Бусад зардал	8,150	9,881	19,385	65,712	103,128
8	Үйл ажиллагааны нийт зардал	67,294	75,386	177,184	144,056	463,921
9	Цэвэр ашиг	-22,397	15,581	-10,792	45,353	27,745
Цуглуулах хэмжээ (тонн/жил) Нэгжийн зардал (төг/тонн)						
10	Сарын хураамж (нэгж: төг/өрх)	1,500	826	20,302		
11	Сарын нэгж зардал (нэгж: төг/өрх)	2,248	684	21,618		

	төг/өрх)				
12	Хогны төлбөр төлж буй өрх/байгууллагын дундаж тоо	2,494	9,182	683	
13	Хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоо	23,109	11,568		
14	Төлбөр хураах хэмжээ (нэгж: %)	11	79		

Эх үүсвэр: Баянзүрх Тохижилт, үйлчилгээний компани болон ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо

(Тайлбар):

(5) Элэгдэл хорогдлын зардлыг дараах байдлаар тооцов:

- Барилга байшинг 50 жил ашиглана
- Машин, төхөөрөмж 10 жил ашиглана
- Тавилга 5 жил ашиглана

(10-1) ОСНААГ-ын орон сууцны хог хаягдлын төлбөр хураасан шимтгэл нь 200 төг/хүн-ээс 4% гэж тооцов.

(10-2) Дүүргийн өрхийн дундаж хүмүүсийн тоог (4.3) "Улаанбаатар хот -XX зуунд" статистикийн эмхэтгэлээс үндэслэн авсан бөгөөд тэрхүү статистикийн мэдээ, тоог ашиглан орон сууцны өрхийн дундаж талбөрийн хэмжээг тооцов

(13) Орон сууцны хорооллын хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоог "Улаанбаатар хот -XX зуунд" статистикийн эмхэтгэлээс үндэслэн авав

Хүснэгт 3-27: Хан-Уул Тохижилт, үйлчилгээний компанийн 2004 оны "Орлого-Зарлага-Ашиг"

нэгж: 000 төг

№	Зардлын зүйл анги	Хог хаягдал цуглуулах үйлчилгээ			Бусад үйлчилгээ (цэвэрлэгээ, тохижилт бусад)	Нийт
		Гэр хороолол	Орон сууцны хороолол	Байгууллага		
1	Орлого	26,440	41,532	54,872	134,397	257,241
	<i>Үйл ажиллагааны зардал:</i>					
2	Цалин, нийгмийн даатгалын зардал	11,218	7,560	8,901	52,557	80,235
3	Түлш, тосолгооны материалын зардал	11,465	15,284	15,973	25,706	68,428
4	Засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл авах зардал	2,096	2,032	3,767	1,167	9,062
5	Элэгдэл хорогдлын зардал	3,772	5,029	5,255	8,458	22,514
6	Захиргааны зардал	9,694	8,638	9,788	33,538	61,659
7	Бусад зардал	6,962	3,408	3,408	30,384	44,162
8	Үйл ажиллагааны нийт зардал	45,207	41,951	47,092	151,810	286,061
9	Цэвэр ашиг	-18,767	-420	7,779	-17,412	-28,820
					Цуглуулах хэмжээ (тонн/жил) Нэгжийн зардал (төг/тонн)	
10	Сарын хураамж (нэгж: төг/өрх)	750	864	16,044		
11	Сарын нэгж зардал (нэгж: төг/өрх)	1,282	873	13,770		
12	Хогны төлбөр төлж буй өрх/байгууллагын дундаж тоо	2,938	4,006	285		
13	Хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоо	12,330	4,367			
14	Төлбөр хураах хэмжээ (нэгж: %)	24	92			

Эх үүсвэр: Хан-Уул Тохижилт, үйлчилгээний компани болон ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо

(Тайлбар):

*Энэхүү мэдээллийн бүтэн жилийн тооцоог 2004 оны 3 дугаар сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хоорондын 10 сарын мэдээлэл дээр тулгуурлан тооцсон

(2; 3) Орлогын хэсэгт 2004 оны 4 дүгээр сараас 12 дугаар сарын хооронд гэр хороололд хог хаягдал цуглуулсан цалин болон түлшний зардлыг оруулаагүй; дараах тоог тооцоонд нэмж оруулсан (цалинд 8898 мянга ба түлшэнд 8563 мянга болно)

(5) Элэгдэл хорогдлын зардлыг дараах байдлаар тооцов:

- Барилга байшинг 50 жил ашиглана
- Машин, төхөөрөмж 10 жил ашиглана
- Тавилга 5 жил ашиглана

(10-1) Гэр хорооллын хогны төлбөрийн хэмжээ 500-1000 төгрөгийн хооронд хэлбэлзэх тул дундаж болгон 750 төг гэж тооцоонд ашигласан

(10-1) ОСНААГ-ын орон сууцны хог хаягдлын төлбөр хураасан шимтгэл нь 200 төг/хүн-ээс 4% гэж тооцов.

(10-2) Дүүргийн өрхийн дундаж хүмүүсийн тоог (4.5) "Улаанбаатар хот -XX зуунд" статистикийн эмхэтгэлээс үндэслэн авсан бөгөөд тэрхүү статистикийн мэдээ, тоог ашиглан орон сууцны өрхийн дундаж талбөрийн хэмжээг тооцов

(13) Гэр хорооллын хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоог "Улаанбаатар хот -XX зуунд" статистикийн эмхэтгэлээс үндэслэн авав

Хүснэгт 3-28: Сонгинохайрхан Тохижилт, үйлчилгээний компанийн 2004 оны
"Орлого-Зарлага-Ашиг"

нэгж: 000 төг

№	Зардлын зүйл анги	Хог хаягдал цуглуулах үйлчилгээ			Бусад үйлчилгээ (цэвэрлэгээ, тохижилт бусад)	Нийт
		Гэр хороолол	Орон сууцны хороолол	Байгууллага		
1	Орлого	57,354	91,217	53,540	88,039	290,150
	<i>Үйл ажиллагааны зардал:</i>					
2	Цалин, нийгмийн даатгалын зардал	45,095	21,645	13,154	44,508	124,401
3	Түлш, тосолгооны материалын зардал	75,920	22,844	12,931	10,214	121,909
4	Засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл авах зардал	7,139	1,623		136	8,898
5	Элэгдэл хорогдолын зардал	13,399	4,032	2,282	1,803	21,515
6	Захиргааны зардал	18,657	7,105	3,697	9,446	38,906
7	Бусад зардал	989	239		10,730	11,957
	Үйл ажиллагааны нийт зардал	161,199	57,487	32,064	76,836	327,586
9	Цэвэр ашиг	-103,845	33,730	21,477	11,202	-37,436

Цуглуулах хэмжээ (тонн/жил)
Нэгжийн зардал (төг/тонн)

10	Сарын хураамж (нэгж: төг/өрх)	1,200	902	3,077		
11	Сарын нэгж зардал (нэгж: төг/өрх)	3,373	569	1,843		
12	Хогны төлбөр төлж буй өрх/байгууллагын дундаж тоо	3,983	8,424	1,450		
13	Хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоо	24,000	9,149			
14	Төлбөр хураах хэмжээ (нэгж: %)	17	92			

Эх үүсвэр: Сонгинохайрхан Тохижилт, үйлчилгээний компани болон ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо (Тайлбар):

*Энэхүү мэдээллийн бүтэн жилийн тооцоог 2004 оны 3 дугаар сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хоорондын 10 сарын мэдээлэл дээр тулгуурлан тооцсон

(5) Элэгдэл хорогдлын зардлыг дараах байдлаар тооцов:

- Барилга байшинг 50 жил ашиглана
- Машин, төхөөрөмж 10 жил ашиглана
- Тавилга 5 жил ашиглана

(10-1) ОСНААГ-ын орон сууцны хог хаягдлын төлбөр хураасан шимтгэл нь 200 төг/хүн-ээс 4% гэж тооцов.

(10-2) Дүүргийн өрхийн дундаж хүмүүсийн тоог (4.7) "Улаанбаатар хот -XX зуунд" статистикийн эмхэтгэлээс үндэслэн авсан бөгөөд тэрхүү статистикийн мэдээ, тоог ашиглан орон сууцны өрхийн дундаж талбөрийн хэмжээг тооцов

Хүснэгт 3-29: Сүхбаатар Тохижилт, үйлчилгээний компанийн 2004 оны
"Орлого-Зарлага-Ашиг"

нэгж: 000 төг

№	Зардлын зүйл анги	Хог хаягдал цуглуулах үйлчилгээ			Бусад үйлчилгээ (цэвэрлэгээ, тохижилт бусад)	Нийт
		Зуслан	Орон сууцны хороолол	Байгууллага		
1	Орлого	3,350	72,986	213,781	249,384	539,501
	<i>Үйл ажиллагааны зардал:</i>					
2	Цалин, нийгмийн даатгалын зардал	1,982	43,177	103,277	92,644	241,080
3	Түлш, тосолгооны материалын зардал	5,644	56,694	83,750	41,236	187,324
4	Засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл авах зардал	0	2,113	3,637	17,662	23,411
5	Элэгдэл хорогдолын зардал	701	7,042	10,402	5,122	23,266
6	Захиргааны зардал	528	6,667	12,632	12,640	32,468
7	Бусад зардал	529	2,225	4,876	46,802	54,432
	Үйл ажиллагааны нийт зардал	9,384	117,918	218,576	216,105	561,982
9	Цэвэр ашиг	-6,034	-44,931	-4,794	33,279	-22,481

Цуглуулах хэмжээ (тонн/жил)
Нэгжийн зардал (төг/тонн)

10	Сарын хураамж (нэгж: төг/өрх)	1,250	864	23,753		
11	Сарын нэгж зардал (нэгж: төг/өрх)	3,502	1,396	24,286		
12	Хогны төлбөр төлж буй	670	7,040	750		

	өрх/байгууллагын дундаж тоо				
13	Хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоо		7,822		
14	Төлбөр хураах хэмжээ (нэгж: %)		90		

Эх үүсвэр: Сүхбаатар Тохжилт, үйлчилгээний компани болон ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо

(Тайлбар):

*Энэхүү мэдээллийн бүтэн жилийн тооцоог 2004 оны 3 дугаар сарын 15-наас 12 дугаар сарын 31-ний хоорондын 9.5 сарын мэдээлэл дээр тулгуурлан тооцсон

** Зуслангийн хог хаягдлыг 6-р сараас 9 дүгээр сарын хооронд 4 сарын хугацаанд цуглуулна

(5) Элэгдэл хорогдлын зардлыг дараах байдлаар тооцов:

- Барилга байшинг 50 жил ашиглана
- Машин, төхөөрөмж 10 жил ашиглана
- Тавилга 5 жил ашиглана

(10-1) ОСНААГ-ын орон сууцны хог хаягдлын төлбөр хураасан шимтгэл нь 200 төг/хүн-ээс 4% гэж тооцов.

(10-2) Дүүргийн өрхийн дундаж хүмүүсийн тоог (4.5) "Улаанбаатар хот -ХХ зуунд" статистикийн эмхэтгэлээс үндэслэн авсан бөгөөд тэрхүү статистикийн мэдээ, тоог ашиглан орон сууцны өрхийн дундаж талбөрийн хэмжээг тооцов

Хүснэгт 3-30: Чингэлтэй Тохжилт, үйлчилгээний компанийн 2004 оны "Орлого-Зарлага-Ашиг"

нэгж: 000 төг

№	Зардлын зүйл анги	Хог хаягдал цуглуулах үйлчилгээ			Бусад үйлчилгээ (цэвэрлэгээ, тохижилт бусад)	Нийт
		Гэр хороолол	Орон сууцны хороолол	Байгууллага		
1	Орлого	43,460	45,000	148,515	75,000	311,975
	<i>Үйл ажиллагааны зардал:</i>					
2	Цалин, нийгмийн даатгалын зардал	33,938	7,909	7,884	37,379	87,111
3	Түлш, тосолгооны материалын зардал	50,011	32,014	28,950	22,581	133,555
4	Засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл авах зардал	5,241	3,355	3,034	0	11,630
5	Элэгдэл хорогдлын зардал	6,073	3,887	3,515	2,742	16,218
6	Захиргааны зардал	6,488	3,244	2,974	4,775	17,481
7	Бусад зардал	22,773	11,680	10,562	27,858	72,873
8	Үйл ажиллагааны нийт зардал	124,524	62,090	56,919	95,335	338,868
9	Цэвэр ашиг	-81,064	-17,090	91,596	-20,335	-26,893
					Цуглуулах хэмжээ (тонн/жил) Нэгжийн зардал (төг/тонн)	
10	Сарын хураамж (нэгж: төг/өрх)	2,400	864	10,314		
11	Сарын нэгж зардал (нэгж: төг/өрх)	6,877	1,192	3,953		
12	Хогны төлбөр төлж буй өрх/байгууллагын дундаж тоо	1,509	4,340	1,200		
13	Хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоо	14,137	5,981			
14	Төлбөр хураах хэмжээ (нэгж: %)	11	73			

Эх үүсвэр: Чингэлтэй Тохжилт, үйлчилгээний компани болон ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо

(Тайлбар):

* Тээврийн цэхийн ихэнх зардлыг түлшний зардал эзлэх хувийг харгалзан хог хаягдлын үйлчилгээний зардалд хуваасан болно.

(5) Элэгдэл хорогдлын зардлыг дараах байдлаар тооцов:

- Барилга байшинг 50 жил ашиглана
- Машин, төхөөрөмж 10 жил ашиглана
- Тавилга 5 жил ашиглана

(10-1) ОСНААГ-ын орон сууцны хог хаягдлын төлбөр хураасан шимтгэл нь 200 төг/хүн-ээс 4% гэж тооцов.

(10-2) Дүүргийн өрхийн дундаж хүмүүсийн тоог (4.5) "Улаанбаатар хот -ХХ зуунд" статистикийн эмхэтгэлээс үндэслэн авсан бөгөөд тэрхүү статистикийн мэдээ, тоог ашиглан орон сууцны өрхийн дундаж талбөрийн хэмжээг тооцов

(13) Гэр хорооллын хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоог "Улаанбаатар хот -ХХ зуунд" статистикийн эмхэтгэлээс, орон сууцны хорооллын хувьд ТҮК-ээс тус тус үндэслэн авав

Хүснэгт 3-31: Налайх Тохижилт, үйлчилгээний компанийн 2004 оны
"Орлого-Зарлага-Ашиг"

нэгж: 000 төг

№	Зардлын зүйл анги	Хог хаягдал цуглуулах үйлчилгээ		Бусад үйлчилгээ (цэвэрлэгээ, тохижилт бусад)	Нийт
		Гэр хороолол	Орон сууцны хороолол*		
1	Орлого	7,107	5,929	53,136	66,172
	<i>Үйл ажиллагааны зардал:</i>				
2	Цалин, нийгмийн даатгалын зардал	8,297	1,692	9,049	19,038
3	Түлш, тосолгооны материалын зардал	5,214	4,350	2,946	12,510
4	Засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл авах зардал	5,851	975	0	6,826
5	Элэгдэл хорогдолын зардал	2,043	1,705	1,154	4,903
6	Захиргааны зардал	3,474	1,315	4,800	9,589
7	Бусад зардал	4,544	462	20,493	25,500
8	Үйл ажиллагааны нийт зардал	29,423	10,499	38,441	78,364
9	Цэвэр ашиг	-22,316	-4,570	14,695	-12,192

Цуглуулах хэмжээ (тонн/жил)
Нэгжийн зардал (төг/тонн)

10	Сарын хураамж (нэгж: төг/өрх)	700	630		
11	Сарын нэгж зардал (нэгж: төг/өрх)	2,898	1,116		
12	Хогны төлбөр төлж буй өрх/байгууллагын дундаж тоо	846	784		
13	Хогны төлбөр төлвөл зохих өрхийн тоо	4,200	936		
14	Төлбөр хураах хэмжээ (нэгж: %)	20	84		

Эх үүсвэр: Налайх Тохижилт, үйлчилгээний компани болон ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо (Тайлбар):

- (1) Орон сууцны хураамжийг цуглуулах ажлыг ОСНААГ-аас Налайх ТҮК-д 2004 оны 5-р сард шилжүүлсэн.
- (2) Санхүүгийн бүртгэл нь ойлгомж муутай байсан тул байгууллагын хог хаягдлын цуглуулах зардлыг тусад нь салгаагүй болно
- (3) Зарим байгууллагууд гэр болон орон сууцны хог хаягдлыг цуглуулах зардалд орсон болно
- (10-2) Дүүргийн өрхийн дундаж хүмүүсийн тоог (4.2) "Улаанбаатар хот -ХХ зуунд" статистикийн эмхэтгэлээс үндэслэн авсан бөгөөд тэрхүү статистикийн мэдээ, тоог ашиглан орон сууцны өрхийн дундаж талбөрийн хэмжээг тооцов
- (5) Орон сууцны өрхийн сарын хог хаягдлын төлбөрийг өрхийн дундаж хүний тоо болох 4.2-т үржүүлэн тооцсон болно.
- (6) Элэгдэл хорогдлын зардлыг дараах байдлаар тооцов:
 - Барилга байшинг 50 жил ашиглана
 - Машин, төхөөрөмж 10 жил ашиглана
 - Тавилга 5 жил ашиглана

Хүснэгт 3-32: Нөөц компанийн 2004 оны "Орлого-Зарлага-Ашиг"

нэгж: 000 төг

№	Зардлын зүйл анги	Хогийн цэг	Нохой устгал	Нийт
	<i>Орлого</i>			
1	Нохой устгал, хотоос		49,273	49,273
2	Хог хаягдал дарж булах, хотоос	28,000		28,000
3	Хог хаягдал дарж булах, байгууллагаас	18,451		18,451
4	Үл хөдлөх хөрөнгө борлуулах орлого	4,033		4,033
5	Бусад орлого (нохойны арьс худалдах)		1,500	1,500
	Нийт орлого	50,484	50,773	101,257
	<i>Үйл ажиллагааны зардал:</i>			
6	Цалин, нийгмийн даатгалын зардал	14,900		14,900
7	Түлш, тосолгооны материалын зардал	21,509		21,509
8	Засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл авах зардал	6,134		6,134
9	Элэгдэл хорогдолын зардал	6,260		6,260
10	Захиргааны зардал	13,933	7,278	21,211
11	Бусад зардал	18,739	35,282	54,021
12	Нийт зардал	81,475	42,560	124,035
13	Цэвэр ашиг	-30,991	8,213	-22,778
14	Хогны хэмжээ (м3) / нохойны тоо	373,127	32,848	
15	Дундаж орлого	135	1,546	
16	Дундаж зарлага	218	1,296	

Эх үүсвэр: Нөөц компани болон ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо (Тайлбар):

- (1) Зардлын тооцоог сарын санхүүгийн баримт дээр тулгуурлан ня-бо-той хамтран хийсэн, Компаниас хүргүүлсэн орлогын баримт болон бусад материал
- (2) Элэгдэл хорогдлын зардлыг дараах байдлаар тооцов:
 - Барилга байшинг 50 жил ашиглана
 - Машин, төхөөрөмж 10 жил ашиглана
 - Тавилга 5 жил ашиглана

в. Үндсэн үзүүлэлтүүд болон дүн шинжилгээ

ТҮК-ийн үзүүлэх үйлчилгээ бүрийн нийт орлогод эзлэх хувь хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв³.


Хүснэгт 3-33: ТҮК болгоны үзүүлэх үйлчилгээ бүрийн нийт орлогод эзлэх хувь хэмжээ (2004)

	Баянгол	Баянзүрх	Хан-уул	Сонгино хайрхан	Сүхбаатар	Чингэлтэй	Налайх
Гэр хорооллын хог хаягдлыг цуглуулах	2%	9%	10%	20%	1%	14%	11%
Орон сууцны хорооллын хог хаягдлыг цуглуулах	48%	19%	16%	32%	14%	14%	9%
Албан байгууллагын хог хаягдлыг цуглуулах	31%	34%	21%	18%	40%	48%	-
Бусад үйлчилгээ (нийтийн эзэмшил газар цэвэрлэх, ногоон байгууламжийн арчилгаа зэрэг)	19%	38%	53%	30%	45%	24%	80%
Нийт	100%	100%	100%	100%	100%	100%	100%

Эх үүсвэр: ТҮК

Гэр хорооллоос орох орлогын хэмжээ нь ихэнх ТҮК-иудын нийт орлогод бага хувийг эзлэж байна. Гэр хорооллын үйлчилгээний орлогоос хамгийн их хамааралтай ТҮК бол Сонгинохайрхан ТҮК байна (20%). Чингэлтэй болон Налайх ТҮК-ийн эс тооцвол орон сууцны хог хаягдлыг цуглуулах үйлчилгээнээс орох орлого гэр хорооллын орлогын хувь хэмжээнээс дээгүүр байна. Орон сууцны үйлчилгээний орлогоос хамгийн их хамааралтай ТҮК бол Баянгол ТҮК байна (48%). Албан байгууллага, ААН-ийн үйлчилгээнээс хамгийн их орлоготой ТҮК нь Чингэлтэй ТҮК (48%) бөгөөд нийтийн эзэмшлийн зам талбайны цэвэрлэгээний үйлчилгээнээс хамгийн их орлоготой нь Баянзүрх (38%), Хан-Уул (53%), Сүхбаатар (45%) болон Налайх (80%) ТҮК тус тус байна.

Дараах зургаар бүх ТҮК-дын нийт орлого, нийт зарлага болон цэвэр ашигийг үзүүлэв. Баянгол, Баянзүрх, Сүхбаатар ТҮК-ийн үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээ нь нэлээд өргөн хүрээтэй байхад Налайх ТҮК нь Сүхбаатар ТҮК-ийн үйл ажиллагааны дөнгөж аравны нэгтэй л тэнцэж байна. Долоон ТҮК-ээс 2004 оны байдлаар зөвхөн Баянгол, Баянзүрх ТҮК нь цэвэр ашигтай гарсан байна.




Эх үүсвэр: ТҮК болон ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо

Зураг 3-24: ТҮК-ийн нийт орлого, нийт зардал болон цэвэр ашиг (2004)


³ Сүхбаатар ТҮК нь гэр хорооллын хог хаягдлыг цуглуулдаггүй тул дээрх үзүүлэлт нь зуслангийн айлуудын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээний хувь хэмжээ гэж энэхүү тайланд тусгагдсан.

Дараах зурагт ТҮК-ийн гэр болон орон сууцны хорооллын орлого ба зардлыг үзүүлэв. Бүх ТҮК нь гэр хороололд алдагдалтай ажиллаж байгаа нь харагдаж байна. Ялангуяа, Сонгинохайрхан болон Чингэлтэй ТҮК-ийн алдагдал нэлээд өндөр бөгөөд тэрхүү алдагдал нь компанийн нийт үйл ажиллагаанд нэлээд хүндрэл учруулж байна. Орон сууцны хорооллын орлого, зарлагын хувьд дөрвөн ТҮК ашигтай ажиллахын сацуу Баянгол ТҮК-ийн орлого нэлээд өндөр байна. Нөгөөтэйгүүр, Сүхбаатар, Чингэлтэй, Налайх ТҮК-ийн хувьд орон сууцны хог хаягдлыг цуглуулах үйлчилгээний зардал нь орлогоос их гарсан байна.



Зураг 3-25: Гэр хорооллын ТҮК-ийн орлого ба зардал (2004)


Эх үүсвэр: ТҮК ба ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо



Зураг 3-26: Орон сууцны хорооллын ТҮК-ийн орлого ба зардал (2004)


Эх үүсвэр: ТҮК ба ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо

Гэр болон орон сууцны хорооллын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээний ТҮК-ийн сарын хураамж болон нэг өрхөд ногдох зардлын хэмжээг Зураг 3-27 ба Зураг 3-28-т үзүүлэв. Нэг өрхөд ногдох ТҮК-ийн сарын зардал нэлээд зөрүүтэй байна. Баянгол болон Чингэлтэй ТҮК-ийн зардал 6,500 төгрөгөөс ч их байхад Хан-Уул дүүргийн хувьд зөвхөн 1,300 төгрөг байх жишээтэй. Түүнчлэн сарын хогны хураамжийн дундаж хэмжээ ТҮК хооронд нэлээд зөрүүтэй байна. Жишээлбэл, Налайхад 700 төгрөг байхад Чингэлтэд 2,400 төгрөг байна.



Зураг 3-27: ТҮК-ийн сарын хураамж болон нэг өрхөд ногдох зардлын хэмжээ, гэр хороололд (2004)


Эх үүсвэр: ТҮК ба ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо




Зураг 3-28: ТҮК-ийн сарын хураамж болон нэг өрхөд ногдох зардлын хэмжээ, орон сууцны хороололд (2004)

Эх үүсвэр: ТҮК ба ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо


Дээр дурьдсан ТҮК-ийн санхүүгийн байдлын хоорондын зөрүүг харуулсан ТҮК-ийн үзүүлж буй үйлчилгээ бүрээс орох цэвэр ашгийг дараах зурагт үзүүлэв.




Баянгол




Баянзүрх




Хан-Уул




Сонгинохайрхан



Сүхбаатар



Чингэлтэй



Налайх

Зураг 3-29: ТҮК-ийн үзүүлж буй үйлчилгээ бүрээс орох цэвэр ашиг (2004)

Эх үүсвэр: ТҮК ба ЖАЙКА-ийн судалгааны багийн тооцоо

ТҮК болгоны онцлог байдлыг дараах байдлаар тодорхойлов.

Баянгол ТҮК Компанийн орлогын гол эх үүсвэр нь нийт орлогын 48 хувийг эзлэх орон сууцны хорооллын хог хаягдлыг ачиж цуглуулах үйлчилгээ юм. Түүнчлэн нийт орлогын 31 хувийг албан байгууллагаас орох орлого эзлэнэ. Компанийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын тоо нь харьцангуй цөөн (560) боловч хэмжээний хувьд томоохон байгууллагууд байна.

Баянгол ТҮК нь 2004 онд ашигтай ажилласан хоёр ТҮК-ийн нэг нь юм. Компани нь гэр хорооллын хог хаягдлыг цуглуулах, зам талбайг цэвэрлэх, тохижилт ногоон байгууламж байгуулах зэрэг үйл ажиллагаандаа алдагдалтай ажилласан боловч орон сууцны хог хаягдлыг цуглуулах үйлчилгээний ашиг орлого (86 сая төгрөг) хангалттай байсан тул тэрхүү алдагдлыг нөхөж чадсан байна. Компанийн цэвэр ашиг 26 сая төгрөг болжээ.

Гэр хорооллын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ нь алдагдалтай байсан гол шалтгаан нь нэг өрхөд ногдох үйл ажиллагааны зардлын хэмжээ 7,000 төгрөг буюу тухайн өрхөөс орох сарын орлогоноос 6 дахин өндөр байна. Баянгол дүүргийн гэр хорооллын бүс нь харьцангуй жижиг тул ажлын хүч болон тоног төхөөрөмжийн ашиглалт дээр үрлэгэн зарлага ихээр гарч компанийн үйл ажиллагааны зардал өндөр гарсан байж болзошгүй.

Баянзүрх ТҮК Компанийн орлогын гол эх үүсвэр нь байгууллагын хог хаягдлыг цуглуулах болон бусад үйлчилгээнээс орсон буюу 2004 онд нийт орлогын 34% болон 38%-ийг тус тус эзэлж байв. Баянгол ТҮК-ийн ижил, компанийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын тоо нь харьцангуй цөөн (680) боловч хэмжээний хувьд томоохон байгууллагууд байдаг байна.

Байгууллагуудын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ нь компанийн орлогын гол эх үүсвэр байсан боловч энэхүү ангилалд компани нь мөн алдагдалтай байсан байна (11 сая төгрөг). Түүнчлэн гэр хорооллын хог хаягдлыг цуглуулх үйлчилгээ нь алдагдалтай байсан (22 сая төгрөг) боловч тухайн жил компани нь дүүргийн төсвөөс санхүүжүүлэх ажил үйлчилгээнээс орох орлогын дэмжлэгтэйгээр 28 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Хан-Уул ТҮК Хан-Уул ТҮК-ийн орлогын гол эх үүсвэр дүүргийн санхүүжилттэй ажил үйлчилгээнээс орох боловч (нийт орлогын 53%, 2004) тэрхүү үйлчилгээний үйл ажиллагааны зардал маш өндөр, алдагдалтай (17 сая төгрөг) байдаг тул ашиггүй байдаг байна.

2004 онд компани 29 сая төгрөгний цэвэр алдагдалтай ажиллажээ. Зөвхөн байгууллагын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ нь ашигтай гарчээ (8сая төгрөг). Тус компани нь орон сууцны хог хаягдлыг цуглуулах үйлчилгээний орлогоос ч ашиг олж чадаагүй байна.

Сонгинохайрхан ТҮК Сонгинохайрхан ТҮК нь бүх дөрвөн төрлийн үйлчилгээнээсээ жигд орлоготой ажилладаг байна. Үүнд: орон сууцны хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ (32%); дүүргийн санхүүжилттэй бусад үйлчилгээ (30%); гэр хорооллын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ (20%); болон байгууллагуудын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ (18%).

Сонгинохайрхан ТҮК нь 2004 онд ТҮК-иудын дунд хамгийн их алдагдалтай ажилласан байна: 37сая төгрөг. Компанийн нийт алдагдалын гол шалтгаан нь гэр хорооллын үйлчилгээнээс хамгийн их алдагдалтай ажилласан бөгөөд (104 сая төгрөг) түүнийгээ бусад ашигтай байсан үйлчилгээгээр ч нөхөж дийлээгүй байна. Гэр

хороололд алдагдалтай ажиллаж буй гол шалтгаан нь тухайн дүүргийн хамрах гэр хорооллын өрхийн тоо хамгийн их юм (4,000 орчим өрх).

Сүхбаатар ТҮК Сүхбаатар ТҮК-ийн орлогын гол эх үүсвэр нь дүүргийн санхүүжилттэй ажил үйлчилгээ (45%) бөгөөд байгууллагын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ (40%) юм.

2004 онд тус компани нь 22 сая төгрөгний алдагдалтай ажилласан бөгөөд тэрхүү алдагдал нь орон сууцны хог хаягдлыг цуглуулах үйлчилгээнээс гарсан байна. (45 сая төгрөг)⁴. Дүүргийн санхүүжилттэй ажил үйлчилгээнээс ашигтай (33 сая төгрөг) ажилласан боловч энэхүү ашиг нь хог хаягдлыг цуглуулах үйлчилгээний алдагдлыг нөхөхөд хангалтгүй байсан байна.

Чингэлтэй ТҮК ТҮК-ийн орлогын гол эх үүсвэр нь байгууллагын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ (48%) юм.

2004 онд компани нь 27 сая төгрөгний алдагдалтай ажилласан байна. Алдагдал нь гол төлөв гэр хорооллын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ байсан байна (81 сая төгрөг). Түүнчлэн тус компани орон сууцны хог хаягдлыг цуглуулах (17 сая төгрөг) болон дүүргийн санхүүжилттэй үйлчилгээнээс ч (20 сая төгрөг) тус тус алдагдалтай ажилласан байна. Бусад ТҮК-тэй харьцуулахад Чингэлтэй ТҮК нь байгууллагын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээнээс хамгийн их ашигтай ажилласан боловч (92 сая төгрөг) нийт алдагдал нь ашгаас хамаагүй их байв.

Налайх ТҮК Компанийн орлогын гол эх үүсвэр нь дүүргийн санхүүжилттэй зам талбайн цэвэрлэгээ болон ногоон байгууламжийн арчилгааны ажил болно (80%).

2004 онд тус компани 12 сая төгрөгний алдагдалтай ажиллажээ. Алдагдлын хэмжээ нь бусад ТҮК-тэй харьцуулахад бага боловч Налайх дүүргийн хэмжээнд нь аваад үзвэл алдагдал нь нэлээд өндөр байна.

с. Дүгнэлт

ТҮК-ийн санхүүгийн байдал дээр дүгнэлт хийж дараах байдлаар хураангуйлав.

- Бүх ТҮК-д гэр хорооллын хог хаягдлыг цуглуулахад алдагдалтай ажилладаг.
- Одоогийн хогны төлбөр хураах дутагдалтай тогтолцоог дүгнэхэд тухайн компанийн хамрах гэр хороолол нь хэмжээний хувьд том байх тусам хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ нь доголдож ирдэг байна. Иймд бизнесийн үр ашгийн хувьд аваад үзэхэд ТҮК нь гэр хороололд үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээ нь бага байх тусам тэдгээрт ашигтай байна.
- Орон сууцны болон байгууллагын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ нь ихэнх ТҮК-ийн хувьд ашигтай боловч Сүхбаатар зэрэг ТҮК нь орон сууцны хог хаягдал цуглуулахад алдагдалтай ажилласан хэвээр байна.
- Хог хаягдлыг цуглуулах үйлчилгээний нэгж зардал нь хогийн цэг рүү тээвэрлэх зайны асуудлыг оролцуулахгүйгээр дүүрэг болгонд өөр өөр байна. ТҮК-ийн менежментийн багийг сонгоход өрсөлдөн бага байдаг байдлаас шалтгаалан ТҮК-ийн үр ашиггүй үйл ажиллагаанд нөлөөлж байгаа болов уу.

⁴ Гол шалтгаан нь зардал хянах тогтолцоо нь дутагдалтай байж болзошгүй.

3.3.6 Хүнийн нөөцийг хөгжүүлэх тогтолцоо

Чингэлтэй ТҮК-д хувьчлахаас өмнө 116 ажилчин байсан бөгөөд дараа нь 2 хүн халагдаж 15 хүн шинээр ажилд авсан бөгөөд шинэ засварын цех ашиглалтанд ороход Чингэлтэй ТҮК нийт 150 ажилчидтай болох явдал нь бараг ашигтай ажилдаггүй компани нь дэндүү их ажилчид авч ажиллуулж байна гэж харагдах боловч энэхүү үзэгдэл нь нэлээд түгээмэл үзэгдэл юм. Хатуу хог хаягдлын салбарт ажиллаж байгаа ажилчид нь менежментийн хувьчлалын үеэр өөрсдийн компанийн удирдлагаа дэмжиж байсан байдлыг ажиглахад Улаанбаатар хотод ажилгүйдлийн түвшин дээд цэгтээ хүрсэн байдалтай холбож тайлбарлаж болох юм. Одоогоор байнгын болон улирлын чанартай ажилчидыг Улаанбаатар хотод сарын 50,000 төгрөг цалинжуулаад авч ажиллуулах боломжтой байна. 2004 оны 3 дугаар сарын 19-ний өдөр тогтоосон амжиргааны баталгаат доод хэмжээг сарын 26,500⁵ төгрөг гэж тогтоосон нь таван хүнтэй гэр бүлд огт хангалтгүй мөнгөн дүн юм.

ТҮК-ийн ажилчины цалингийн нийтлэг хэмжээ сард 70,000-80,000 төгрөг. Жишээлбэл, Чингэлтэй ТҮК-ийн захирал компани нь хувьчлагдсаны дараа гэр хороололд ажиллах ачигчийн сарын цалинг 40,000 төгрөгөөс 80,000 төгрөг болгож нэмэгдүүлсэн боловч захирал өөрөө нэг дундаж гэр бүлийг тэжээхэд хүрэлцэхүйц мөнгө биш гэж байв. Түүнчлэн ажилчид ажлын цаг барих, ажлын үр дүн нэмэгдүүлэх зэрэг асуудлаар онооны урамшуулалын 10 онооны тогтолцоо нэвтрүүлсэн байна. Жишээлбэл, сайн ажиллаж 10 оноо авсан хүн цалингаа бүрэн гүйцэд буюу 80,000 төгрөг авна. Хэрэв тухайн ажилчин авбал зохих оноогоо авч чадаагүй бол онооны хэмжээгээр цалингийн суутгаж олгодог байна.

Ажлын хүчний зардал нь нийт зардлын тал орчим хувь байдаг бөгөөд ТҮК-ийн үндсэн үзүүлэлтүүд гэсэн санал асуулгын дагуу дунджаар Хан-Уул, Сүхбаатар ТҮК-д сарын цалийн 105,000 төгрөгөөс Чингэлтэй ТҮК-ийн 300,000 төгрөгийн хооронд хэлбэлздэг байна. Хан-Уул дүүрэгт гэр хорооллын ачигч нар сард 150,000 төгрөгний цалинтай бөгөөд орон сууцны хороололд ажилдаг ачигчид ресийн тоо нь илүү гэдэг шалтгаанаар арай өндөр цалинтай байдаг байна. Конторын ажилчид сард 80,000-150,000 төгрөний цалинтай бөгөөд унаа гэх мэт нэмэгдэл авч заримдаа хагас жилийн шагнал авах боломжтой байдаг юм байна. Энэхүү цалингийн хэмжээ болон урамшуулалын тогтолцоо нь төрийн салбарт ажиллаж буй ижил төрлийн ажил эрхлэх хүмүүстэй харьцуулахад илүү сайн нөхцөлтэй байна.

Нөөц компанийн сарын цалин зөвхөн дунджаар 60,000 төгрөг болно. Компани нь өөрийн төсвийг шийдвэрлэх эрхгүй байдаг тул төсвийн хэлэлцээ хийхэд хүндрэтэй байдаг. Компанийн цалингийн хэмжээг Нийслэлийн өмчийн харилцааны газар тогтоодог байна. Ажлын хүч нь дунджаар 2-3 жилд солигдож байдаг бөгөөд энэхүү үзүүлэлт нь төрийн албан хаагчийн хувьд нэлээд өндөр үзүүлэлт юм. Шинээр ажилдавах хүмүүс нь ихэвчлэн хог түгч нар байдаг байна.

Зах зээлийн эдийн засаг хэр их үр ашигтай байгааг Нөөц компанийн жишээн дээр харж болно. Жишээлбэл, компанийн хамгийн үнэ цэнэтэй ажилчин бол бульдозерийн операторч бөгөөд сарын 120,000 төгрөгийн цалин нь компанийн захирлын цалин (92,000 төгрөг)-гаас ч өндөр байна. Саяхан солигдсон Нөөц компанийн захирал 1999 оноос хойш ажиллаж байсан бөгөөд өмнө нь 1993 оноос эхлэн Сонгинохайрхан ТҮК-ийн захирлын албан тушаалыг хашиж байжээ. Тэр үеийн ТҮК-ийн орлого нь зардлаас хамаагүй давж гардаг байсан явдлыг Нөөц компанийн өнөөгийн алдагдалтай ажиллаж байгаа байдалтай нааштай харьцуулалт хийж болж байна.

⁵ Ядуурлын түвшинг шинэчилж 30,000 төгрөг болгосон, 2005 оны 3 дугаар сарын байдлаар.

Энэхүү салбарын ахлах ажилтан нь хатуу хог хаягдлын менежментийн чиглэлээр дагнан дээд боловсрол эзэмшиж туршлагатай болсон байна. Жишээлбэл, Нөөц болон ТҮК-ийн үйл ажиллагааг хянах ЗАА-ны Хот тохижилтын хэлтсийн ажилтан нь тэрхүү албан тушаал дээр хамгийн доод тал нь 2 жил, дунджаар 7 жил орчим болсон байна. Хотын захиргааны хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэнүүд нь дээд боловсролтой, аль болох хатуу хог хаягдлын менежментийн чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн, доод тал нь 5 жилийн ажлын туршлагатай байх шаардлагатай. Тэдгээр нь өөрийн ажлын байран дээр олон төрлийн асуудал хариуцах нь тухайн ажлын байр сонирхолтой болох бөгөөд өнөөгийн шилжилтийн эдийн засгийн үед санал бодол солилцох боломжийг олгодог байна.

Хатуу хог хаягдлын менежментийн салбарт ажиллах боловсон хүчний тоо хангалтгүй гэж үзэх боловч өнөөгийн Засгийн газрын бүтцийн хүрээнд орон тоог нэмэгдүүлэх боломжгүй юм. Нөгөөтэйгүүр, ЗАА-ны Хот тохижилтын хэлтсийн орон тоог 11-ээс 8 болгож бууруулсан байна. Хэлтэс нь өөрийн орон тоог нэмэгдүүлэх талаар Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд асуудал оруулсан боловч эцсийн шатанд энэхүү асуудлыг Засгийн газрын кабинетийн шийдвэрээр шийдвэрлэнэ.

1990 оноос хойш бодлогын болон хяналт тавих дээд шатны төрийн албан хаагч нар хатуу хог хаягдлын асуудлаар гадаад, дотоодод сургалт семинарт хамрагдаж гадаад орны туршлага, сүүлийн үеийн технологийн талаар сурж судалсан болно. Гэсэн хэдий ч үйл ажиллагааны түвшинд гадаадын арга барил, технологийн талаар мэдлэг хомс байсаар байна. ТҮК хоорондын ажлын арга барилын талаар ч харьцуулалт байхгүй явдал нь шинэ, үр ашигтай ажлын аргачлал бусад тархаж нэвтрэхгүй, хотын хөгжилд хувь нэмрээ оруулах нь удаан байна. Гүйцэтгэх шатанд шинэ ажилчидад зориулсан сургалтыг ажлын байран дээр шууд гүйцэтгэж байна.

3.4 Өнөөгийн хатуу хог хаягдлын менежментийн үнэлгээ

3.4.1 Нэгдүгээр Бага хурлаар томъёолсон хатуу хог хаягдлын менежментийн асуудлын хураангуй

Одоогийн хатуу хог хаягдлын менежментийн талаар туршлага солилцо, тухайн салбарт тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийн талаар ярилцах зорилгоор анхны Бага хурлыг 2004 оны 12 дугаар сарын 9-10-ны өдөр зохион байгуулсан. Дараах хэсэгт тухайн Бага хурлаар тодорхойлсон хатуу хог хаягдлын менежментэд тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийг танилцуулж байна.

а. Хог хаягдлын асуудлаарх иргэд, олон нийтийн хандлага болон зан байдал

1. Зарим хүмүүс нь хог хаягдал гаргадаг, нөгөө хэсэг нь цэвэрлэх ёстой гэсэн ойлголт олны дунд байна.
2. Хүмүүсийн ёс суртахуун нэлээд доогуур болж тэдгээрийн хамтын ажиллагаа болон бусдыг хянах нь хангалтгүй байна.
3. Ядуурал газар авч иргэд хог хаягдлын үйлчилгээ төлөх чадваргүй болж улмаар хогны төлбөр төлөх ч сонирхолгүй болсон байна
4. Гэр хороололд зөвшөөрөлгүй буусан иргэд бүртгэлгүй байдаг тул хогны төлбөр төлдөггүй.

5. Хог хаягдлыг ил задгай байдлаар гуу жалга, үерийн ус зайлуулах суваг шуудуунд хаяж улмаар битүүлэн үер усны аюул үүсгэдэг. Байдлыг шийдвэрлэх хамгийн энгийн арга зам бол тэрхүү хууль бус зан үйлдлийг болих.
6. Гэр хороололд газар доорх шугам сүлжээ байхгүй тул айл болгон жорлон ухаж бохироо хаядаг бөгөөд дүүрч хөлдөх цагт ухаж гаргаад ахуйн хог хаягдлын хамт хаядаг байна.
7. Гэр хороололд малтай айл өрх олон байдаг тул тэдгээр их хэмжээний хог хаягдал гаргадаг байна (Гэхдээ энэхүү асуудал нь Мастер төлөвлөгөөний хүрээнд ноцтой асуудал гэж үзэхгүй байна).

b. Иргэд, олон нийтийн боловсрол сургалтын хангалтгүй асуудлууд

1. Хог хаягдлыг хэрхэх талаар оршин суугчид мэдлэг ухамсраар хомс байгаа боловч хүмүүс суурийн газрын хогийг хэрхэн ашиглаж боловсруулах талаарх Монголын зан үйл, уламжлал байна.
2. Хог хаягдлын хууль тогтоомжийн талаар иргэд, олон нийтийн мэдлэг хангалтгүй; аюултай хог хаягдал, бохирдол болон эрүүл мэндийн эрсдэл зэрэг хог хаягдлын асуудлаар иргэд, олон нийтэд өгөх мэдээлэл хангалтгүй байна. Хууль бус үйлдэлтэй холбоотой холбогдох торгууль шийтгэл зэрэг хог хаягдлын асуудлыг сурталчилсан, нийт ААН, байгууллагуудыг оролцуулсан нийтийн хочр гурван арга хэмжээ жил болгон зохион байгуулж хэвлэл мэдээлэл ашиглан сурталчилахыг санал болгож байна.
3. Хог хаягдлын менежментийн талаар аливаа хичээл болон тусгай хөтөлбөр цэцэрлэг, сургуулийн хөтөлбөрт байдаггүй байна.
4. Түүнчлэн дүүрэг, хороо багийн Засаг дарга нарыг ч сургалтанд хамруулах нь зүйтэй.
5. Үйлдвэрлийн хог хаягдлыг хэн, хэрхэн хаях талаар хангалттай ойлголт байхгүй байдаг тул байгууллагууд аюултай хатуу болон шингэн төрлийн хог хаягдлыг хольж бусад хогтой хамт хаяснаар байгаль орчныг ихээхэн бохирдуулж байна.
6. Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах 3R-ын үзэл баримтлалын талаар ойлголт байхгүй, хэрэжүүлдэггүй байна.
7. Зарим нь хатуу хог хаягдлын менежментийн талаар гадаад дотоодод холбогдох мэргэжлийн хүмүүсийг урт, богино хугацааны сургалтанд хамруулснаар үр дүнтэй байж болох юм гэж үзэж байна.

c. Хууль, тогтоомжийн холбогдолтой асуудлууд

1. Салбарын хуулийн хэрэгжилт хангалтгүй байхын сацуу үл ойлголцол төрүүлж байна.
2. Хариуцлагын хэмжээ хязгаар ойлгомжгүй – хот юу хариуцах, дүүрэг юу хариуцах нь үл ойлгомжтой, бүх асуудлыг ТҮК (Төхижилт, үйлчилгээний компани)-д хариуцуулж орхидог.
3. Хогны тусгай машин, контейнер сав (Сод Монгол компанийн оруулж ирж буй гэр хорооллын хогны сав) гадаадаас оруулж ирэхэд импортын татвараас хөнгөлөх шаардлагатай гэж зарим нэгэн үзэж байна.
4. Зарим хүмүүс хог ихээр гаргах импортын бараанд татвар ногдуулж орлогыг нь ТҮК-д шилжүүлэх саналтай байна.

d. Хот төлөвлөлтийн асуудлууд

1. Гэр хорооллын гудамж, зохион байгуулалт нь замбараагүй тул хатуу хог хаягдлыг менежмент хийхэд хүндрэл учруулдаг.
2. Гэр хороололд газар доорх ус, бохирын шугам сүлжээ байхгүй – иймд айл болгон өөрийн бохирын нүхийг ухаж, жорлон дүүрч өвөл хөлдөхөд гаргаж аван ахуйн хог хаягдлын хамт хаядаг байна.
3. Хог хаягдлын тээвэрлэх асуудлыг замын нөхцөл байдал хүнрэл учруулдаг: цас, халтиргаатай өгсүүр зам, замыг таглаж хаасан байдал.
4. Орон сууны байшин барилгуудыг хатуу хог хаягдал системэд тохиромжгүй; түүнчлэн хогны бункер нь муухай үнэр гаргадаг.
5. Зуслангийн бүсийг иргэд байнга орших хэлбэрээр ашиглах болсон тул өвөл зунгүй хог хаягдал цуглуулах үйлчилгээ үзүлэх шаардлагатай.
6. Хог хаягдал дэндүү их газар авч байна.

е. Бохирдолын асуудлууд

1. Хүчтэй салхинд хог хаягдал замбараагүй тархаж байгаль орчин бохирдуулдаг: хөрс, ус ба худаг, болон хог хаягдал шатааж гарах утаа нь агаар орчин бохирдуулдаг.
2. Ахуйн хог хаягдлыг аюултай хог хаягдлаас ялгадаггүй тул хог хаягдалтай шууд харьцах этгээдүүдийг эрсдэлд оруулж байгаль орчин бохирдуулж байна.
3. Зарим хувацар сав, шилийг дахин ашиглах боловч байгаль орчинд био аргаар ялзардаггүй хог хаягдал ихээр хаягдаж байна.
4. ААН-үүд үйлдвэрийн хог хаягдлыг задгай машинд ачиж тэр нь замдаа асгарах явдал гардаг.
5. Гэр хорооллын хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах нь зүйтэй гэж зарим нэг хүмүүс санл болгож байна.

ф. Эрүүл мэндийн асуудлууд

1. Хүмүүс, мал амьтан задгай хаясан хог хаягдлыг хоол хүнсэндээ хэрэглэж улмаар халдвартай өвчин авч тарааж байна.
2. Хатуу хог хаягдал хортон шавьж үржих эх үүсвэр болж байна.
3. Хог хаягдлыг ил задгай байдлаар хаяснаар нийтийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.
4. Эмнэлгийн болон аюултай хог хаягдлын хогийн төвлөрсөн цэг байдаггүй тул байгаль орчин, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.
5. Иргэд олон нийтийн ерөнхий ёс суртахуун орчин хог хаягдлын менежментэд сөргөөр нөлөөлж байна.

г. Технологийн асуудлууд

1. Хог хаягдал тээвэрлэх машин техник нь хуучирч, нэмэлт хангамж байхгүй болж тэдгээрийн засвар үйлчилгээ тогтмол түвшинд хийгдэхгүй болсон. Цас цэвэрлэх төхөөрөмжийн хангамж дутмаг.
2. Гудамжны хогийн савны тоо хангалтгүй.
3. Хог хаягдлыг ангилан ялгадаггүй.
4. Гараж, дулаан ажлын байр, цахилгаан, усан хангамж, дунд шатны хог боловсруулалтын байгууламж зэрэг байгуулмжтай хогийн төвлөрсөн цэг байгуулах шаардлагатай байна.

5. Зарим хүмүүс дүүрэг бүр дээр хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах байгууламж байх ёстой гэж илэрхийлэх боловч дүүргийн төсөвт нэлээд хүндрэлтэй байх болов уу.
6. Гэр хорооллын хогны савны хэмжээ дэндүү жижиг байна.
7. Аюултай химийн хог хаягдал арж булах хогийн төвлөрсөн цэгийг Сонигинохайрхан дүүргийн Тахир соёот гэдэг газар байгуулах саналтай байгаа бөгөөд холбогдох зураг, зардлыг тооцолсон боловч санхүүгийн асуудлааас шалтгаалан байгуулах асуудал хойшлогдоод байна. Иймд бусад хувилбаруудыг судлах шаардлагатай.

h. Санхүүгийн асуудлууд

1. Хуулинд тусгагдсан хог хаягдлын үйлчилгээний сан байхгүй.
2. Гэр хорооллын иргэд оршин суугчид хогны төлбөр төлөх чадваргүй, хороо гудамжны бүртгэл тодорхойгүй тул хогны төлбөр бүрэн гүйцэд хураагдаггүй. Хатуу хог хаягдлын төлбөр 1999 оны түвшинд хэвээр байгаа бөгөөд хогны төлбөр хураалтын хувь хэмжээ дөнгөж 30-40%-тай байна. Иймд хогны төлбөр цуглуулах системийг ерөнхий татварын тогтолцооны хүрээнд ч юмуу өөрчлөх цаг болсон.
3. Зарим хүмүүс хог хаягдлыг үнэ цэнэтэй бүтээгдэхүүн гэж үзэж хаягдал түүхий эд дахин ашигладаг, экспортлодог компаниудад татварын хөнгөлөлт олгох хэрэгтэй гэж үзэж байна. ТҮК-иуд тэрхүү асуудлын менежментэд оролцож төрийн зүгээс дахин боловсруулах байгууламжийн газрын асуудлыг шийдвэрлэж өгөх боломжтой юм.

i. Үйл ажиллагааны асуудлууд

1. Хог хаягдал цуглуулах тогтсон хуваарь байхгүй тул иргэд хэдийд ч хамаагүй хаяж байна.
2. Хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр нь ангилан ялгадаггүй тул гарах хэмжээ нь дэндүү их байна гэжээ. Цэнэглэх зай батарей болон автомашины тос масл зэрэг аюултай хог хаягдлыг оролцуулан анхан шатны дахин ашиглалт, рисайкл үйл ажиллагаа хийгддэггүй байна.
3. Хром, туглага, цацраг идэвхт зэрэг хүнд металл агуулсан үйлдвэрийн хог хаягдлын зориулалтын дагуу дарж булдаггүй бөгөөд тэдгээрийг хэрхэх талаар аливаа механизм байхгүй байдаг байна.
4. Санхүүгийн хүндрэл бэрхшээлээс шалтгаалан хог хаягдлыг зориулалтын дагуу дарж булахгүй байна.
5. Албан бус хог түүгч нар аливаа зохион байгуулалт, менежментэд ордоггүй тул цаашид тэдгээр хүмүүсийг зохион байгуулах шаардлагатай байх тул ТББ-дыг тэрхүү ажилд идэвхтэй оролцуулж болох юм.
6. Мэргэжлийн хяналтын газар нь хууль зөрчсөн өрх, ААН-ийг бус ТҮК-ийг торгодог бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор хорооны түвшинд нэг байцагч ажиллуулах шаардлагатай талаар санал гаргажээ.
7. Хог хаягдал тээвэрлэх бүрэн бус машин техник, хогийн төвлөрсөн цэг хүрэх хол зай, муу зам, хангалтгүй менежмент зэрэг байдлаас шалтгаалан тээврийн асуудал үүсч байна.
8. Хог хаягдал тээвэрлэх эрх аваагүй компаниуд хог үл хаях газар хаяж хууль бус хогийн цэг бий болгоод байна.

9. Баримт материал, мэдээлэл байхгүй тул хог хаягдлын хэмжээ, бүтэц, тооны талаар ойлголт байхгүй. Иймд гэр хорооллын хог хаягдлын бактерийн хувь хэмжээг судлах санал гарчээ.
10. Менежмент, мониторинг болон мэдээллийн систем тогтоогүй тул тэдгээрийг сайжруулж Монголын цаг агаарын нөхцөл байдалд тохируулах шаардлагатай байна.
11. Хяналт болон шалгах эрх үүргийг ТҮК болон иргэдэд шилжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлжээ. Түүнчлэн дүүргийн хаяналтын эрх бүхий байгууллага нь ТҮК-ийн ажилтан томилон хяналтыг гүйцэтгүүлэх; хяналтын ажилд дүүргийг бодвол ТҮК нь илүү үр дүнтэй гэж үзэх хүмүүс ч байна.
12. Ажлын аргачлал, боловсон хүчний сургалт хангалтгүй байхын сацуу ажилчидын дунд үүрэг хариуцлын тухай ойлголт огт байхгүй байна.
13. Салбарын боловсон хүчний нөөцийн чанар, цалин бага, хүнд бохир ажлын орчин зэрэг нь салбарын үр өгөөжийг буруулж байна. Иймд сайн ажилласан этгээдийн дэмжиж урамшуулал олгодог тогтолцоо бий болгох шаардлагатай байна.
14. Барилгын хог хаягдлыг ТҮК бус тухайн барилгын компанийн гэрээгээр ажиллах этгээд хариуцах боловч тэдгээр нь хууль бусаар хаях сонирхолтой тул барилгын хог хаягдал, ухмал шороо, түүнийг буцаан ашиглах зэрэг асуудлаар хууль тогтоомж шаардлагатай байна.

3.4.2 Үнэлгээ

а. Оршил

Удирдтгал тайлангийн 1 дүгээр суурь бодлогын хүрээнд судалгааны багийн зүгээс судалгааны бүсэд хатуу хог хаягдлын менежментийн асуудлыг өөрсдөө шийдвэрлэх боломжтой холбогдох Монгол Улсын Засгийн газрын байгууллагуудын чадавхийг хөгжүүлэхэд дэмжинэ гэсэн байгаа. Иймд холбогдох байгууллагуудын чадавхи болон өнөөгийн байдалд нь үнэлгээ өгөх нь чухал юм. 2 дугаар суурь бодлого нь Мастер төлөвлөгөөг аль болох бодит амьдрал дээр хэрэгжих боломжтой байх, улмаар ажлын давхардалыг арилгах, эдийн засгийн цар хүрээг илүү үр өгөөжтэй ашиглах болон тэс өөр, цоо шинэ зүйлс нэвтрүүлэх бус харин өнөөгийн институцын тогтолцоон дээр үндсэн байгуулах замаар нийт системийн үр ашгийг нэмэгдүүлэх нь чухал гэж үзэж байна.

Дээрх тайлангийн хэсэгт 2004 оны 12 дугаар сард зохион байгуулсан нэгдүгээр Бага хурлын үеэр тодорхойлсон хатуу хог хаягдлын менежментийн салбарын асуудлуудыг хураангуйлан дүгнэсэн бөгөөд тэрхүү асуудлыг тус тус доор дурьдсан байгаа болно.

Бага хурлаар тодорхойлсон тулгамдаж буй асуудал № I.10: *Менежмент, хяналт болон мэдээллийн систем нь үл нийцсэн тул тэдгээрийг сайжруулж Монголын цаг агаарт тохируулах шаардлагатай.* Хатуу хог хаягдлын менежменттэй холбогдолтой мэдээлэл нь үнэхээр хоорондоо уялдаа холбоо байхгүй, нэгдсэн бус тогтолцоотой байна. Янз бүрийн эх үүсвэрээс бидэнд ирүүлсэн мэдээ материал нь хоорондоо маш их зөрүү, ялгаатай байхын зэрэгцээ нэг эх үүсвэрийн мэдээлэл ч хоорондоо таарахгүй байгаа байдлыг бид нэгтгэх бус тэрхүү тус тусын мэдээлэл дээр тулгуурлан ямар нөлөө, үр дагавартайг байх талаар үнэлгээ өгөхийг оролдов. ТҮК-ийн хагас жилийн тайлан нь стандартын бус форматаар хийсэн байхын сацуу гол шаардагдах мэдээллийг орхигдуулсан байна. Хооронд нь харьцуулах болмжтой болгохын тулд хотын төвийн зургаан ТҮК-д үндсэн үзүүлэлтүүдийн талаарх дараах хүснэгтийн дагуу товч санал асуулга боловсруулж тараасан.

Хүснэгт 3-34: ТҮК-ийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн тухай санал асуулга

Дүүрэг _____				
Тайлагнах хугацаа: 2004 оны 1-р хагас ЭСВЭЛ 2004 оны 2-р хагас (хоёр хугацаа хоюулаа шаардлагатай)				
Орон сууцны иргэдийн тоо				
ААН-ийн гэрээний тоо				
Хогны төлбөр төлөх чадвартай гэр хорооллын иргэдийн тоо/ цуглуулах %				
/ %				
Хогны төлбөр төлж чадархгүй ядуу иргэдийн тоо				
ТҮК-ийн ажилчидын тоо				
ТҮК-ийн ажилчидад зарцуулах төгрөг.				
Үйл ажиллагаа	м3	төг орлого	Машины тоо	Ажилчидын тоо
Орон сууцны хог хаягдал				
Гэр хорооллын хог хаягдал				
Нийтийн эзэмшлийн болон далан сувгийн хог хаягдал				
Ногоон байгууламж / тохижилт				
Байгууллагын хог хаягдал				
Бусад (бохир, бохирын холбогдолтой ажил зэрэг тодорхойлох)				

в. Үйлчилгээний түвшин – Хог хаягдал ачиж цуглуулах ба тээвэрлэх


Хатуу хог хаягдлын менежмент нь бусад нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын нэгэн адил албан болон албан бус/хотын гэр хорооллын бүс/ гэж хоёр ялгагдаж байна. Орон сууцны иргэд үнэ хямд, төсвийн татаастай дулаан, халуун хүйтэн ус, бохир усны систем, засмал зам зэрэг үйлчилгээгээр хангагдахын сацуу хог хаягдлыг нь өдөр тутам ачиж цуглуулж байна. Гэр хорооллын иргэд шороон замын хажууд амьдрах, ус, түлээ, нүүрсээ худалдан авч зөөх, өөрсдөө бие засах газраа газар ухаж байгуулан өвлийн улиралд ч түүнийгээ ашиглах зэрэг ажлуудыг хийсэн ч хог хаягдал цуглуулах үйлчилгээг сард нэг удаа л авах боломжтой юм. Гэр хорооллын иргэд сард дөнгөж нэг удаа хог хаягдал цуглуулах үйлчилгээ авч 2,400 төгрөг төлж байхад нийтлэг байрны орон сууцны иргэд өдөр тутам хог хаягдал цуглуулах үйлчилгээ авчихад салд 800 төгрөг тушаадаг байна.

Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах-1 төслийн ТЭЗҮ-ийн тайлангийн 2 дугаар ботгийн хавсралтад ихэнх гэр хороололд өмнө нь албан болон албан бусаар иргэд хогоо хаядаг түр цэг байсан бөгөөд тэндээс нь хоёр долоо хоногт эсвэл сард нэг удаа хогийг нь цуглуулдаг байсан. Сүүлийн үед хог хаягдлыг айлын хашааны хаалганаас нь ачих тогтолцоонд шилжиж хогны төлбөр хураах тал дээр үр өгөөжтэй боловч үйл ажиллагааны зардал нь харьцангуй өдөр тул судалгааны баг зөвхөн энэхүү хувилбарыг бус бусад хувилбарыг ч судалж үзэх шаардлагатай гэжээ. Гэр хороололд жижиг хэмжээний, магадгүй моторт бус тээврийн хэрэгслэлээр цуглуулах нь үр ашигтай байж болох боломжтой.

Бага хурлаар тодорхойлсон тулгамдаж буй асуудал № 1.1: Хог хаягдал цуглуулах тогтсон хуваарь байхгүй тул иргэд дуртай үедээ хогоо хаяж байна. Орон сууцны иргэд байрныхаа орчин тойронд өнгө үзэмжгүй, хог түүгчид болон нохой зэрэг нь хог хаягдлыг амархан замбараагүй тараачих боломжтой хог хаях түр цэг, байгууламж байлгах сонирхолгүй байдаг боловч ТҮК нь зөвхөн ажлын цагаар буюу оршин суугчид ажиллаа явсаны дараа хог хаягдал цуглуулах ажлаа хийдэг тул иргэд гадаа, ил хаяхаас өөр аргаагүй болдог. Иймд зарим иргэд нийтийн хогийн контейнер сав ашиглахыг дэмжих боловч тэдгээр нь ихэвчлэн амархан дүүрч асрагч тархдаг байна

Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах-2 төслийн хүрээнд 2003 онд Улаанбаатар хотын гэр хорооллын 7 бүсэд 2,000 орчим өрхийн дунд судалгаа явуулж

түүний дүнг 1995 онд Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах-1 төслийн хүрээнд хийсэн судалгааны дүнтэй харьцуулж дараах зурагт үзүүлэв. 2003 онд 87,6%-ийг “хотын захиргаа”, 12,4%-ийг өрх нь хог хаягдал ачиж цуглуулах үйлчилгээ үзүүлж байсан байна. Дараах зургийг дагуу 1995 оноос хойш гэр хорооллын хог хаягдал цуглуулах үйлчилгээ эрс муудсаныг харуулж байна. Нийт хамрагдах өрхийн тал хувьд нь сард нэг удаа хог хаягдлыг цуглуулах давтамж бараг өөрчлөгдөөгүй бол хоёр долоо хоногт нэг удаа ачдаг байсан үйлчилгээ 30%-иас 7% хүртэл буурчээ. Түүнчлэн сараас илүү хугацаагаар үйлчилгээ авдаггүй болон огт авадаггүй өрхүүдийн тоо хоёр дахин нэмэгдэж 40% хүрээд байна.



Эх үүсвэр: Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах-1 төслийн ТЭЗҮ-ийн тайлангийн 2-р ботийн хавсралт, 1995 оны 12-р сар; Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах-2 төслийн ТЭЗҮ-ийн тайлан, 2003 оны 11-р сар.

Зураг 3-30: 1995 ба 2003 оны хог хаягдал цуглуулах давтамж

Жилээс жилд муудаж буй нөхцөл байдлын үнэлгээг дараах зурагт үзүүлэв.

Хүснэгт 3-35: Хогны машин нэвтрэх боломжгүй гэр хороолол

Дүүрэг	Хүн ам 2004	Өвлийн улиралд үйлчилгээ үзүүлэх боломжгүй хүн ам		Зуны улиралд үйлчилгээ үзүүлэх боломжгүй хүн ам	
		%	хүн	%	хүн
Сонигинохайрхан	114,485	10%	11,449	6%	6,869
Хан-Уул	49,401	0%	-	0%	-
Чингэлтэй	79,979	43%	33,991	23%	17,995
Сүхбаатар	62,912	10%	6,291	25%	15,728
Баянгол	29,176	10%	2,918	5%	1,459
Баянзүрх	67,994	25%	16,999	20%	13,599
Нийт	403,947	18%	71,647	14%	55,650

Эх үүсвэр: ТҮК-ийн захирлуудын тооцоо, 2005 оны 4 дүгээр сар.

Байршлаас шалтгаалан өрхүүдэд нөлөөлөх өвөл, зуны улиралд тулгарах бэрхшээлүүд: Чингэлтэй дүүргийн өгсүүр газрууд жилийн дөрвөн улирал хүндрэл учруулж, Сүхбаатар дүүргийн 11, 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн шавар шалбаг, 16 дугаар хорооны өгсүүр газар нь өвлийн улиралд нэвтрэхэд бэрхшээл учруулдаг байна. Гэр хорооллын хүн амын 55,000-72,000 орчим оршин суугчид зун болон/эсвэл өвлийн улиралд хогны машин үл нэвтрэх газар амьдарч байна. Түүнчлэн, өнөөдөр үйлчилгээ бараг авч чадахгүй байгаа тэдгээр иргэд нь хатуу хог хаягдлын менежментийн хаалганаас хаалга хүртэл гэсэн үйлчилгээг хамгийн ихээр авах шаардлагатай байгаа хүмүүс байна.


Өнөөгийн гэр хороолол нь ариун цэврийн нөхцлийг хангахгүй болон хүрээлэн буй орчныг ноцтойгоор доройтуулж буй байдлыг бүгд хүлээн зөвшөөрдөг. Судалгааны

хүрээнд хийсэн олон нийтийн санал асуулгын дагуу гэр хорооллын оршин суугчидын 82% нь гудамжинд хог хаягдал замбараагүй тархах, 69% нь эвгүй үнэр зэргийг тус тус тулгамдаж буй асуудлууд гэж тодорхойлжээ. Гудамж цэвэрлэгээний ямарваа нэгэн тодорхой арга хэмжээ авахгүй бол, нийт оршин суугчид нь хогны төлбөрөө төлсөн ч гэсэн хатуу хог хаягдлын энэхүү асуудал байсаар байх болно. Энэхүү “гудамжны цэвэрлэгээ” гэсэн асуудал нь нийт хотын хэмжээний асуудал бөгөөд ТҮК-ийн нийт ажилчдын 30 орчим хувь хотын албан хэсгийн (төлөвлөгөөт бүс буюу орон сууцны хороолол) нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний ажилд хамрагдан оролцдог боловч орон сууцны иргэдийн 66% нь хог хаягдал замбараагүй тархах байдал, 38% эвгүй үнэр зэрэг асуудлыг тулгамдаж буй асуудал гэж тодорхойлжээ.

1990 оноос өмнө, коммунист системийн үед, хогны машин цагийн хуваарийн дагуу явж аливаа ноцтой хатуу хог хаягдлын асуудал гардаггүй байжээ. Хотын статистикийн мэдээллээр (“Улаанбаатар хот–ХХ зуунд” статистикийн эмхэтгэл, НЗДТГ-ын Статистик, мэдээлэл судалгааны газар, 2004) 1980-аад оны эхээр тээвэрлэж байсан хог хаягдлын хэмжээ 1990 оны үетэй харьцуулахад гурав дахин их буюу 1981 онд 1,480,200м³ тээвэрлэсэн байхад 2003 онд 672,200м³ хог хаягдал тээвэрлэжээ. Тухайн үеийн байгууллагад хууль бусаар хог хаяхтай холбогдох санхүүгийн зардал байхгүй байгаа бөгөөд тэдгээр нь хууль бусаар хог хаях ч шаардлага байхгүй байсан байна.

Хатуу хог хаягдлын менежментийн стандарт хэт их доошоо унаж салбарын өнөөгийн дорой нөхцөл байдлын талаар олон нийт хүлцэнгүй хандаж байгаа боловч нийслэлийн захиргааны холбогдох тохижилт, үйлчилгээний газар хэлтсүүд иргэд (Хан-Уул дүүрэгт долоо хоногт гурваас дөрөв), орон сууц болон НМХГ-аас санал гомдол хүлээн авч захиргааны шат дамжлагын дагуу ТҮК-д холбогдох арга хэмжээ авахыг даалгадаг байна. Хоёр долоо хоногт нэг удаа болох дүүргийн Засаг дарга нарын хурлаар хатуу хог хаягдлын асуудал байнга яригдах бөгөөд хурлын холбогдох шийдвэрийг дүүрэг дээрээ хэлэлцэж ТҮК-д арга хэмжээ авахыг даалгадаг байна. Хатуу хог хаягдлын асуудал телевизийн мэдээгээр ч мэдээллэх явдал гардаг байна.


Судалгааны хүрээнд авсан санал асуулга нь хугацааны хувьд, ТҮК-иуд хувьчлагдаад 9 сарын дараа болсон ч асуулганд оролцогчид тэдгээрийн үйл ажиллагааны талаар бодит үнэлгээ өгөв. Дараах зурагт орон сууцны иргэд ихэнх нь өөрчлөлт орсон эсэхийг анзаараагүй боловч оршин суугчид үйлчилгээний чанар муудсан гэхээсээ сайжирсан гэжээ (31% : 5%). Түүнчлэн бизнесийн ААН-ийн нэгжийн дунд судалгаа авахад хог хаягдал цуглуулах үйлчилгээ хувьчлагдсаны дараа бага зэрэг сайжирсан гэж хариуцсан боловч ихэнх ААН үйлчилгээ хангалтгүй хэвээр байгаа гэжээ. Нөгөөтэйгүүр, гэр хорооллын оршин суугчид үйлчилгээ сайжирсан гэхээсээ муудсан гэж хариулжээ (20% : 10%). Дээрх асуулгын дүнд хог хаягдал цуглуулах үйлчилгээ нь хувьчлагдсанахаа дараа тухайн салбарын үйл ажиллагаа, гол нөөц бололцоо нь үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй болон зардал өндөр гэсэн гэр хорооллоос үйлчилгээ үзүүлэхэд энгийн хялбар гэсэн бизнесийн ААН болон орон сууцны хороолол руу чиглэх болсон байна.



Зураг 3-31: Хувьчлагдсан ТҮК-ийн үйл ажиллагааны тухай оршин суугчдын санал

Эх үүсвэр: Судалгааны багийн олон нийтийн санал асуулга, 2005 оны 1 дүгээр сар.

ТҮК-дын дундаж жилийн эргэлт нь 1.5 сая ам.доллар байдаг бөгөөд нийт зардлын ихэнхийг хог хаягдал цуглуулах болон тээвэрлэх ажиллагаанд зарцуулдаг байна. ТҮК-дын үйл ажиллагаа нь ижилхэн мэт боловч тэдгээрийн хооронд нэлээд том зөрүүтэй байдаг бөгөөд дараах зурагт зургаан ТҮК-ийн хоорондын ялгааны харьцаа болон дунджыг тооцоолон үзүүлэв. 100,000 орон сууцны оршин суугчидтай Баянгол ТҮК Чингэлтэй ТҮК-ээс зургаа дахин их оршин суугчидад үйлчилдэг; Сонгинохайрхан ТҮК нь 140,000 гэр хорооллын оршин суугчидад үйлчилж байхад Сүхбаатар ТҮК нь гэр хороололд огт үйлчилгээ үзүүлдэггүй; Баянзүрх ТҮК-ийн хөрөнгийн эргэлт Чингэлтэй ТҮК-ээс гурав дахин их; Сонгинохайрхан ТҮК-ийн цуглуулах хог хаягдлын хэмжээ Хан-Уул ТҮК-ээс гурав дахин их зэрэг хоорондоо томоохон ялгаатай болно.



Эх үүсвэр: ТҮК-ийн үндсэн үзүүлэлтүүдийн талаарх санал асуулга, 2005 1-р сар .

Зураг 3-32: ТҮК хоорондын үндсэн үзүүлэлтүүдийн ялгаа

Түүнчлэн цуглуулах хог хаягдлын төрөл нь ТҮК хооронд өөр өөр байна. Гэр хорооллын хатуу хог хаягдлын хэмжээ нь Сонгинохайрхан ТҮК-д нийт цуглуулах хог


хаягдлын хэмжээнд 63%-ийг эзэлж байхад Сүхбаатар ТҮК-д 0%; шугам сүлжээний ажил Хан-Уул ТҮК-д 31%-тай байхад Сүхбаатар болон Баянгол огт байхгүй байх жишээг дараах зурагнаас үзэж болно.

Хүснэгт 3-36: ТҮК-ийн цуглуулах хатуу хог хаягдлын хэмжээний харьцаа, 2004

	Сонгино хайрхан	Хан-Уул	Чингэлтэй	Сүхбаатар	Баянгол	Баянзүрх
Орон сууц	19%	18%	20%	36%	40%	21%
Гэр хороолол	63%	25%	20%	0%	16%	32%
Байгууллага	11%	20%	0% (1.)	49%	43%	45%
Далан суваг	3%	31%	28%	0%	0%	1%
Бусад	4%	6%	15%	15%	2%	1%

Тайлбар. 1. Чингэлтэй дүүргийн байгууллагын хог хаягдлыг орон сууцны хог хаягдлаас салгах боломжгүй. Эх үүсвэр: ТҮК-ийн үндсэн үзүүлэлтүүдийн талаарх санал асуулга, 2005 1-р сар.

Ажлын хүчний бүтээмжийг Зураг 3.4.4 үзүүлэв. Сонгинохайрхан ТҮК нь Сүхбаатар болон Хан-Уул ТҮК-ээс бүтээмж нь гурав дахин өндөр байгаа нь хогийн төвлөрсөн цэгт хамгийн ойр байрлах давуу талтай холбоотой байж болно. Бага хурлын I.7. асуудлаар *Бүрэн бус техник, хогийн цэг хүртэлх хол зай, чанаргүй зам болон тааруухан менежмент зэргээс шалтгаалж тээврийн асуудал хүндрэлтэй* гэж тодорхойлохын сацуу одоогийнхоос хол хогийн цэг сонгох нь үйл ажиллагааны үр бүтээд нөлөөлж болзошгүй байдлыг Зураг 3-33-т үзүүлэв. Гэхдээ ажлын үр бүтээл, бүтээмж нь тэр болгон хогийн цэгийн ойр байршлаас шалтгаалахгүй. Жишээлбэл, Баянзүрх дүүрэг хогийн төвлөрсөн цэгээс хамгийн зайдуу оршдог дүүрэг боловч Баянзүрх ТҮК нь орлого ихтэй, томоохон бизнесийн ААН-д үйлчилгээ үзүүлдэг тул тус салбарын хэмжээнд нэлээд өндөр бүтээмжтэй ажилдаж ААН-тэй байгуулах гэрээ нь тээвэрлэх хог хаягдлын хэмжээгээрээ Сонгинохайрхан дүүргийн дундаж гэрээнээс зургаа дахин том байна. Түүнчлэн хогийн цэг рүү тээвэрлэх зайтай холбоогүй нэг бүтээмжийн асуудал бол орон сууцны иргэдийн хогны төлбөр хураалтын хувь хэмжээ Сонгинохайрхан болон Баянзүрх ТҮК нь бусад харьцуулахад маш өндөр хэмжээнд, 100 орчим хувьтай байна.




Эх үүсвэр: ТҮК-ийн үндсэн үзүүлэлтүүдийн талаарх санал асуулга, 2005 1-р сар .

Зураг 3-33: ТҮК-ийн ажилчдын ажлын бүтээмж, хог хаягдал цуглуулах тээвэрлэх хэмжээгээр, 2004.

Машины үйл ажиллагааны бүтээмжийг тээвэрлэх зайгаар тодорхойлох бөгөөд Сонгинохайрхан ТҮК-ийн машины бүтээмж нь Хан-Уул болон Сүхбаатар ТҮК-ийн машинаас гурав ба дөрөв дахин өндөр байгааг дараах зурагт үзүүлэв. Сонгинохайрхан ТҮК нь нийт 24 машинтай ч гэсэн нийт 43 машинтай Сүхбаатар ТҮК-ээс хоёр дахин их


хэмжээний хог хаягдал тээвэрлэдэг байна. Сүхбаатар ТҮК нь гэр хорооллын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ үзүүлдэггүй зөвхөн орон сууцны хог хаягдал ачдаг мөртлөө бусад ТҮК-тай харьцуулахад автомашины үйл ажиллагааны бүтээмж нь хамгийн бага байна. Өөрөөр хэлбэл, Сүхбаатар ТҮК-ийн автопарк нь бусад ТҮК-тэй харьцуулахад хамгийн их автомашинтай боловч тэдгээрийг бусадтай харьцуулахад ажлын үр бүтээмж нь хамгийн доогуур байгаа нь Нийслэлийн өмчийн харилцааны газар ТҮК-ийн цуглуулж тээвэрлэх хог хаягдлын нийт хэмжээг харгалзан автомашины дахин хувиарлалт хийх асуудал гарч ирж магадгүй.



Эх үүсвэр: ТҮК-ийн үндсэн үзүүлэлтүүдийн талаарх санал асуулга, 2005 1-р сар.

Зураг 3-34: ТҮК-ийн автомашины үйл ажиллагааны бүтээмж, хог хаягдал цуглуулах тээвэрлэх хэмжээгээр, 2004.

Тус тусын эх үүсвэрээр ТҮК-ийн цуглуулах хогны төлбөрийн хэмжээний хоорондын зөрүүг дараах зурагт үзүүлэв. Энэхүү үзүүлэлтэнд тээвэрлэх зайны асуудал үндэслэлтэйгээр гарч ирэх бөгөөд хэдий чинээ хог ачиж цуглуулах газар нь хол байна төдий чинээ зардал болон хогны төлбөрийн хэмжээ нь өндөр байх болов уу. Гэсэн хэдий ч Хан-Уул ТҮК нь нэгж м³ хог хаягдал цуглуулж тээвэрлэх үйлчилгээнээс орох орлого нь Сонгинохайрхан ТҮК-тэй харьцуулахад тав дахин өндөр байна.



Эх үүсвэр: ТҮК-ийн үндсэн үзүүлэлтүүдийн талаарх санал асуулга, 2005 1-р сар.

Зураг 3-35: ТҮК-ийн орлого, хог хаягдал цуглуулах тээвэрлэх хэмжээгээр, 2004


Дүүргийн захиргааны зохион байгуулалтыг коммунизмын үед дээрээс доошоо гэсэн шатлан захиргаадах үед байгуулжээ. Дүүрэг болон хотын захиргаа нь нийтийн аж ахуйн үйлчилгээнд зарцуулах хөрөнгө санхүүжилт олдохгүй байгаа энэ эдийн засгийн орчинд дүүрэг дээр түшиглэсэн ТҮК-ийн үйл ажиллагаа нь тохирохгүй байхын зэрэгцээ байгууллагын бүтэц, цар хүрээ ч гэсэн оновчтой хувилбар бус байна. Автомашины паркийн засвар үйлчилгээ болон нийтийн эзэмшлийн эд хогшил үйлдвэрлэх, угсрах ажлыг арай өргөн цар хүрээнд үр ашигтай хийж болно. ТҮК-ийн үйл ажиллагааны үр өгөөж нь ялгаатай байгааг дараах зурагт харуулсан бөгөөд цаашид гэрээгээр ажил үйлчилгээ хийлгэх тендерийн явцад харгалзаж үзэх нь зүйтэй.

Налайх ТҮК-ээс бусад зургаан ТҮК нь хотын төвд маш үйл ажиллагаа явуулж байнга бусад дүүргийнхээ үйл ажиллагааны зам талбайгаар орж гардаг байна. Тэрхүү зургаан дүүргийн хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг сайжруулах болон ногоон байгууламж, бусад тохижилтын ажлыг цөөн тооны үйлчилгээ үзүүлэх байгууллагуудаар гүйцэтгүүлэх нь оновчтой, илүү үр өгөөжтэй байж болно. Ер нь бол өрсөлдөн үйлчилгээний чанарыг сайжруулах болно гэж салбарын хүмүүс үзэж байгаа бөгөөд ажил үйлчилгээг гэрээгээр өрсөлдөөнд тендерийн журмаар хэрэгжүүлэх нь хамгийн оновчтой болов уу. Иймд хатуу хог хаягдлын салбарын хөрөнгө нь дүүрэг бус хотын өмчийн эзэмшилд байдаг тул хөрөнгийг тухайн оноосон дүүргийн нутаг дэвсгэрээс гадуур ажиллах боломжийг нь олговол нийт дүндээ хотын хэмжээнд л хувь нэмрээ оруулах болно.

Хатуу хог хаягдлын хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох “цуглуулах ба тээвэрлэх” үйл ажиллагаа нь хувьчлалын явцын анхан шатны үед байгаа боловч мэдээллээс тусгаарлагдсан орон зайд үйл ажиллагаа явуулж байна. Өнөөгийн бүтэц зохион байгуулалтын хүрээнд хатуу хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны чанарыг холбогдох сайжруулах арга хэмжээ, хатуу хяналт, хууль журам зөрчих этгээдэд ногдуулах шийтгэлийн тогтолцоо, санхүүгийн орлого зарлагын тайлан баланс нь хариуцах эзэнтэй зэрэг нөхцөл байдлын хүрээнд амжилттай хэрэгжих боломжтой. Түүнчлэн хатуу хог хаягдлын менежментийн үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд нээлттэй байдал, өрсөлдөөнийг нэвтрүүлэн хөхүүлэн дэмжих шаардлагатай.

с. Үйлчилгээний түвшин – хаях

Бага хурлын I.8. дугаар асуудлаар *Хог хаягдал тээвэрлэх зөвшөөрөлгүй ААН хууль бусаар хог хаяж байгаа тул хууль бус хогийн цэгүүд үүрч байна* гэж тодорхойлж тэр дундаа ТҮК болон бусад зөвшөөрөлтэй хогны машинууд ч хууль бусаар хог хаях явдал гаргаж байна. Түүнчлэн, Бага хурлын I.14 дүгээр асуудлаар *Барилгын хог хаягдлыг ТҮК бус сонирхол бүхий гэрээгээр ажиллаж буй этгээд гүйцэтгэх боловч барилгын ухсан шороо, буцааж булаах асуудлаар журам гаргахад анхаарал тавих шаардлагатай* гэж тодорхойлсон асуудлын хамт хууль бус хог хаягдал нь, жишээлбэл, албан ёсны хоёр хогийн төвлөрсөн цэг нь хотын баруун талд байрлалтай тул зүүн бүсэд ихээр бий болох; хотоос зүүн тийш 15 км зайд байрлах Бумбатад хяналт тавьсан ч барилгын компаниудын гүйцэтгэгч нар хайрга, элс авах замдаа хогоо хууль бусаар хаях явдал гарсаар байна. Хогийн төвлөрсөн цэг дээр буух байгууллагын хог хаягдлаас дарж булаах төлбөр авдаг тогтолцоо нь хог тээвэрлэх этгээдийг очихгүй, цэгийн бус газар хогоо хаяхад хүргэж байна. Энэхүү асуудлын цар хүрээг хог хаягдлын цуглуулах хэмжээ болон хогийн төвлөрсөн цэг дээр буух хэмжээний харьцуулалт дээр үндэслэн дүгнэлт хийх шаардлагатай – дараах зургийг үзэх.



Эх үүсвэр: Улаанбаатар хот–XX зуунд” статистикийн эмхэтгэл, НЗДТГ-ын Статистик, мэдээлэл судалгааны газар, 2004

Зураг 3-36: Албан ёсоор тээвэрлэсэн болон дарж булсан хог хаягдлын хэмжээ

Дээрх схем зургийн дагуу 2000 оноос хойш тээвэрлэсэн болон дарж булсан хоёр тооны зөрүү нэмэгдэж 2003 онд энэхүү зургийн тоон мэдээллийн дагуу нийт цуглуулж тээвэрлэсэн хог хаягдлын зөвхөн тал орчим хувийг дарж булсан байна. Энэхүү зөрүү нь тээвэрлэсэн хог хаягдал нь бохирын системийн бохир ус тээвэрлэсэн мэдээг оруулсан эсвэл ТҮК-дын өөрсдийн цуглуулж тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлж тайлангаа өгсөнтэй холбон тайлбарлаж болох боловч хогийн төвлөрсөн цэг дээр дарж булах хог хаягдлын хэмжээг бууруулж тайлагнах нь эргэлзээтэй. Иймд тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ байнга нэг түвшинд байна гэж үзсэн ч хоёр тооны хооронд зөрүү гарсаар байх болно. Иймд хууль бус хог хаягдал хогийн төвлөрсөн цэг дээр буух хэмжээтэй ижилхэн хууль бусаар хаягдаж дараа нь хууль бус хог хаягдлын хоёрдугаар шатны цуглуулалтын хүрээнд ч хогийн төвлөрсөн цэг дээр ирдэггүй гэж ойлгогдож байна.

2004 онд хогийн төвлөрсөн цэгүүд дээр дарж булсан хог хаягдлын мэдээллийг дараах зурагт үзүүлэв. Зарим нэг албан бус мэдээллийн сурвалжаар гэр хорооллын хүн ам орон сууцны хорооллын хүн амаас хоёр дахин их гэсэн тооцоог үл харгалзан 2004 онд Нөөц компанийн удирдах хогийн төвлөрсөн цэгүүд дээр орон сууц болон гэр хорооллоос адилхан хэмжээтэй, хотын нийт хог хаягдлын 77%-ийг дарж булсан гэх боловч УЧХЦ-т хамгийн ойр болон Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын хог хаягдлын хэмжээ нь хотын нийт гэр хорооллын дарж булсан хог хаягдлын хэмжээтэй бараг ижилхэн болж байна. Энэхүү үзэгдэл нь хогийн төвлөрсөн цэг хог хаягдал цуглуулах цэгүүдэд ойр байршилтай холбоотой байж болно. Байгууллагын хог хаягдал нийт хог хаягдлын 18%, бусад хог хаягдал 6%-ийг тус тус эзэлж байв. Хог хаягдлын төрөл болон холбогох үйл ажиллагаанууд ч хоорондоо ялгаатай байна. Хан-Уул ТҮК-ийн цуглуулах хог хаягдлын нийт хэмжээнээс 47% нь байгууллагын хог хаягдал бөгөөд 35% нь орлого ихтэй, томоохон ААН-тэй байгуулсан гэрээний дагуу цуглуулах хог хаягдлын хэмжээ байна. Баянзүрх, Сүхбаатар болон Баянгол ТҮК-ийн цуглуулах нийт хог хаягдлын 26%, 24% болон 22% тус тус орон сууцны хог хаягдал эзэлж тэдгээрийн цуглуулах гэр хорооллын хог хаягдлын хэмжээ нь харьцангуй бага байна, 9%, 7% ба 5% тус тус байна. Сүүхбатар дүүргийн хувьд гэр хорооллын хог хаягдал цуглуулдаггүй гэж байгаа боловч гэр хорооллын хог хаягдлын хэмжээ бага ч гэсэн байгаа нь сонирхол татаж байна.

Хүснэгт 3-37: 2004 онд хогийн төвлөрсөн цэгүүд дээр дарж булсан хог хаягдлын тухай мэдээлэл

Дүүрэг	Хог хаягдлын төрөл										
	Орон сууц		Гэр хороолол		Байгууллага		Зам цэвэрлэгээ		Бусад 1.		Нийт
	м3	Дүүргийн %	м3	Дүүргийн %	м3	Дүүргийн %	м3	Дүүргийн %	м3	Дүүргийн %	
Сонгинохайрхан	15,489	15.0%	73,640	71.4%	7,502	7.3%	4,034	3.9%	2,448	2.4%	103,113
Баянгол	31,466	53.6%	7,821	13.3%	15,314	26.1%	4,141	7.0%		0.0%	58,742
Сүхбаатар	34,431	63.1%	9,931	18.2%	6,523	12.0%	3,210	5.9%	440	0.8%	54,535
Чингэлтэй	14,413	33.6%	22,873	53.2%	1,741	4.1%	3,608	8.4%	324	0.8%	42,959
Баянзүрх	37,722	58.1%	13,083	20.2%	11,329	17.5%	2,770	4.3%		0.0%	64,904
Хан-Уул	9,936	20.3%	15,255	31.2%	22,950	47.0%	399	0.8%	334	0.7%	48,874
Нийт	143,457	38.4%	142,603	38.2%	65,359	17.5%	18,162	4.9%	3,546	1.0%	373,127

1. "Бусад" төрлийн хог хаягдал нь лаг болон гол, суваг шуудууны хаягдал

d. Аюултай хог хаягдал

Хортой хог хаягдал хянах Монгол Улсын техник технологийн болон боловсон хүчний чадавхи хязгаарлагдмал, менежмент нь сул хэвээр байсаар байна. Нийт үүсэх хортой хог хаягдлын 20% (Дэлхийн банк, *Монгол Улсын байгаль орчны хяналт 2004*) стандартын бус байгууламжинд, бас 20% нь ил задгай байдалтай хадгалагдаж байна. Түүнчлэн аж үйлдвэр, аюултай эсвэл хортой хог хаягдлын бүртгэл тооллого, агаарын дээжийн дүн шинжилгээ болон хогийн төвлөрсөн цэгийг газар дээр нь очиж байдалтай танилцах зэрэг ажлууд хийгдэхгүй байна. Ус болон хөрсний болзошгүй бохирдол эрчимчэж байгаа талаар үзэл бодол нэмэгдэж байгаа юм байна.

Эмнэлгийн халдвартай хог хаягдлыг хаяхаас нь өмнө халдваргүйжүүлдэг бөгөөд хогийн төвлөрсөн цэг дээр эмнэлгийн хог хаягдлыг цэг байх ёстой юм байна. Шинээр бий болж буй эмнэлгийн үйл ажиллагааг одоогоор найдвартай хянахгүй байна. Энэхүү асуудлаар баримтлах Эрүүл мэндийн яамны гол зарчмын асуудал бол томоохон шатаах зуух барих уу эсвэл байгаль орчинд халгүй эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах / хаях автоклав байгуулах гэдэг асуудал дээр байгаа юм байна.

e. Бохир ус

ТҮК-ийн үндсэн үзүүлэлт гэсэн асуулга судалгаагаар тэдгээрийн цуглуулж тээвэрлэх нийт хог хаягдлын 13%-ийг бохир тээвэрлэх асуудал эзэлдэг бөгөөд ихэнх нь гэр хорооллын бохир байдаг байна. Нийтийн аж ахуйг сайжруулах-2 төслийн өрхийн судалгаагаар гэр хорооллын нэг хашааны айлын ухсан жорлон дунджаар 5 жилийн хугацаанд (хамгийн доод хугацаа 3.7 жил, хамгийн дээд хугацаа 9.8 жил) ашиглагдах бөгөөд жорлон дүүрсний дараа нийт гэр хорооллын өрхийн 81.5% нь шинэ нүх ухаж жорлон байгуулдаг гэсэн бол 12.3% нь бохирын зориулалтын машин ашиглаж соруулуулдаг байна. 76.6% нь шинэ жорлон ухах газартай гэж байсан бол явандаа ашиглах боломжтой газар гэр хорооллын тухайн нэг хашаанд багасах хандлагатай байх тул ирээдүйд хатуу хог хаягдал болон эрүүл мэнд, ариун цэврийн салбарын шийдвэрлэх нэлээд томоохон асуудлыг нэг болно.

Гэр хорооллын бүсэд байрлах, бохирын шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцны барилга байшингийн бохирын асуудал нэлээд ноцтой нийтийн эрүүл мэндийн асуудал болсон байна. Тэдгээр барилга байгууламжийн нийтийн бие засах газар нь ариун цэврийн шаардлага хангахгүй, үл хайхрагдсан байдалтай, заримдаа огт байдаггүй тул иргэд нь ойролцоох гуу жалга, дов ашиглаж бие засдаг бөгөөд улмаар нохой зэрэг мал амьтнаар дамжин буцаж оршин суух бүсэд орж ирдэг байна.

Газар доорх бохирын шугам сүлжээг гэр хорооллын бүсэд сунгаж суурилуулах төлөвлөгөө хотод огт байхгүй, хувийн болон нийтийн тусгай сан байхгүй тул энэхүү

асуудал яваандаа хүндэрч хариуцах эзэнгүй болж хатуу хог хаягдлын менежмент нь УСАГ-тай хамтран хариуцан шийдвэрлэх болзошгүй.

f. Анги́лын ялгах ба дахин ашиглах

Бага хурлын I.2 дугаар асуудлаар *Хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр нь ангилан ялгадаггүй тул гарах хэмжээ нь дэндүү их байна* гэжээ. Цэнэглэх зай батарей болон автомашины тос масл зэрэг аюултай хог хаягдлыг оролцуулан анхан шатны дахин ашиглалт, рисайкл үйл ажиллагаа хийгддэггүй байна. Монгол хүний хоол хүнсний онцлог байдлаас шалтгаалан нэг хүн жилд 1.5 хонь болон 1/4 үхрийн мах хүнсэндээ хэрэглэж бусад улс орнуудтай харьцуулахад нэлээд их хэмжээний яс болон бусад мал амьтны гаралтай хог хаягдал гаргадаг байна. Ландфи́лын технологи нь агаарын орчингүй технологи байдаг тул тэрхүү нөхцөлд метан хий гарч улмаар агаар мандалд хүлэмжийн хий ялгаруулдаг байна. Түүнчлэн ясны хаягдал нь ландфи́лын үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг байна. Хүнсний хог хаягдал нь хөрсний хучилтын доор ялзарж, метан хий гаргаж, улмаар хогийн цэг дээр гал, утаа гарч агаарыг бохирдуулан цэгийн ажилчид, хог түүгчид, ойр орчим амьдрах оршин суугчидад аюул учруулдаг байна. Нийтийн аж ахуйг сайжруулах-1 төслийн судалгааны хүрээнд 1995 онд гэр хорооллын өрхүүдийн 2/3 нь яс болон хаягдал түхий эдийг идэвхтэй ангилан ялгадаг байжээ

Яс ашиглан бордоо болон бусад хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төрийн өмчит үйлдвэр ажиллаж байсан бол одоогоор цөөн хэдэн тахианы аж ахуйгаас өөр энэхүү их хэмжээний био бүтээгдэхүүний хэрэглээ байхгүй байна. Дээрх үйлдвэр одооч байдаг боловч тоног төхөөрөмж нь ажилгаагүй болжээ. Зарим хүмүүс яс боловсруулах үйлдвэрлэлд бага хэмжээний хөрөнгө оруулалт хийхэд яс гэдэг энэхүү үнэ цэнэтэй дахин ашиглах боломжит түүхий эдийг зах зээлд үр өгөөжтэй ашиглах боломж нь байгаа гэж үзэж байна. Ерөнхийдөө энэхүү тайлангийн 3.3.1.e-г хэсэгт дурьдсан хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах асуудлыг байгуулах; Бага хурлын I.5 дугаар асуудлаар *Албан бус хог түүгч нар хяналтгүй, зохицуулалтгүй асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулах шаардлагтай; хатуу хог хаягдлын менежментийг сайжруулахад ТББ нь чухал бүрэлдэхүүн хэсэг* болгож ашиглах зэрэг асуудал дээр тулгуурлан ТҮК-ийн захирлууд ангилан ялгасан хог хаягдлыг тусад нь цуглуулах, худалдаж авах болон хог хаягдлыг эх үүсвэр дээрээ ангилан ялгалт хийх өрхүүдийн сарын хураамжийг хөнгөлөх арга хэмжээ авч болно гэж илэрхийлжээ.

g. Шалгалт

Хатуу хог хаягдлын хяналт шалгалт бүх шатны түвшинд байдаг боловч тэдгээр нь одоогоор хууль бус хог хаягдлыг хянахад хангалтгүй байна. Дүүргийн тохижилт үйлчилгээний хэлтэст хатуу хог хаягдлын менежмент болон бусад байгаль орчны асуудлыг хуулийн дагуу хариуцах нэг л орон тоо байдаг боловч амьдрал дээр хогны асуудал тухайн хэлтсийн нэлээд том асуудал бөгөөд их бага хэмжээгээр хэлтсийн ихэнх ажилтан нар оролцож хамрагддаг. Засгийн газрын захиргааны шатлалын энэхүү түвшинд байгаль орчны холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангаж, зөрчил гаргаж буй этгээдийн эсрэг авах доривтой торгууль, шийтгэлийн тогтолцоо нь хангалтгүй байна. Түүнчлэн Улсын мэгэжлийн хяналтын газрын хяналт ч хангалтгүй байдаг гэж үздэг байна. Жилдээ цөөн хэдэн торгууль шийтгэлийг хувь хүн, иргэн, хатуу хог хаягдлын дүрэм журмыг зөрчигч этгээдэд буй байгууллага, ААН ногдуулдаг боловч торгуулийн хэмжээ нь эдийн засгийн үр дүнтэй арга хэмжээ болохуйц арга хэмжээ биш байна.

Бага хурлын I. 6. дугаар асуудлаар *Мэргэжлийн хяналтын газар нь хууль зөрчиж буй өрх эсвэл байгууллага бус ТҮК-ийг буруу үйл ажиллагаанаас болсон гэж ТҮК-ийг торгодог гэж тодорхойлж хорооны засаг дарга доод тал нь нэг байцагчтай байх шаардлагатай гэж санал гаргав.* Зарим Засгийн газрын албан тушаалтангууд Улсын мэргэжлийн хяналтын газрыг бэхжүүлэх эсвэл дүүргийн орон тоог 5-6 байцагчаар, 3-4 хорооны дунд нэг байцагч ажиллуулах замаар орон нутгийн засаг захиргааг бэхжүүлж үйлдвэрлэл болон хууль бус хог хаягдлыг хянах эрхийг олгох шаардлагатай гэж үзэж байна. Зарим ТҮК-д хууль журам зөрчиж буй этгээдийг торгох, шийтгэх эрхийг олгох нь зүйтэй гэж үзэж байна. Бага хурлын I. 11. дүгээр асуудлаар *Хяналт болон шалгах эрх үүргийг ТҮК болон иргэдэд шилжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлжээ. Түүнчлэн дүүргийн хяналтын эрх бүхий байгууллага нь ТҮК-ийн ажилтан томилон хяналтыг гүйцэтгүүлэх; хяналтын ажилд дүүргийг бодвол ТҮК нь илүү үр дүнтэй гэж үзэх хүмүүс ч байна.* Коммунизмын үед “гудамжны эргүүл” буюу нийгмийн хэв журмаас гадна хог хаягдлаа хууль бусаар хаяж буй айл өрхийг хянаж тэдгээрийг холбогдох газарт нь мэдээллэх зэрэг ажлыг хийдэг байжээ. Хог хаягдлын хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор энэхүү системийг буцааж сэргээх санал ч гарч байв. Жишээлбэл, тухайн гудамж эсвэл хэсгийн нутаг дэвсгэр дээр хатуу хог хаягдлын нөхцөл байдлыг хянах зорилгоор сайн дурын эсвэл бага зэргийн урамшуулал олгож зарим иргэдийг томилон ажиллуулж улмаар аливаа зөрчил илэрхэд тэдгээр нь хорооны Засаг дарга, ТҮК эсвэл мэргэжлийн хяналтын газрын холбогдох албан тушаалтан нарт мэдээллэх гэсэн хэлбэртэй байна. Гэхдээ эдгээр арга хэмжээ ардчилсан нийгэмд дэндүү захиргаадалтын шинж чанартай, төвөгтэй байх асуудал гэж үзнэ.

Холбогдох хяналт шалгалтыг хийж байх шаардлагатай боловч шат шатны түвшинд хяналт зохицуулалт хийх нь тэрхүү хяналтын тогтолцоо нь ажиллахгүй, үр дүн муутай болсоны илэрхийлэл юм. Үр дүн, өгөөжтэй хяналтын тогтолцоо нь маш энгийн байдаг. Иймд хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай байна гэж олон дуу хоолой гарч байгаа нь тэрхүү тогтолцоо ажиллахгүй болсоны шинж тэмдэг бөгөөд шууд хяналтын байгууллагын эрх мэдэл, орон тоог нэмэгдүүлэх бус өнөөгийн өдөр тутмын хог хаягдал цуглуулах, тээвэрлэх тогтолцоогоо сайжруулах нь зүйтэй. Үүнээс гадна, одоогоор нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих асуудал бол хогийн төвлөрсөн цэг рүү хог хаягдал тээвэрлэж булаах ажилтай холбогдож гарах зардлаас зайлсхийх барилга болон бусад ААН-ийн нэлээд их хэмжээний хууль бус хог хаягдлыг хүчтэй хянах зүйтэй. Одоогоор тэрхүү хяналтыг тавих эрх нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх хамгийн тохиромжтой захиргааны нэгж байхын сацуу шаардлагатай бол эрх үүргийг нэмэгдүүлж болох юм.

h. Санхүү

Бага хурлын h.2 дугаар асуудлаар *Гэр хорооллын иргэд төлбөр төлөх чадваргүй байдаг тул хогны төлбөрийг бүрэн гүйцэд хураадаггүй, болон иргэд оришин суугчидын хаяг бүртгэл бүрэн буй байдаг тул хогны төлбөр төлүүлэх арга хэмжээг шаардагдах түвшинд авдаггүй. Хатуу хог хаягдлын төлбөр 1999 оны түвшинд хэвээр байгаа бөгөөд хогны төлбөр хураалтын хувь хэмжээ дөнгөж 30-40%-тай байна. Иймд хогны төлбөр цуглуулах системийг ерөнхий татварын тогтолцооны хүрээнд ч юмуу өөрчлөх цаг болсон гэжээ.* ТҮК-ийн менежментийн хувьчлалын дараа гэр хороололд үзүүлэх хатуу хог хаягдлын үйлчилгээ доройтсон. Хогны төлбөр төлөлтийн хувь хэмжээ бага байдаг тул аливаа байгууллага нь гэр хорооллын бүсэд үйлчилгээ үзүүлэх сонирхолгүй болж зах зээл нь бий болоогүй тул өрсөлдөөн байх үндэс суурь тавигдахгүй байна. ТҮК-ийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн тухай судалгааны хүрээнд цуглуулсан мэдээллийн дагуу 2004 онд нийт таван ТҮК-ийн гурван ТҮК-ийн

үйлчилгээ үзүүлдэг гэр хорооллын өрх сард дунджаар 200 төгрөгөөс бага төлбөр төлсөн бол Хан-Уул ТҮК-д 2,600 төгрөг байсан. Судалгааны олон нийтийн санал асуулгын дагуу гэр хорооллын өрхийн дундаж хогны төлбөр сард 1,745 төгрөг байна гэж тодорхойлсон боловч хогны төлбөрийг төлөх чадвартай өрхөөс төлбөр хураах хувь хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй: одоогоор гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг хашааныхан хаалганаас цуглуулахад шууд төлбөрөө төлөхгүй байгаа юм чинь оршин суугчид хогоо гаргаж хаядаг нийтийн хогны контейнер систем ашиглахад хогны төлбөр хураах хувь хэмжээ бүр ч багасах болно. Хаалганаас хаалга гэсэн хэлбэрийн хог хаягдал цуглуулах тогтолцоог ажиллуулахад нэлээд зардал ихтэй болно.

Бага хурлын I.4. дүгэр асуудлаар *Санхүү хөрөнгөний хүндрэл бэрхшээлээс болоод хог хаягдлыг хангалттай дарж булахад хүрэлцэхгүй байна* гэж тодорхойлсон нь энэхүү салбарын нийт хэмжээнд санхүү мөнгөний асуудал шийдвэрлэхэд хамгийн хэцүү асуудал болсон бөгөөд сүүлийн 15 жилийн хугацаанд энэхүү асуудлыг амжилттай шийдвэрлэгдээгүй байна. Жишээлбэл, 1995 онд гэр хорооллын хогны төлбөр 140 төгрөг байсан бол тэрхүү хэмжээ 2004 оны байдлаар 370 төгрөг болох байжээ. 1995 оны хогны төлбөрийн хэмжээ тогтвортой байсан бололтой. Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах-1 төслийн ТЭЗҮ-гийн хүрээнд судалгаа хийхэд ТҮК, ялангуяа Хан-Уул, Сонгинохайрхан болон Нөөц компани зэрэг нь 1994 онд орлого нь 23.1 сая, зарлага нь 22.8 сая төгрөгийн эргэлттэй байж тэр үед номинал ашигтай ажиллаж байсан боловч элэгдэл хорогдлын тооцоо хийж байсан нь эргэлзээтэй.

Хатуу хог хаягдлын салбарт нэмэлт санхүүжилт оруулахаас өмнө нь энэхүү салбар нь хамгийн үр өгөөжтэй хэлбэрээр ажиллаж байгааг баталгаажуулах шаардлагатай – судалгааны дүнд салбар нь санхүүгийн хувьд хамаагүй эрүүл, нэмэлт хөрөнгө санхүүжилт шаардлаггүй байж ч болох юм. Бусад хөгжиж буй орнуудын хатуу хог хаягдлын менежментийн салбартай харьцуулахад Улаанбаатар хотын энэхүү салбарын санхүүгийн зохицуулалт нь илүү үр өгөөжтэй, үл төвлөрсөн, үйлчлүүлэгчидтэй шууд харилцхх холбоотой байгаа нь харагдаж байна. Санхүүгийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх нэг гарц бол хуулинд тусгагдсан байгаа хог хаягдлын үйлчилгээний сан байгуулах асуудал юм (Бага хурлын h.1 дугаар асуудал). Үйлчилгээний сан хотын хэмжээнд байгуулах уу эсвэл дүүргийн хэмжээнд үү гэдэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх нь дүүргийг үйл ажиллагаа боловч хогийн төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хотын хэмжээнд ажиллуулж байна. Иймд Нөөц компанийн өнөөгийн санхүүгийн хүндрэлтэй асуудал нь хотын захиргаа нь нийслэлийн иргэдэд нийтийн аж ахуйн үйлчилгээний үнэ өртгийг аль болох хамгийн доод түвшинд байлгах асуудалтай холбоотой байж болох юм. Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах-1 болон 2 дугаар төслийн хэрэгжилтийн турш хэрэглээний усны үнийг Хотын захиргаанаас нэмэх сонирхолгүй байсан нь төслийн хэрэгжилтэд асуудал болж байсан байна. Хог хаягдлын менежментийн салбарын санхүүгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор одоогоор хог хаягдлын менежментийн асуудал дүүрэг дээр байгаа тул үйлчилгээний сангийн үйл ажиллагааг дүүргийн Засаг даргын түвшинд, түүний хяналтанд байлгаж хогийн төвлөрсөн цэгийн зардлыг үйлчилгээний санд хотын төсвөөс, дүүргээс, эсвэл шууд хэрэглэгчээс төлөх гэсэн хэлбэрийг сонгож болох юм. Улмаар Нөөц нь дүүрэг дүүргээр хүлээн авсан хог хаягдлын хэмжээ болон бусад гэрээгээр авсан хог хаягдлын хэмжээн дээр үндэслэн үйлчилгээний сангаас дарж булсан зардлаа авч болох боловч одоогоор гэрээгээр үйлчлэх нь тэр болгон хангалттай хэрэгжихгүй, хог хаягдал дарж булах газраа ирэхгүй байх явдал гарч байна. ТҮК нь хогны төлбөр хурааж үйлчилгээний санд шилжүүлээд дараа нь буцааж зардлаа авах гэсэн нэмэлт шат дамжлаг гаргах нь ач холбогдолгүй нь ойлгомжтой байна.